

РЕДАКЦИН ЗӨВЛӨЛ

EDITOR'S BOARD

Дарга

Др. Бямбасүрэнгийн Энхбайгаль

Chairman

Byambasuren Enkhbaigali. Ph.D

Нарийн бичгийн дарга

Др. Доржраагийн Мөнхтөр

Secretary

Dorjraa Munkhtur Ph.D

Гишүүд

Др. пр Жамъянгийн Батсуурь

Гунгаагийн Базарваань

Дашхүүгийн Батмөнх

Др. Эрдэнэ-Очирын Энхмаа

Members

Jamiyan Batsuuri Ph.D

Gungaa Bazarvaani

Batmunkh Dashkhuu

Erdene-Ochir Enkhmaa Ph.D

Редакцын хаяг:

Самбуугийн гудамж 11, Засгийн газрын-11,
8 давхар

Board Address:

8th floor, Government Building-11,
Sambuu Str. 11

Утас: (976-51)264000

Факс: (976-11)324055

Tel: (976-51)264000

Fax: (976-11)324055

Шуудангийн хаяг:

Монгол Улс, Улаабаатар Төв шуудан-870

Postal Address:

Central Post Office 870 Ulaanbaatar

Захиалгын индекс:

200952

Subscription index:

200952


Цахим хуудас: www.iss.gov.mn

АГУУЛГА

CONTENT

А.Түвшинтөгс Орос, хятадын стратегийн түншлэлийн талаарх Хятадын зарим судлаачийн үзэл, хандлага	4	A.Tuvshintugs (Ph.D) The Sino-Russian Strategic Partnership: Views from Beijing
Н.Соёлгэрэл Хятадын өсөлтийн түшиц: Төв Ази дахь эдийн засаг, Эрчим хүчний хамтын ажиллагаа	12	N.Soyolgerel (M.A) The Influence of Chinese growth on Central Asia: Economic and energy cooperation
Ч.Нарантуяа Евразийн эдийн засгийн холбооны өнөөгийн байдал, хэтийн төлөв	21	Ch.Narantuya (M.A) The current situation and perspectives of Euroasian Union
Д.Уламбаяр Хойд Солонгосын шинэ аюул ба НҮБ-ын шинэ хориг	31	D.Ulambayar (Ph.D, Professor) A new threat of North Korea and the UN's new sanctions
Л.Бямбаханд НАТО-гийн түншлэлийн хэлбэрүүд, Монгол-НАТО-гийн харилцаа	38	L.Byambakhand (M.A) NATO's partnership formats and Mongolia-NATO relations
М. Эрдэнэбаяр Парламентын засаглалд тулгарч буй сорилт	45	M.Erdenebayar (Ph.D) Challenges to Mongolia's parliamentary system
Х.Номинболор Орчны бохирдол, хүн амын аюулгүй байдалд учруулах эрсдэл	51	Kh.Nominbolor (M.E) Environmental pollution and a threat to human security
Э.Энхмаа Ж.Батсуурь Монгол Улсын хүн амын орон зайн байршил ба нягтралын газарзүйн тархалтын өнөөгийн байдал	61	E.Enkhmaa (Ph.D) J.Batsuuri (Sc.D) Present situation of the geographical location and density of the Mongolian populationwledge management in the public sector

С.Алтанчимэг	S.Altanchimeg (M.A)
Мэдлэгийн менежмент төрийн бодлогын залгамж чанарт нөлөөлөх нь	66 Knowledge management in the public sector
Б.Эрдэнэбат	B.Erdenebat
Зэвсэглэл, байлдааны техникийн хангалт бол Зэвсэгт хүчний байгуулалтын чухал асуудал мөн	71 The supply of military equipment and armaments is the main issiu for strengthening Armed Forces
Зохиогчид	77 Authors



А. ТҮВШИНТӨГС (Ph.D.)

ОРОС, ХЯТАДЫН СТРАТЕГИЙН ТҮНШЛЭЛИЙН ТАЛААРХ ХЯТАДЫН ЗАРИМ СУДЛААЧИЙН ҮЗЭЛ, ХАНДЛАГА

In the recent years Chinese scholars actively studied at the various universities of Russian Federation on the subject related to the strategic partnership relations between Russian Federation and People's Republic of China in the dissertation level from the field of political, economic, historical, sociological, philological and pedagogical sciences. This article shows a review of the main results, conclusions and proposals some of above mentioned Chinese academics.

ОРШИЛ

БНХАУ-ын удирдлага ОХУ-тай хөгжүүлж буй харилцаа, хамтын ажиллагаа, тухайлан стратегийн түншлэлийн асуудлыг гүнзгийрүүлэн судлахад онцгой анхаарч, олон тооны судлаачдыг оросын их сургуулиудын докторантурт зорилго чиглэлтэй илгээж байна. Тухайлбал, XX зуун гарснаас хойш улс төр,¹ эдийн засаг,² түүх,³ сурган

¹ Цуй Чжэн. Научно-техническое сотрудничество РФ и КНР в контексте инновационного развития стран БРИКС. Диссертация на соискание ученой степени кандидата политических наук. Московский государственный университет им. М.В.Ломоносова. Москва, 2015. - 229 с.

² Цзян Фэн. Государственное регулирование внешней торговли Китая. Диссертация на соискание ученой степени кандидата экономических наук. Московский государственный университет им. М.В.Ломоносова. Москва, 2014. - 185 с.

³ Синь Жэнь. Российско-китайское приграничное и межрегиональное сотрудничество на современном этапе (2001-2011 гг.). Диссертация на соискание ученой степени кандидата исторических наук. Московский государственный институт (Университет) международных отношений МИД России. Москва, 2014. - 169 с.

хүмүүжүүлэх,⁴ хэл шинжлэл,⁵ социологи⁶ зэрэг төрөл бүрийн чиглэлээр 24 хятад судлаач ОХУ-д докторын зэрэг хамгаалсны 70 хувь нь зөвхөн сүүлийн 4 жилд ногдож байна (Бүтэн жагсаалтыг хавсралтаас үзнэ үү). Энэхүү өгүүлэлд хятадын зарим эрдэмтний сонирхолтой дүгнэлт, саналыг тоймлон танилцуулж байна.

ХЯТАД СУДЛААЧДЫН ҮЗЭЛ ХАНДЛАГА

Судлаач Чжэн Ци ОХУ-ын Санкт-Петербургийн улсын их сургуульд “Орчин үеийн Орос, Хятадын харилцаанд цэрэг-техникийн хамтын ажиллагааны улс төрийн гүйцэтгэх үүрэг”⁷ сэдвээр улс төр судлалын ухааны докторын зэрэг хамгаалсан бүтээлдээ Орос, Хятадын орчин цагийн цэрэг-техникийн хамтын ажиллагааг улс төр, эрх зүйн хүрээнд судалж дараах дүгнэлт хийсэн байна.

1. Орос, Хятадын стратегийн нийтлэг ашиг сонирхол бол харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлж, Азид АНУ

⁴ Яо Вэй. Подготовка специалистов вокального искусства в системах высшего музыкального образования Китая и России. Диссертация на соискание ученой степени кандидата педагогических наук. Астраханский государственный университет. Астрахань, 2015. - 196 с.

⁵ Шао Дэвань. Отражение российско-китайских отношений в русскоязычных СМИ КНР 2006-2016 гг. Диссертация на соискание ученой степени кандидата филологических наук. Российский университет дружбы народов. Москва, 2017. - 159 с.

⁶ Дин И. Роль высших органов государственной власти в формировании политической стабильности в обществе: сравнительный анализ Китая и России. Диссертация на соискание ученой степени кандидата социологических наук. Санкт-Петербургский государственный университет. Санкт-Петербург, 2016. - 219 с.

⁷ Чжэн Ци. Политическая роль военно-технического сотрудничества в современных российско-китайских отношениях. Автореферат диссертации на соискание ученой степени кандидата политических наук. Санкт-Петербургский государственный университет. Санкт-Петербург, 2010. - 20 с.

цэргийн хүчээ зузаатгах, нөлөөгөө тэлэх явдлыг хязгаарлах, дэлхийн олон туйлт тогтолцоо бүрэлдэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино. Энэ нь хоёр улсын цэрэг-техникийн хамтын ажиллагааны үндэс суурь болно.

2. Орос, Хятадын цэрэг-техникийн хамтын ажиллагааны агуулгад гарч буй өөрчлөлтөд улс төр, эдийн засгийн хүчин зүйл нөлөөлж байна. Тухайлбал, Хятадын хувьд үндэсний цогц хүчин чадавхыг бэхжүүлэх, гадаадын технологи, эд ангиас үл хамаарсан өөрийн цэрэг-аж үйлдвэрийн цогцолборыг хөгжүүлэх явдал улс төрийн нэн тэргүүний зорилт юм.

3. ОХУ-ын хувьд Хятадтай хөгжүүлж буй цэрэг-техникийн хамтын ажиллагаа хоёрдмол үр дагавартай. Нэг талаас уг хамтын ажиллагаа нь эдийн засаг ба цэргийн аж үйлдвэрийн хөгжилд дэмжлэг болохоос гадна ОХУ-ын АНДБН чиглэсэн дипломат ажиллагаанд ч түлхэц болдог. Нөгөө талаас ШХАБ, Төв Азийн хуучин Бүгд Найрамдах улсууд болон Алс Дорнодын асуудлаар ОХУ, БНХАУ-ын хоорондын зөрчил хурцадсан тохиолдолд сөрөг үр дагавар авчрах болно.

4. Орос, Хятадын цэрэг-техникийн хамтын ажиллагаа Ази Номхон Далайн Бүс Нутгийн аюулгүй байдалд ихээхэн нөлөөтэй. Энэ нь зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг хөтлөхийн зэрэгцээ Хятад, Тайваний харилцааг хурцатгах уршигтай.

5. АНУ, ЕХ-ноос үзүүлж буй улс төрийн дарамт шахалт болон цэргийн техник нийлүүлэлтэд тавьсан хориг үргэлжилж буй нөхцөлд Оростой хөгжүүлж буй цэрэг-техникийн хамтын ажиллагаа Хятадын хувьд Зэвсэгт хүчин, цэрэг-аж үйлдвэрийн цогцолбороо шинэчлэх цорын ганц үр өгөөжтэй арга зам мөн.

6. Орос, Хятадын стратегийн нийтлэг ашиг сонирхол нэг туйлт дэлхийн тогтолцоо бүрдүүлэх хандлагыг зогсоох,

АНУ-ын Ази дахь цэргийн оролцооны тэлэлтийг хаах, хоёр талын харилцааг сайжруулах, түүнчлэн хамтын ажиллагаа, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бүс нутгийн байгууллагыг хөгжүүлэх чиглэлд давхцдаг. Гэхдээ Алс Дорнодын бүс нутаг, ШХАБ-ын хөгжлийн хэтийн төлөв, Төв Ази дахь эрчим хүчний бодлогын хувьд ОХУ, БНХАУ-ын ашиг сонирхол ялгаатай байдаг.

7. Хятадын удирдлага үндэсний аюулгүй байдалд халгаатай, мөргөлдөөнд хүргэж болзошгүй нөхцөл байдлаас сэргийлж хршүүдтэй харилцаагаа сайжруулах замаар цэргийн шууд нүүрлэх болзошгүй аюулыг сааруулахыг зорьж байгаа. Гэвч бүс нутгийн аюулгүй байдлын тогтолцоог тогтворгүйжүүлэх хүчин зүйлс оршин байгаа явдлыг БНХАУ-ын үндэсний аюулгүй байдалд учрах аюул гэж үзнэ. Санаа зовоож буй гол асуудал бол их гүрнүүд хоорондоо болон БНХАУ-тай хөрш хиллэдэг улстай холбоотны харилцаа тогтоож болзошгүй явдал юм. Энд нэн тэргүүнд Ази дахь АНУ-ын бодлогыг нэрлэж болно. Түүнээс гадна БНХАУ хөрш улсуудтай газар нутгийн болон усан хилийн талаар маргаантай асуудлаа шийдвэрлэж чадаагүй нөхцөл байдал мөн тогтворгүйжүүлэх хүчин зүйл болдог.

8. ОХУ, БНХАУ-ын цэрэг-техникийн хамтын ажиллагаа цэргийн зэвсэг, байлдааны техник нийлүүлэх, Хятад өөрийн хүчээр үйлдвэрлэлээ явуулахад шаардлагатай лиценз худалдаж авах, хамтарсан үйлдвэрлэл эрхлэх зэрэг гурван үндсэн чиглэлээр хөгжиж иржээ. Хамтын ажиллагааны дүнд Хятадын Зэвсэгт хүчний чадавх болон туршилт, зохион бүтээх ажлын түвшин дээшилсэн болно.

Судлаач Чу Лин ОХУ-ын Санкт-Петербургийн санхүү, эдийн засгийн улсын их сургуульд “ОХУ, БНХАУ-ын эрчим хүчний салбарын хамтын ажиллагааны

улс төр, эдийн засгийн хүчин зүйл”⁸ сэдвээр 2015 онд улс төр судлалын ухааны докторын зэрэг хамгаалжээ.

Энэхүү бүтээлдээ судлаач ОХУ, БНХАУ-ын эрчим хүчний салбарын хамтын ажиллагааны үечлэл⁹, хууль, эрх зүйн үндэс, эрчим хүчний талаар баримталж буй хоёр улсын бодлогын харьцуулалт, эрчим хүчний хамтын ажиллагаанд оршиж буй асуудал, хамтын ажиллагааны улс төр, эдийн засгийн үнэлгээ, хэтийн төлөв зэрэг асуудлыг хамран шинжилжээ. Тэрээр бүтээлдээ ОХУ, БНХАУ-ын эрчим хүчний хамтын ажиллагаанд дор дурдсан хүндрэлтэй асуудал¹⁰ байгааг тодорхойлжээ. Үүнд:

1. ОХУ, БНХАУ-ын хооронд эрчим хүчний салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх урт хугацааны нэгдсэн хөтөлбөр үгүй. Оросын Засгийн газар үндэсний ашиг сонирхлыг дээд зэргээр хамгаалах зарчмыг хатуу баримталдаг.

2. Эрчим хүчний хамтын ажиллагааны салбарт ОХУ, БНХАУ-ын хооронд итгэлцэл үгүй. ОХУ, БНХАУ өөр өөрийн геополитикийн ашиг сонирхол бүхий их гүрнүүд учир зөвхөн түншүүд бус, мөн өрсөлдөгчид юм.

3. Эрчим хүчний зах зээлийн гадаад өрсөлдөгчид. Олон улсын нөхцөл байдал, гадаад өрсөлдөгчид болон байгалийн хийн үнийн асуудал нь Орос, Хятадын байгалийн хийн салбарын эрчим хүчний урт хугацааны хамтын ажиллагааны гол саад болж байна.

⁸ Чу Лин. Политические и экономические аспекты сотрудничества между КНР и РФ в сфере энергетики. Диссертация на соискание ученой степени кандидата политических наук. Санкт-Петербургский государственный университет экономики и финансов. Санкт-Петербург, 2015. -147с.

⁹ Судлаач ОХУ, БНХАУ-ын эрчим хүчний хамтын ажиллагааг 1-р үе: 1992-1999 он Ельцин үе, 2-р үе: 2000-2008 Путин үе, 3-р үе: 2008-2012 Медведев үе, 4-р үе: 2013 оноос Путин шинэ үе хэмээн 4 үе шат болгон ангилсан байна.

¹⁰ Мөн тэнд: стр. 83-92.

4. Байгалийн хийн үнэ тогтоох асуудал. Эрчим хүчний хамтын ажиллагааг жигдрүүлэн хэвшүүлэх, ОХУ, БНХАУ-ын хооронд эрчим хүчний нөөц нийлүүлэлтийн гэрээ байгуулахад үнэ нэн тэргүүний ач холбогдолтой. Хятадууд Оросоос нийлүүлэх байгалийн хийг зах зээлийн үнээс хямд авах сонирхолтой. Тухайлбал, мянган куб метр хийг 235 ам.доллар /250-аас илүүгүй/, оросууд 350 ам.доллар гэдэг. Харилцан ашигтай, хоёр талын ашиг хонжооны талаар ойлголт үндсэндээ алга байна. Эрчим хүчний нөөцөө өндөр үнээр өгнө гэсэн нийлүүлэгчийн төсөөлөл Орос, Хятадын харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэхэд саад болж байна.

5. Шинэ төрлийн эрчим хүчний салбарт ОХУ, БНХАУ-ын хооронд инновацийн хамтын ажиллагаа байхгүй.

6. ОХУ, БНХАУ-ын ашиг сонирхлын зөрчил зэргийг онцолсон байна.

Эдгээр саад бэрхшээлийг арилгах талаар судлаач дараах дүгнэлт хийж, санал дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Оршиж буй саад бэрхшээлийг шийдвэрлэхэд Орос, Хятад харилцан ашигтай, хоёулаа хожих үзэл санааг бэхжүүлэх, ялгаатай байр суурийг зөвхөн засгийн газрын зохицуулалтад тулгуурлахаас гадна зах зээлийн зарчмаар арилгах ёстой.

2. Эрчим хүчний нөөцийн худалдааг нэмэгдүүлэхээс гадна технологи, тоног төхөөрөмжийн чиглэлээр эрчим хүчний хамтын ажиллагааг харилцан ашигтай хөгжүүлэх нь чухал байна. Тухайлбал, түлш, эрчим хүчний салбарт Орос, Хятадын санхүү-эдийн засгийн бүлэглэлийг харилцан нэвтрүүлэх явдлыг хөхиүлэн дэмжих нь зарчмын ач холбогдолтой. Эрчим хүчний хамтын ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд хоёр талын бизнес бүлэглэлийн оролцооны хүрээг тэлэх шаардлагатай. Эрчим хүчний яриа

хэлэлцээнд зөвхөн төрийн өмчийнхөөс гадна хувийн корпорациудыг оруулах нь зүйтэй.

3. ОХУ, БНХАУ-ын Засгийн газрын улс төрийн түвшинд эрчим хүчний хамтын ажиллагааг хэрэгжүүлэх, үр өгөөжийг нэмэгдүүлэхүйц механизм бүрдүүлж, боловсронгуй болгох шаардлагатай. Тухайлбал, ОХУ-ын Засгийн газар орос, хятадын эрчим хүчний салбарын ирээдүйг харсан, өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлэх үндсийг тавих зорилгоор хятадын нутагт нефть олборлох төсөлд оросын эрчим хүчний компаниудын оролцох нөхцөлийг бүрдүүлэх ёстой. ОХУ, БНХАУ-ын хооронд 2008 онд байгуулагдсан эрчим хүчний нөөцийн талаарх яриа хэлэлцээний механизм нь эрчим хүчний хамтын ажиллагаанд түүхэн онцгой ач холбогдолтой явдал болсон.

4. Хятадын хувьд ойрын ирээдүйд тогтсон үнээр, найдвартай хангалт хийх нөхцөлтэйгээр 10 ба түүнээс дээш жилийн хугацаатай хэлэлцээр байгуулах явдал чухал юм. Харин алс хэтдээ түүхий нефтийн дэлхийн зах зээлд оролцогч нарт хатуу хяналт тавих механизм бүрдүүлэх нэн тэргүүний зорилт болж байна. Эрчим хүчний урт хугацааны тогтвортой, харилцан ашигтай стратегийн хамтын ажиллагаа хөгжүүлэх явдал хоёр талын стратегийн түншлэлийн түвшинг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

5. Орос, Хятадын эрчим хүчний салбарын хамтын ажиллагаа амжилттай хөгжихөд дараах гурван зүйлээс хамаарна. Үүнд: 1) Хамтын ажиллагаа хоёр талын ашиг сонирхолд тулгуурлах ёстой, 2) Эрчим хүчний хамтын ажиллагаа нь хүчирхэг стратегийн түншлэлд тулгуурлах ёстой 3) Хоёр улсын төрийн тэргүүн эрчим хүчний харилцаанд онцгой анхаарал тавьж, хөгжилд улс төрийн шийдвэртэй дэмжлэг үзүүлэх ёстой.

Судлаач Ван Цзуняо Оросын улс түмний найрамдлын их сургуульд “ОХУ, БНХАУ-ын эдийн засгийн хамтын ажиллагааны ирээдүйтэй чиглэл”¹¹ сэдвээр 2017 онд эдийн засгийн ухааны докторын зэрэг хамгаалжээ.

“Эдийн засаг “шинэ хэвийн байдал”-д шилжих үеийн Хятадын гадаад эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн эзлэх үүрэг, хэтийн төлөв” хэмээх нэгдүгээр бүлэгтээ Хятадын эдийн засаг “шинэ хэвийн байдал”-д шилжих бодлогын онол, практикийн хандлага, гадаад эдийн засгийн хөгжлийн стратеги боловсруулсан онцлог, Хятадын гадаад эдийн засгийн харилцаанд Оросын эзлэх байрыг шинжилж, дараах дүгнэлтийг хийжээ. Үүнд:

Хятадын эдийн засгийн өсөлтийн удаашралтыг “шинэ хэвийн байдал” гэж томъёолж байгаа бөгөөд худалдаа, хөрөнгө оруулалтад суурилсан эдийн засгийн загвараа дотоод хэрэглээнд тулгуурласан эдийн засгийн өсөлтийн загварт шилжих стратеги баримталж байна. Өөрөөр хэлбэл, “шинэ хэвийн байдал”-ын мөн чанар нь үйлдвэрлэлийн хүчин зүйлийг эрчимтэй ашиглах замаар эдийн засгийн хурдан өсөлтийг хангах бус чанартай хөгжил” гэж судлаач үзжээ.¹²

“Хятад, Оросын худалдаа, хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, бүтцийн өөрчлөлт” хэмээх 2 дугаар бүлэгт Хятад, Оросын худалдааны харилцааны үечлэл,¹³ хятад-оросын худалдааны харилцан хамаарал, хоёр талын эдийн засагт эзлэх

¹¹ Ван Цзуняо. Перспективные направления российско-китайского экономического сотрудничества на современном этапе. Диссертация на соискание ученой степени кандидата экономических наук. Российский университет дружбы народов. Москва, 2017. – 180 с.

¹² Мөн тэнд. х. 158.

¹³ Нэгдүгээр үе: 1992-1993, хоёрдугаар үе: 1994-1998, гуравдугаар үе: хурдан өсөлтийн үе 1999-2008, дөрөвдүгээр үе: бууралтын үе 2009-2010, тавдугаар үе: “шинэ хэвийн байдал”-ын эхний үе /2011 оноос өнөөг хүртэл/.

байр, ОХУ-аас БНХАУ-д болон БНХАУ-аас ОХУ-д нийлүүлж буй хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, хэмнэл, бүтэц, хоёр талын худалдаа, эдийн засгийн харилцаанд оршиж буй асуудлыг судалж дараах үнэлгээ дүгнэлтийг хийсэн байна.

1. Оросын эдийн засаг Хятадтай хийх худалдаанаас хамаарах хамаарал 1992-2015 онд тогтмол өсч ирсэн. Энд 2 онцлог зүйл байсан. 1-рт: эдийн засгийн томоохон хямрал бүрийн дараах Оросын эдийн засгийн Хятадтай хийх худалдаанаас хамаарах хамаарал улам бүр нэмэгдэж байсан. 2-рт: 2008 оны хямралын дараах хамаарал тасралтгүй өсч байхын зэрэгцээ ОХУ-ын эдийн засгийн гадаад худалдаанаас хамаарах хамаарал тасралтгүй буурсан.

2. Харин Хятадын эдийн засгийн ОХУ-тай хийх худалдаанаас хамаарах хамаарал мөн хоёр онцлогтой. Нэгдүгээрт: Оросын эдийн засгийн хөгжлийн түвшингээс шууд хамаарч байна. Оросын эдийн засгийн хөгжлийн түвшин дээшлэх бүр Хятадын хамаарал өссөн, Хоёрдугаарт: 2008 оны дараа Хятадын эдийн засгийн ОХУ-тай хийх худалдаанаас хамаарах хамаарал түүхэндээ хамгийн бага 0.36 хувь болохын зэрэгцээ ерөөсөө гадаад худалдаанаас хамаарах хамаарал ДХБ-д элссэнээс хойших түүхэн бага хэмжээнд 36.8 хувьд хүрчээ.

3. ОХУ-ын гадаад худалдаанд Хятадын эзлэх жин тогтмол өссөөр ирсэн. 2015 оны байдлаар БНХАУ оросын экспортод хоёр, импортод нэгдүгээр байр эзэлж байсан бол, ОХУ нь хятадын экспортод 15, импортод 10 дугаар байрт эрэмбэлэгдсэн байна.

4. Хоёр талын худалдааны өнөөгийн тэргүүлэх чиглэл нь нефть нийлүүлэлт боловч энэ нь урт хугацааны тогтвортой хөгжлийг хангаж чадахгүй. Иймээс эрчим хүчний чиглэлээрх Орос, Хятадын

суурь судалгааны түвшинг нэмэгдүүлэх, эрчим хүчийг хөгжүүлэх шинжлэх ухаан, технологийн гол асуудлыг шийдвэрлэх, эрчим хүчний шинэ нөөцийн чиглэлээр инновацийг хөгжүүлэх шаардлагатай. Үүний тулд хятад, оросын шинжлэх ухаан, технологийн жишиг загвар бүс байгуулах замаар хамтын ажиллагааны объектыг өргөжүүлж болно.

5. Хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалтын урт хугацааны хамтын ажиллагааны суурь болохуйц солонгорсон дэд бүтэц байгуулах нь онц чухал ач холбогдолтой. Иймээс эрчим хүч, авто болон төмөр замын тээврийн сүлжээ, сансар судлал, цахилгаан холбооны сүлжээ, дэд бүтцийн объектыг сайжруулах болон шинээр байгуулах зэрэг бүтээн байгуулалтын төслүүдийг дэмжих шаардлагатай. Энд Алс Дорнод, Сибирийн дэд бүтцэд зориулсан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь чухал ач холбогдолтой.

6. БНХАУ-ын эрчим хүчний аюулгүй байдал (АБ)-ын тулгамдсан асуудал нь: хангалтын АБ, үнэ тогтоолтын АБ, хэрэглэлтийн үеийн АБ, тээвэрлэлтийн АБ, түүнчлэн геологийн хайгуул, боловсруулалт, ашиглалтын АБ.

“Хятад, Оросын эдийн засгийн хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл, хэтийн төлөв” нэртэй 3 дугаар бүлэгтээ судлаач түлш, эрчим хүчний салбар дахь Орос, Хятадын харилцаа; дэд бүтцийн бүтээн байгуулалт дахь хөрөнгө оруулалт; өндөр технологийн салбар; хил орчмын болон бүс

нутгийн хамтын ажиллагаа; хил орчмын бүс нутагт цахим бизнес, интернэт-худалдаа хөгжүүлэх боломж зэрэг асуудлыг шинжилсэн байна.

Хятадын эдийн засаг нэг хэсэгтээ “шинэ хэвийн байдал”-д байх тул гадаад түнш, түүний дотор ОХУ Хятадын нөхцөлд зохицон хөрөнгө оруулалтад суурилсан эдийн засгийн өсөлтөөс хэрэглэгчид тулгуурласан эдийн засгийн өсөлтийн загварт шилжих шаардлагатай болно.

ДҮГНЭЛТ

Хятадын судлаачид ОХУ-ыг стратегийн түнш бөгөөд геополитикийн ашиг сонирхлын ялгаа бүхий стратегийн өрсөлдөгч гэж үздэг байна.

Хятадын ардын чөлөөлөх арми Оросын тусламжтайгаар цэргийн зэвсэг, байлдааны техникээ боломжтой хэмжээнд шинэчилсэн, цаашид цэрэг-техникийн хамтын ажиллагааг Оросоос шинэ төрлийн зэвсэг, технологи авах, хамтарсан үйлдвэрлэл хөгжүүлэхэд чиглүүлэх, эрчим хүчний хамтын ажиллагааны хувьд оросын талаас хамааралтай саад бэрхшээл байгаага, түүнийгээ арилгах талаар Москва анхаарах ёстой, нефть, байгалийн хий зэрэг түүхий эдийг өөрийн ашиг сонирхолд нийцсэн үнээр импортолно, худалдаа, эдийн засгийн хөгжлийн загвараа хятадын бодлоготой нийцүүлэх, өөрчлөх шаардлагатай зэрэг нэлээд “бяр амтагдсан”, “тулгах байр суурь”-тай байгааг хятадын эрдэмтдийн бүтээлээс харж болохоор байна.

ЭХ СУРВАЛЖ

- Чжэн Ци. Политическая роль военно-технического сотрудничества в современных российско-китайских отношениях. Автореферат диссертации на соискание ученой степени кандидата политических наук. Санкт-Петербургский государственный университет. Санкт-Петербург, 2010. – 20 с.
- Чу Лин. Политические и экономические аспекты сотрудничества между КНР и РФ в сфере энергетики. Диссертация на соискание ученой степени кандидата политических наук.

наук. Санкт-Петербургский государственный университет экономики и финансов. Санкт-Петербург, 2015. -147с.

- Ван Цзуняо. Перспективные направления российско-китайского экономического сотрудничества на современном этапе. Диссертация на соискание ученой степени кандидата экономических наук. Российский университет дружбы народов. Москва, 2017. – 180 с.
- Шао Дэвань. Отражение российско-китайских отношений в русскоязычных СМИ КНР 2006-2016 гг. Диссертация на соискание ученой степени кандидата филологических наук. Российский университет дружбы народов. Москва, 2017. - 159 с.
- Ду Цюаньбо. Особенности имиджа КНР в русскоязычных печатно-сетевых СМИ Китая. Диссертация на соискание ученой степени кандидата филологических наук. Российский университет дружбы народов. Москва, 2017. – 180 с.
- Чжэнь Чэн. Эволюция российско-китайских отношений в энергетической сфере (2001-2015 гг.). Диссертация на соискание ученой степени кандидата исторических наук. Российский университет дружбы народов. Москва, 2016. – 167 с.
- Чжоу Цзяньин. Эволюция взаимоотношений между Китаем и Россией в 2001-2006 гг. Автореферат диссертации на соискание ученой степени кандидата исторических наук. Владивосток. 2010.
- Цуй Чжэн. Научно-техническое сотрудничество РФ и КНР в контексте инновационного развития стран БРИКС. Диссертация на соискание ученой степени кандидата политических наук. Московский государственный университет им. М.В.Ломоносова. Москва, 2015. - 229 с.
- Се Чжэнчжэнь. Влияние Американского фактора на китайско-российские отношения в постбиполярный период (1991-2015 гг.). Диссертация на соискание ученой степени кандидата исторических наук. Российский университет дружбы народов. Москва, 2016. – 182 с.
- Синь Жань. Российско-китайское приграничное и межрегиональное сотрудничество на современном этапе (2001-2011 гг.). Диссертация на соискание ученой степени кандидата исторических наук. Московский государственный институт (Университет) международных отношений МИД России. Москва, 2014. - 169 с.
- Лу Чуньюе. История, современное состояние и перспективы сотрудничества провинции Хэйлунцзян и Дальнего Востока России в конце XX - начале XXI века. Диссертация на соискание ученой степени кандидата исторических наук. Благовещенский государственный педагогический университет. Благовещенск. 2015. - 186 с.
- Дин И. Роль высших органов государственной власти в формировании политической стабильности в обществе: сравнительный анализ Китая и России. Диссертация на соискание ученой степени кандидата социологических наук. Санкт-Петербургский государственный университет. Санкт-Петербург, 2016. - 219 с.
- Цзян Фэн. Государственное регулирование внешней торговли Китая. Диссертация на соискание ученой степени кандидата экономических наук. Московский государственный университет им. М.В.Ломоносова. Москва, 2014. - 185 с.

- Лю Цянь. Обучение китайских студентов-филологов устной речи с использованием материалов исторического содержания. Диссертация на соискание ученой степени кандидата филологических наук. Московский педагогический государственный университет. Москва, 2015. - 286 с.
- Фэн Юй. Функционирование аксиологических концептов в лингвоментальном пространстве приграничных регионов России и Китая. Диссертация на соискание ученой степени кандидата филологических наук. Благовещенский государственный педагогический университет. Благовещенск. 2016. - 182 с.
- Чжан Би Юй. Тенденции развития туристического комплекса Китая. Диссертация на соискание ученой степени кандидата экономических наук. Московский государственный университет им. М.В.Ломоносова. Москва, 2015. - 200 с.
- Яо Вэй. Подготовка специалистов вокального искусства в системах высшего музыкального образования Китая и России. Диссертация на соискание ученой степени кандидата педагогических наук. Астраханский государственный университет. Астрахань, 2015. - 196 с.
- Лян Чжэ. Православие в контексте современного российско-китайского взаимодействия (1949-2015). Автореферат диссертации на соискание ученой степени кандидата исторических наук. Российский университет дружбы народов. Москва, 2016. – 27 с.
- Ван И. Приграничное экономическое сотрудничество между Россией и Китаем. Автореферат диссертации на соискание ученой степени кандидата исторических наук. Российский университет дружбы народов. Москва, 2009. – 27 с.
- Гао Шудинь. Российско-китайские отношения в условиях глобализации (политико-концептуальный анализ). Автореферат диссертации на соискание ученой степени кандидата политических наук. Московский государственный университет им. М.В.Ломоносова. Москва, 2005. - 24 с.
- Ся Гуаньюань. Экономическая интеграция России и Китая в Шанхайской организации сотрудничества. Автореферат диссертации на соискание ученой степени кандидата экономических наук. Уральский государственный экономический университет. Екатеринбург, 2009. - 16 с.
- Чэнь Цянь. Экономическое обоснование роли угля в обеспечении эффективного использования ресурсного потенциала ТЭК. Автореферат диссертации на соискание ученой степени кандидата экономических наук. Российский государственный геологоразведочный университет имени Серго Орджоникидзе. Москва, 2011. - 26 с.
- Сун Цзе. Вино в социокультурном ландшафте России и Китая. Автореферат диссертации на соискание ученой степени кандидата исторических наук. Астраханский государственный университет. Астрахань, 2015. - 22 с.
- Чжан Вэй. Информационные аспекты деятельности Шанхайской организации сотрудничества. Автореферат диссертации на соискание ученой степени кандидата филологических наук. Московский государственный университет им. М.В.Ломоносова. Москва, 2017. - 21 с.



Н.СОЁЛГЭРЭЛ

ХЯТАДЫН ӨСӨЛТИЙН ТҮШИЦ: ТӨВ АЗИ ДАХЬ ЭДИЙН ЗАСАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Central Asia has become a region where China supports its economic growth through the engagement with regional countries. China sees regional countries as one of the partners that China can import natural and energy resources from, potential space to increase its trade turnover and new alternative to connect China to the Western markets. In line with this tendency, China is deepening its investment policy towards these countries.

This article examines China's economic relations with Central Asian countries, while looking at how these relations are mutually beneficial.

Түлхүүр үгс: Хятад, Төв Ази, хөрөнгө оруулалт, эрчим хүчний түүхий эд, эдийн засгийн хамтын ажиллагаа

ОРШИЛ

Төв Азийн бүс нутаг БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх томоохон түшиц газар болоод байна. Тэдний зүгээс “стан”-уудыг байгалийн болон эрчим хүчний нөөцийн эх сурвалж, худалдаа, бараа эргэлтийн томоохон орон зай, өрнөдийн зах зээлд холбох тээврийн замын

шинэ хувилбар хэмээн тооцож байгаа. Тээврийн замын шинэ хувилбар гэдэгт Евразийг холбосон төмөр зам, автомашин, агаарын тээврийн нэгдсэн сүлжээ болох эртний “Торгоны зам”-ыг ойлгож байгаа. Тиймээс ч Хятадын зүгээс бүс нутагт баримталж байгаа хөрөнгө оруулалтын

бодлогоо эдгээр хандлагад нийцүүлэн, эрчимжүүлж байгаа юм.

Төв Азийн улсууд тусгаар тогтносон эхэн үед Бээжингийн зүгээс тэдэнд оруулж байсан хөрөнгө оруулалтын хэмжээ нэг тэрбум ам.долл. хүрэхтэй үгүйтэй байсан төдийгүй газрын тос, байгалийн хийн салбараар хязгаарлагдаж байв. Харин үүнээс хойш хорь гаруй жилийн хугацаанд Хятадын бүс нутагт оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ хэдэн арав дахин өсөөд Тээврийн замын шинэ хувилбар гэдэгт Евроазийг холбосон төмөр зам, автомашин, агаарын тээврийн нэгдсэн сүлжээ болох эртний “Торгоны зам”-ыг ойлгож байгаа. Тиймээс ч Хятадын зүгээс бүс нутагт баримталж байгаа хөрөнгө оруулалтын бодлогоо эдгээр хандлагад нийцүүлэн, эрчимжүүлж байгаа юм.

Төв Азийн улсууд тусгаар тогтносон эхэн үед Бээжингийн зүгээс тэдэнд оруулж байсан хөрөнгө оруулалтын хэмжээ нэг тэрбум ам.доллар хүрэхтэй үгүйтэй байсан төдийгүй газрын тос, байгалийн хийн салбараар хязгаарлагдаж байв. Харин үүнээс хойш хорь гаруй жилийн хугацаанд Хятадын бүс нутагт оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ хэдэн арав дахин өсөөд байна.

Тиймдээ ч хамтын ажиллагааны энэ өсөлтийг Бүх *Хятадын Ардын улс төрийн зөвлөлдөх* зөвлөлийн *Үндэсний* хорооны дэд тэргүүн Ван Чинмин дүгнэн 2017 оны наймдугаар сард Хятадын Лянь Юнь Ганд болсон Хятад-Төв Азийн хамтын ажиллагааны V дахь чуулга уулзалтын үеэр хэлсэн үгэндээ “... *Хятад болон Төв Азийн орнууд дипломат харилцаа тогтоосон 25 жилийн турш, улс төрийн харилцан итгэлцэл бэхжиж, харилцан ашигтай хамтын ажиллагаа идэвхтэй хөгжсөөр ирсэн юм. Аюулгүй байдлын салбар дахь хамтын ажиллагаа гүнзгийрч, хүмүүнлэгийн солилцоо идэвхтэй хөгжин, олон улсын хамтын ажиллагаа нягтарч,*

бусад орнуудтай харилцах тухайд бүс нутгийн хамтын ажиллагааны жишиг болж байна. Өдгөө, “Нэг бүс Нэг зам”-ыг хамтаар байгуулах явдал Хятад болон Төв Азийн орнуудын хамтын ажиллагааны гол шугам болж байна. Хятад улс Төв Азийн орнуудтай улс төрийн итгэлцлийг тасралтгүй гүнзгийрүүлж, “Нэг бүс Нэг зам”-ын хамтын ажиллагааг тал бүрээр хөгжүүлж, хууль сахиулах аюулгүйн хамтын ажиллагааг өргөжүүлэн, олон улсын зохицуулалтыг ахиулж, иргэдийн ойлголцлыг гүнзгийрүүлэн, хоёр талын харилцааг тасралтгүй шинэ шатанд хүргэхэд бэлэн байна ...”¹ хэмээн тэмдэглэсэн байна.

Энэ өгүүлэлдээ бидний мөнхийн хоёр хөршийн нэг БНХАУ-ын Төв Азийн бүс нутгийн улсуудтай эдийн засгийн тухайд хэрхэн харилцаж байгааг тоймлон харахын сацуу хамтын ажиллагаа талуудад хэр зэрэг ашиг тустай байгааг дүгнэн үзэхийг зорьсон болно.

НЭГ. КАЗАХСТАН: ХЯТАДЫН ӨРНӨД РҮҮ НЭВТРЭХ ХААЛГА

Астана бол Бээжингийн тухайд Ойрх Дорнодоос газрын тосны хамаарлаа бууруулахад чиглэсэн Төв Ази дахь чухал түнш юм. Хятад ч мөн адил Казахстаны хувьд Европын Холбооны дараа хоёрдугаарт тооцогдох газрын тосны бүтээгдэхүүний томоохон худалдан авагчид тооцогдож байна. Газрын тосны салбараар хязгаарлагдаж байсан хоёр талын харилцаа 2010 онд БНХАУ-ын удирдагч Ху Жиньгао Казахстанд айлчлах үеэр талууд атомын эрчим хүчийг энх тайванчаар ашиглахаар тохирсон үеэс өргөжин тэлэх болсон юм. Хятадад 650 тн уран нийлүүлэхээр Казахстаны Казатомпром, Хятадын CGNPC компани хооронд хамтын ажиллагааны гэрээ байгуулсан билээ.

¹ “5th China-Central Asia Cooperation Forum held in Lianyungang”, http://english.jschina.com.cn/23261/201708/t20170804_4471846.shtml

Улмаар 2013 оны есдүгээр сард Хятадын Төрийн тэргүүн Си Зинпинь, Казахстаны Ерөнхийлөгч Н.Назарбаев нар бүх талын стратегийн түншлэлийн хэлэлцээрт гарын үсэг зурцагасан билээ. Уг хэлэлцээрт эдийн засаг, ялангуяа эрчим хүчний салбар дахь хамтын ажиллагааг улам бүр гүнзгийрүүлж, газрын тос, байгалийн хийн олборлолт, тээвэрлэлтэд түлхүү анхаарч ажиллахаар тусгасан юм.

Мөн талууд хөрөнгө оруулалтын зургаан баримт бичигт гарын үсэг зурсан. Хятадын зүгээс Казахстанд 22 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийх боломжтой болсон байна. Хөрөнгө оруулалтын ихэнх нь дэд бүтцийн салбарт чиглэж байгаа бөгөөд хоёр улсыг холбосон шинэ зам, магистралийг барихаар болсон байна. Энэ чиглэлд юуны өмнө Казахстанас Хятад руу хий дамжуулах С хоолойн шугамыг өргөтгөх, Бейнеу-Базой-Чимкент чиглэлийн хоолойг барих ажлыг эхлүүлэх болон Атырау хот дахь үнэрт нүүрсустөрөгчийн үйлдвэрлэлийн комплексийг шинэчлэх зэрэг томоохон төслүүдийг хэрэгжүүлэхээр тохирсон юм². Эдгээрийн үндсэн дээр Казахстанас Хятад руу нийлүүлэх эрчим хүчний түүхий эдийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэхээр талууд төлөвлөсөн юм. Хамгийн сүүлд 2017 оны зургаадугаар сард талууд Астанад найман тэрбум ам.долларын хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурлаа.

Өнгөрсөн хорь гаруй жилийн хугацаанд бүс нутгийн улсуудаас Казахстанд Хятадын зүгээс хамгийн их хөрөнгийг оруулсан билээ. Нийт 42.8 тэрбум ам.долларын хөрөнгө оруулсны зэрэгцээ 50 тэрбум

² “Строительство газопровода Бейнеу-Бозой-Шымкент закончат в этом году”, Подробнее: <http://www.abctv.kz/ru/news/stroitelstvo-gazoprovoda-bejneubozoj-shymkent-zakonchat-v> Любое использование материалов допускается только при наличии гиперссылки на www.abctv.kz <http://www.abctv.kz/ru/news/stroitelstvo-gazoprovoda-bejneubozoj-shymkent-zakonchat-v>

ам.долларын зээл олгоод байна.³ 2016 онд 624 сая ам.долларын хөрөнгийг Бээжингээс Астанад оруулсан явдал өмнөх оныхоос долоо дахин их байгаа юм. Мөн аж үйлдвэрийн 50 гаруй том төслийг хэрэгжүүлсэн ба 100 сая тн газрын тос, 183 тэрбум куб.метр байгалийн хий нийлүүлээд байна. Хоёр талын хоорондын төмөр замын ачаа тээврийн хэмжээ 2016 онд гэхэд 8.2 сая тоннд хүрсэн бол Хятадаас Казахстанаар 1200 галт тэргээр дамжуулан гуравдагч оронд ачаа тээвэрлэжээ.⁴

Хоёр талын худалдаанд цаашид ихээхэн голлох нэрийн бүтээгдэхүүнд нүүрс багтаж байна. Казахстан улс нүүрсний экспортын түншээ Европ, Азийн чиглэлд тэлэхэд ихээхэн анхаарч байна.⁵ Тус улсын нүүрсний хамгийн том худалдан авагч болох ОХУ-ын импортын хэмжээ буурсны улмаас 2016 онд төлөвлөсөн хэмжээндээ хүртэл олборлолт хийж чадаагүй аж. Мөн онд нийт 98 сая тонныг олборлосноос 71.8 саяыг дотооддоо хэрэглэж, 26.2 саяыг экспортолжээ. Харин 2017 онд зах зээлийн эрэлтэд нийцүүлэн 100 сая тонныг олборлохоор төлөвлөөд байна⁶. Цаашдаа бүтээгдэхүүнээ борлуулах нэг том зах зээлээ Хятад гэж тэд харж байгаа юм.

2016 онд 200 сая тонн нүүрс гаднаас импортолсон БНХАУ-ыг нүүрсний томоохон зах зээл хэмээн тооцож, бусад нийлүүлэгчидтэй өрсөлдөх чадвараа үнэлэх болон Хятадыг боломжит зах зээл байж чадах тухайд Казахстан улс бүхий

³ “News from China” <http://in.china-embassy.org/chn/xwfw/zgxw/P020170629523808336106.pdf>

⁴ “China Focus: China, Kazakhstan move closer with Belt & Road cooperation”, http://news.xinhuanet.com/english/2017-06/09/c_136353535.htm

⁵ Ерөнхий сайд Бакытжан Сагинтаев Засгийн газрын хуралдаан дээр хэлсэн үгэндээ “... Ирээдүйг харах хэрэгтэй. ОХУ-ын биднээс авдаг нүүрсний хэмжээ багассаар байгааг бид хэдэн жил ярьж байна. Удахгүй бид бүр энэ зах зээлийг алдаж ч мэдэх юм...” хэмээн мэдэгдээд байна.

⁶ “Добыча нефти в Казахстане: увеличится до 100 млн тонн в год”, <https://forbes.kz/news/201706/16>

л түвшиндээ анхааран судалж байна. Тухайлбал, "... Хөрш орнуудын нүүрсний зах зээлийн өнөөгийн байдал болон цаашдын хандлагыг сайтар тооцоолох нь чухал. ОХУ 2030 он хүртэл жилд олборлож байгаа 400 сая тонноо 500 саяд хүргэхээр төлөвлөж байна⁷. Технологи нь хоцрогдсон Экибастузын ордны нүүрсийг бид орлох боломжтой гэж үзсэн боловч Кузнецкийн нүүрсээр орлуулахаар тэд өөрсдөө тооцоолж байгаа тул Оросын зах зээл бидний хувьд хязгаарлагдмал болж байна. Тиймээс шинэ зах зээлийн эрэлд гарах хэрэгтэй. Эдийн засаг, экологийн асуудал болон өнөөгийн нөхцөл байдлаас үүдэн дотоод дахь олборлолтынхоо хэмжээг 500 саяар бууруулахаар БНХАУ шийдвэрлэсэн болно. Тэгэхээр бид тэдний олборлолтоо танах процесс, газар нутгийн хувьд аль хэсэг дэх олборлолтын тухай ярьж байгаа зэргийг ажиглаж байх шаардлагатай ..." ⁸ хэмээн Астана үзэж байна.

Төв Азид явуулж буй Хятадын бодлогод Казахстан чухал байр суурь эзэлдэг ба талууд бүх талын харилцааг өргөн хүрээнд хөгжүүлэхээр зорьж байна. Эрчим хүчний түүхий эд, ялангуяа нүүрс, зэсийн худалдаа, хий дамжуулах хоолойн төслийн явц нэлээд эрчимтэй байна.⁹ Казахстаны

⁷ "Energy strategy of Russia", www.energystrategy.ru/projects/docs/ES-2030_(ENG).PDF

⁸ "Казахстан поищет новых клиентов на уголь", www.abctv.kz/ru/news/

⁹ Судлаачийн тайлбар: уудын хооронд 50 тэрбум ам.долларын 20 орчим төсөл, хөтөлбөр хэрэгжиж байна. 2015 оны 08 дугаар сард Казахстаны Ерөнхийлөгч Н.Назарбаев БНХАУ-д айлчлах үеэр талууд нэмж 13 тэрбум ам.долларын өртөг бүхий 25 орчим төслийг хэрэгжүүлэх гэрээнд гарын үсэг зурсан юм. Ингэснээр талуудын хамтран хэрэгжүүлэх төсөл 45 орчимд хүрч байна. Эдгээр төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн 30 тэрбум ам.долларыг Хятадын тал гаргаж байгаад талархан Н.Назарбаев "... Олон улсын санхүүгийн байгууллагуудаас оруулах хөрөнгө оруулалт багассан ийм үед Хятадын тал ийнхүү хөрөнгө оруулж байгаад талархуштай ..." хэмэсэн билээ. Дашрамд дурдахад өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд Хятад улс 19 тэрбум ам.долларын хөрөнгийг Казахстаны эдийн засагт оруулжээ.

гадаад худалдааны бүтэц, бүтээгдэхүүний төрөлжилт манайхтай төстэй учир зарим нэг тоо баримтыг тодруулан авч үзье.

Казахстан улс нүүрсний нөөцөөрөө дэлхийд наймдугаарт эрэмбэлэгддэг ба 300 жил олборлоход хүрэлцэх аж. Тус улсад нөөц нь тогтоогдсон 400 орд газарт нийт 33.6 тэрбум тонн нүүрс байгаа явдал дэлхийн нөөцийн 3.6 хувийг бүрдүүлдэг. 2016 онд 98 сая тонн нүүрс олборлож, 71.8 саяыг нь дотооддоо хэрэглэн, хэрэгцээгээ бүрэн хангасны зэрэгцээ 26.2 саяыг¹⁰ (энэ нь зөвхөн ОХУ-д ногдоно) экспортолсон байна. Харин Монгол Улс жилд 20 сая тонныг олборлодог юм. Казахстаны одоо олборлож буй хэмжээнд бид 2025 онд хүрэхээр төлөвлөж байгаа. Гэтэл Хятадын жилийн хэрэглээ 3 тэрбум тонн. *Хэдийгээр олон улсын шинжээчид төдийгүй Хятадын эрх баригчдын хэлж буйгаар агаарын бохирдол зэрэг хүчин зүйлсийн улмаас Хятад нүүрсний хэрэглээгээ бууруулахыг зорьж байгаа ч ойрын 5 жилдээ төдийлөн өөрчлөгдөхгүй, харин ч экспортын хэмжээгээ 15-20 хувиар нэмэгдүүлж болзошгүй юм.*¹¹ Нөгөө талаас Казахстан улс Украин, Хятад, Европыг нүүрсний боломжит зах зээл¹² хэмээн харж, сонирхож эхлээд байна. Тус улсын Үйлдвэрлэл, шинэ технологийн яамны сайд асан И.Иссекешевийн дурдсанаас үзвэл, Казахстан нүүрсийг өндөр технологиор сайтар боловсруулж, зөвхөн эрчим хүч үйлдвэрлэхэд бус бензин, дизель түлш, цахилгаан болон химийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ашиглах боломжийг судалж байгаа аж.¹³

¹⁰ "Казахстан поищет новых клиентов на уголь", www.abctv.kz/ru/news/

¹¹ Мөн тэнд

¹² "Kazakhstan wants to export coal to Ukraine, China and Europ", http://en.tengrinews.kz/markets/Kazakhstan-wants-to-export-coal-to-Ukraine-China-and-Europe-253890/

¹³ "IN KARAGANDA REGION, A PLANT WILL EMERGE FOR CONSOLIDATED DEEP COAL REPROCESSING", http://www.mid.gov.kz/en/news/

Хятадын төрийн өмчит Шиньхуа компани Казахстаны “Kaznex invest” хувь нийлүүлсэн нийгэмлэгтэй хамтран Казахстаны Карагандын сав газарт коксжих нүүрс олборлох тохиролцоонд хүрч, эхний ээлжинд найман тэрбум ам.долларын хөрөнгө оруулан жилд зургаан сая тн коксжих нүүрс боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүлэхээр тохироод байгаа.¹⁴ Олборлосон нүүрсийг 100 хувь Хятадын зах зээлд хүргэхээр төлөвлөн эрчимтэй ажиллаж эхэлжээ. Нийт 3600 кв.км талбайг эзлэх, нөөцөөрөө Зөвлөлтийн үед Донбасс болон Кузбассын дараа гуравдугаарт орж байсан Карагандын нүүрсний ордын боловсруулах үйлдвэр ашиглалтад орсноор жилд зургаан сая тонн коксжих нүүрсийг Хятадын зах зээлд нийлүүлэх ба энэ нь өмнөд хөршийн импортын долоо орчим хувийг эзлэхээр байна.¹⁵

Түүнчлэн 2017 оны эхний дөрвөн сарын байдлаар хоёр талын хоорондын ХАА-н бүтээгдэхүүний худалдаа өнгөрсөн оны мөн үеийнхээс 14.5 хувиар нэмэгдэж, 113.2 сая ам.долларт хүрээд байгаа нь газрын тос, нүүрс, хийгээр хязгаарлахгүй ХАА-н салбарын харилцаа талуудын харилцаанд ихээхэн жин дарах болсныг илтгэж байна. Дашрамд дурдахад эрчим хүчний түүхий эдээс гадна Казахстаны зүгээс Хятадад улаан буудай, наранцэцгийн үр, цөцгийн тос, талх экспортолж байгаа бол эргээд Хятадаас цитрусын төрлийн жимснүүд, улаан лооль, алим, лийр зэрэг жимс, ногоо худалдан авч байна.

Казахстан улс нүүрсний экспортын түншээ Европ, Азийн чиглэлд тэлэхэд karaganda-region-plant-will-emerge-consolidated-deep-coal-reprocessing

¹⁴ “Китай вложит 8 млрд долл. вказахскийуголь”, <http://www.karakan-invest.ru/publics/news/226.htm>

¹⁵ “Kazakhstan wants to export coal to Ukraine, China and Europ”, <http://en.tengrinews.kz/markets/Kazakhstan-wants-to-export-coal-to-Ukraine-China-and-Europe-253890/>

ихээхэн анхаарч байна.¹⁶ Тус улсын нүүрсний хамгийн том худалдан авагч болох ОХУ-ын импортын хэмжээ буурсны улмаас 2016 онд төлөвлөсөн хэмжээндээ хүртэл олборлолт хийж чадаагүй аж. Мөн онд нийт 98 сая тонныг олборлосноос 71.8 саяыг нь дотооддоо хэрэглэж, 26.2 саяыг экспортолжээ. Харин 2017 онд зах зээлийн эрэлтэд нийцүүлэн 100 сая тонныг олборлохоор төлөвлөөд¹⁷ байна. Цаашдаа бүтээгдэхүүнээ борлуулах нэг том зах зээлээ Хятад гэж тэд харж байгаа юм.

ХОЁР. УЗБЕКИСТАН: ИДЭВХЖИЖ БУЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагаа аж үйлдвэрийн салбар дахь хөрөнгө оруулалт, байгалийн нөөцийн худалдаан дээр суурилж байна. Энэ чиглэлд талууд нийт 5.3 тэрбум ам.доллараар үнэлэгдэх хөрөнгө оруулалтын 30 гаруй баримт бичигт 2012 онд гарын үсэг зурсан билээ. Дурдсан хөрөнгө оруулалт нүүрсустөрөгчийн үйлдвэрлэл, хөвөн, уран, байгалийн хий, ховор металл, химийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, электроник, мэдээллийн технологи, барилгын материалын үйлдвэрлэлд зарцуулагдах аж. 2012 оны есдүгээр сард Хятадын Ерөнхий сайдын орлогч Ху Ляньюя тус улсад айлчлахдаа Ерөнхийлөгч асан Ислам Каримовтай «ШХАБ-ын гишүүн орнуудтай нөхөрлөл хамтын ажиллагааны тухай гэрээ»-нд гарын үсэг зурсан юм. Мөн талууд 535 сая ам.долларын үнийн дүн бүхий хоёр талын зөвшилцлийг баталсан билээ. Мөн оны наймдугаар сараас эхлэн Хятад руу Узбекистанаас хий нийлүүлж эхэлсэн ба

¹⁶ Ерөнхий сайд Бакытжан Сагинтаев Засгийн газрын хуралдаан дээр хэлсэн үгэндээ “... Ирээдүйг харах хэрэгтэй. ОХУ-ын биднээс авдаг нүүрсний хэмжээ багассаар байгааг бид хэдэн жил ярьж байна. Удахгүй бид бүр энэ зах зээлийг алдаж ч мэдэх юм...” хэмээн мэдэгдээд байна.

¹⁷ “Добыча нефти в Казахстане: увеличится до 100 млн тонн в год”, <https://forbes.kz/news/201706/16>

тухайн онд нийт таван тэрбум куб.метр байгалийн хийг нийлүүлжээ. Улмаар энэ хэмжээ ахисаар 2016 онд 25 тэрбум куб. метр хийг Хятад руу экспортолжээ.

Мөн Хятадын CGNPC компани Узбекистаны Госкомгео компанитай Төв Кызылкумын талбайд уран олборлох зорилгоор хамтран ажиллах гэрээг 2011 оны тавдугаар сард байгуулсан нь талуудын харилцааг өргөтгөжээ. Гэрээнд заасан ёсоор олборлох үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтыг эхлүүлсэн ба 2014 оны хоёрдугаар хагасаас уран олборлож эхэлжээ. Улмаар 2015 оны зургаадугаар сард Торгоны замын эдийн засгийн бүсийн хүрээнд үр өгөөжтэй худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөтгөх тухай протоколд талууд гарын үсэг зурсан юм.

Протоколд тусгаснаар талууд худалдаа, хөрөнгө оруулалт, санхүү, тээвэр зэрэг салбарт хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхээр тохирсны дагуу гадаад худалдаанд дахь бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, аж үйлдвэрлэлийн паркуудыг байгуулах болон дэд бүтцийн барилга байгууламжуудыг барьж байгуулах ажлуудыг эхлүүлээд байна.

ГУРАВ. КЫРГЫЗСТАН: ТӨВ АЗИТАЙ ХАРИЛЦАХ ХЯТАДЫН ТЭЭВЭР-ЛОЖИСТИКИЙН ТУЛГУУР

Бээжингийн зүгээс Кыргызстаныг Төв Ази руу нийлүүлэх өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийхээ тээвэр ложистикийн зангилаа хэмээн тооцож байгаа. Зөвхөн Төв Ази гэлтгүй ОХУ руу нийлүүлэх бараа бүтээгдэхүүний үлэмж хэсэг Кыргызстаны бөөний худалдааны зах зээлээр дайран өнгөрч байгаа юм. Цөөнгүй шинжээчдийн үзэж буйгаар Кыргызстаны ДНБ-д энэхүү худалдааны эзлэх хувь 30-50 хувь байна. Энэхүү үзүүлэлт Кыргызстаны эдийн засагт үзүүлэх Хятадын нөлөө Оросынхоос

дутахгүй байгааг илтгэж байна. Юу гэвэл, ОХУ-д хөдөлмөр эрхэлдэг хөдөлмөрийн мигрантуудынх нь орлого ДНБ-ий нь 30 хувийг бүрдүүлдэг юм.

Гэхдээ Кыргызстан дахь Хятадын нөлөө зөвхөн худалдаагаар хязгаарлагдахгүй. Кыргызстанаас цахилгаан эрчим хүч экспортлохын тулд усан цахилгаан станц барьж байгуулах төсөлд ихээхэн анхаарал хандуулж байна. Одоогийн байдлаар энэ чиглэлд нэлээд идэвхтэй хамтран ажиллаж байгаа төсөл гэвэл Нарын гол дээрх усан цахилгаан станцын байгууламжийн ажил юм.

Мөн транзит худалдааны дэд бүтцийг барьж байгуулах чиглэлд хөрөнгө оруулалтын салбарт хамтран ажиллах тухайд хоёр тал ихээхэн анхаарал хандуулж байна. Кыргызстаны өмнөд хэсгийг дайрч Хятад, Узбекистаныг холбох төмөр замын төсөл ирээдүйд Хятад, Европын хооронд ачаа тээвэрлэх хугацааг богиносгоход ихээхэн чухал үүрэг гүйцэтгэх юм.

Талуудын худалдаанд хил орчмын бүс нутгийн харилцаа ихээхэн чухал. Тиймээс худалдааны хэмжээг нэмэгдүүлэхийн тулд Шинжаан Уйгарын Өөртөө засах Орон, Кыргызстаны худалдааг өргөтгөх нь чухлыг Хятадын тал онцолж байна. Бээжингийн зүгээс усны эрчим хүч, ХАА болон аюулгүй байдлын салбарт гаалийн бүтэц, зохицуулалтыг хялбарчлахад анхаарч байна.

2016 оноос Туркменистанаас Хятад руу хий нийлүүлж эхэлсэн дамжуулах хоолойн Кыргызстаны нутгаар дамжих хэсгийн ажлыг 2014 оны зургадугаар сард эхлүүлсэн юм. Төслийн нийт өртөг 1.5 тэрбум ам.доллар бөгөөд жилд 30 тэрбум куб.метр хүртэл хий нийлүүлэх хүчин чадал бүхий 215 км урттай¹⁸ томоохон бүтээн байгуулалт юм.

Мөн 2015 оны гуравдугаар сард Кыргызстаны зүгээс хоёр улсыг

¹⁸ “CNPC signs pipeline agreements with Russia, Kyrgyzstan”, <http://www.ogj.com/articles/2015/12/cnpc-signs-pipeline-agreements-with-russia-kyrgyzstan.html>

холбосон төмөр зам барих ажлыг бүрэн санхүүжүүлэхийг Хятадаас хүссэн. 2012 онд техник эдийн засгийн үзүүлэлт нь хэдийнээ хийгдсэн энэхүү төслийн өртөг өндөр байсны улмаас хөрөнгө оруулалт нь хойшлоод байсан билээ. Хятадын оруулж байсан хөрөнгийн ихэнх нь Кыргызстаны талаас захиалсны дагуу хийгдэж буй техникийн туслалцаа хэлбэрээр орж байгаа юм. Үүний зэрэгцээ Кыргызстаны тээвэр, барилгын салбарт ч мөн ноогдож байгаа юм.

Ер нь Бээжингийн зүгээс Кыргызстанд оруулж буй хөрөнгө оруулалт, зээлийн хэмжээ харьцангуй хязгаарлагдмал байсныг хэлэх нь зүйтэй. Энэ нь тодорхой шалтгаантай. Нэн тэргүүнд Кыргызстаны дотоод улстөрийн байдал тогтворгүй байсантай холбоотой бол мөн бусад их гүрнүүд болох ОХУ, АНУ-ын цэрэг батлан хамаалахын сонирхол хүчтэй байсан нь ч нөлөөлсөн нь лавтай.

2016 оны байдлаар хоёр талын худалдааны эргэлт нэг тэрбум ам.долларт хүрээд байгаа ба 1.8 тэрбум ам.долларын зээл¹⁹ олгоод байна. Товчхондоо, Хятад улс нь өнөөдөр Кыргызстаны хоёр дахь том худалдааны түнш бөгөөд экспортын барааны хоёр дахь том зах зээл юм. 2016 онд хоёр орны харилцан зорчигчид давхардсан тоогоор 200 мянгад хүрсний зэрэгцээ Хятадад суралцаж байгаа кыргыз оюутны тоо жил бүр 500 гаруйгаар нэмэгдсээр 10 мянга д хүрээд байна.

¹⁹ “Prospects for China – Kyrgyzstan Economic Relations in the Framework of the Silk Road Economic Belt Project”, <http://china-trade-research.hktdc.com/business-news/article/The-Belt-and-Road-Initiative/Prospects-for-China-Kyrgyzstan-Economic-Relations-in-the-Framework-of-the-Silk-Road-Economic-Belt-Project/obor/en/1/1X000000/1X0A9JIX.htm>

ДӨРӨВ. ТАЖИКИСТАН: ХЯТАДЫН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДААНЫ ГОЛ ТҮНШ

Тус улс дахь Хятадын нөлөө сүүлийн жилүүдэд үлэмж нэмэгдэж байна. 2014 оны есдүгээр сард талуудын хооронд байгуулсан 16 баримт бичиг хоёр талын харилцаанд шинэ эрин үеийг нээсэн юм. Эдгээрийн дотор “Стратегийн түншлэлийг өргөжүүлэх тухай”, “2015-2020 он хүртэлх хамтын ажилагааны хөтөлбөр”, 300 сая юаны тусламж үзүүлэх “Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын зөвшилцөл”, “Хөнгөлөлттэй зээл олгох болон Торгоны замын эдийн засгийн бүс байгуулах” санамж бичиг зэрэг харилцааны суурь болсон баримт бичиг багтаж байна.

Эдгээр баримт бичгийн үндсэн дээр, одоогийн байдлаар талуудын харилцаа дэд бүтэц, эрчим хүч, эрдэс баялгийн нөөц, үйлдвэрлэл, ХАА-н бүтээгдэхүүний дахин боловсруулалт зэрэг салбарт төвлөрч байна. Тажикистан аны эрх баригчдын үзэж буйгаар Хятадын Торгоны замын санаачилга нь Тажикистаны тээврийн чадавхийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ Өмнөд Ази, Персийн буланг Хятадтай холбох Тажикийн корридорын тусламжтай хил дамнасан ачаа тээврийн хэмжээ нэмэгдэх аж.

Тажикистан Торгоны замын эдийн засгийн бүсийн хэлэлцээрт гарын үсэг зурж нэгдэн орсон анхны орон юм. Энэ хүрээнд дэд бүтцийн харилцан хамаарлыг бэхжүүлэх болон ХАА-н салбарт шинэ техник, технологи нэвтрүүлэхэд нэн тэргүүнд анхаарч, хөрөнгө оруулалтыг чиглүүлэхээр төлөвлөж байна.

Ерөнхийд нь дүгнэж үзвэл, Хятадын зүгээс Тажикистантай харилцах харилцаандаа эдийн засгийн зэрэгцээ аюулгүй байдал, геополитикийн сонирхлын үүднээс хандаж байна.

Хятад улс Тажикистанд үзүүлж буй зээл, тусламжийнхаа үрээр тус улсыг түүхий эдийн бааз суурь, бараа хангалтын зах зээл болгон хувиргаж байгаа тухай гадаадын ажиглагчид дурдсаар байна. Энэ зорилгодоо хүрэхэд нь Хятадад Тажикистаны эдийн засаг, нийгмийн сул хөгжил болон эрчим хүч, хүнсний хангамжийн хомсдол “ивээс” болж байгаа юм.

Одоогийн байдлаар Бээжин Душанбегийн хоёр дахь том худалдааны түнш, хамгийн том “донор” орон болчихоод байна. Тус улсын гадаад худалдаа 2016 онд 3.9 тэрбум ам.долларт хүрээд байгаагаас ОХУ-тай нэг тэрбум, Хятадтай 885 сая ам.долларын худалдаа²⁰ хийжээ. Гэвч Хятадтай хийсэн худалдаа ихээхэн тэнцвэргүй Хятадын экспорт 90 хувийг эзэлж байна. Хятадын хөрөнгө оруулалтын дийлэнх нь Тажикистанд зам гүүр барих зэрэг дэд бүтцийн салбарт түлхүү зарцуулагдаж байгаа аж. Тажикистаны нийт гадаад өрийн тэн хагасыг Хятад дангаар барьж байна. Эдгээр санхүүгийн дэмжлэгийн хариуд Тажикистанд алт, уран болон газрын ховор элемент олборлох эрхийг Хятад бүрэн эзэмших болоод байна. Үүний зэргэцээ талуудын хооронд маргаан тариад байсан мянга гаруй кв.км газар нутгийг Хятадад найр тавин өгөхөд хүргэсэн байна.

ТАВ. ТУРКМЕНИСТАН: ХЯТАДЫН БАЙГАЛИЙН ХИЙН ГОЛ ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧ

Туркменистаны ДНБ-ий орлогын үлэмж хэсгийг бүрдүүлэгч байгалийн хийн гол худалдан авагч нь Хятад юм. Энэ тухайд ОХУ-ын Газпромыг ардаа орхиод удаж байна. Туркменистан-Хятадын хий дамжуулах хоолойн анхны магистраль

²⁰ “Таджикистан / Экономика / Внешнеторговый оборот Таджикистана за два года сократился на 1,3 миллиард долларов”, <https://news.tj/ru/news/tajikistan/economic/20170124/vneshnetorgovii-оборот-tadzhikistana-sokratilsya-na-13-milliardov-dollarov>

2009 оны 12 дугаар сард ашиглалтанд орсон бөгөөд 2011 оны сүүлээр хоёр дахийг ашиглалтад оруулснаар хий дамжуулах хоолойн хүчин чадал жилд 40 тэрбум куб. метр болж өссөн²¹ байна. Үүнээс гадна 2012 оны дөрөвдүгээр сараас эхлэн Узбекистан улс мөн Туркменистан-Хятадын хий дамжуулах хоолойгоор дамжуулан хий худалдан авах болжээ.

Хоёр талын хамтын ажиллагааны хороо 2012 оны долоодугаар сард Бээжинд хуралдаж, Хятадын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайдын орлогч Ван Цишань Туркменистан улсыг Хятад руу байгалийн хий урт хугацаанд тогтвортой, найдвартай нийлүүлэгч хэмээн нэрлэж, эрчим хүчний хамтын ажиллагааг бүрэн дэмжихээ илэрхийлсэн билээ. Одоо талууд Аму Дарья мөрний баруун эрэг болон Өмнөд Иолотаний байгалийн хийн ордын төслийн барилгын болон олборлолтын ажлыг эхлүүлж, Туркменистанаас Хятадад нийлүүлэх хийн хэмжээг жилд 25 тэрбум куб.метрээр нэмэгдүүлэхээр зорьж байна.

Мөн Хятадын зүгээс «Шинэ Торгоны Зам»-ын хүрээнд хоёр орны эдийн засгийн харилцааг хөгжүүлэхийн тулд төмөр зам, ялангуяа өндөр хурдны төмөр зам барихад БНХАУ-ын туршлагыг нэвтрүүлэхээр төлөвлөж байна. Энэ нь Туркменистаны Ерөнхийлөгчийн Төв Ази, Каспийн болон Хар тэнгис, Ойрхи Дорнод, Өмнөд болон Зүүн Өмнөд Азийн нэгтгэсэн шинэ гео-эдийн засгийн орон зай байгуулах санаачилга хэрэгжихэд томоохон алхам болох аж. Хятадад ч ялгаагүй Туркменистаны нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлснээр бараа бүтээгдэхүүнээ Европ руу тээвэрлэх боломж олж авах нөхцөл бүрдэх нь гарцаагүй.

²¹ “Chinese CNPC’s current Turkmenistan gas imports reach 35bcm/year”, Таджикистан / Экономика / Внешнеторговый оборот Таджикистана за два года сократился на 1,3 миллиард долларов

ДҮГНЭЛТ

Бээжингийн зүгээс Төв Азийн өсч буй эдийн засгийг эрчим хүчний түүхий эдээр найдвартай хангах эх үүсвэр, Европ хүрэх худалдааны сүлжээ байгуулахад нь транзит болох гол нутаг дэвсгэр хэмээн хардаг. Тив дамнасан, Төв Азиар дамжин өнгөрөх “Бүс ба зам” эдийн засгийн хонгил байгуулах санаачилга ч эдгээр зорилгодоо хүрэх стратеги нь юм.

Өнөөгийн байдлаар БНХАУ нь Казахстан, Туркменистан, Узбекистан, Тажикистан, Кыргызстаны худалдааны том түнш болоод байна. Улс төрийн шийдвэр гаргах ижил процесс бүхий энэ бүс нутгийн улсуудтай Бээжингийн зүгээс улс төр, эдийн засгийн бүхий л салбарт хамтран

ажиллахад хялбар байж магадгүй юм. Сүүлийн жилүүдэд хоёр талын хооронд хийгдсэн гэрээ хэлэлцээрүүд үүнийг илтгэж байна. БНХАУ-ын Төв Азид явуулж буй бодлогод Казахстан улс чухал байр суурь эзэлдэг ба талууд бүх талын харилцааг өргөн хүрээнд хөгжүүлэхээр чармайж байна. Казахстаны гадаад худалдааны бүтэц Монгол Улсынхтай төстэйн зэрэгцээ хоёул далайд гарцгүй, нэг зорилтот том зах зээлтэйн улмаас ижил сорилттой тулгарч болзошгүй тул тус улсын жишгийг сайтар судалж, анхаарч байх шаардлагатай. Ялангуяа бүс нутгийн томоохон тоглогч, хөрөнгө оруулагч улсуудтай Казахстан болон бүс нутгийн бусад улсууд хэрхэн хамтран ажиллаж, ашиг сонирхлыг нь бий болгож буй нь анхаарал татна.



Ч.НАРАНТУЯА

ЕВРАЗИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХОЛБОО ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭТИЙН ТӨЛӨВ

The Eurasian Economic Union (EEU), a regional economic integration, is planning to enhance the economic competitiveness of its member states and improve the living standards of citizens, but still has not been successful at the present moment, GDP has been steadily declining and in some parts, member states have been facing significant barriers to engage in foreign trade independently. Beside the Russian Federation, trade relations between other member states of the EEU are weak while trade deficit among the countries is widening. The EEU is a critical factor for Russian ambition to establish a multi-polar world order. Therefore, Russia is trying to intensify the Eurasian Economic Union and to expand ties with other countries in various formats such as dialogue partners, Free Trade Zones and Free Trade Agreements.

Монгол Улс эрдэс баялаг, эрчим хүчний үлэмж их нөөцөөрөө олон улсын анхаарлыг өдгөө татах болсон. Далайд гарцгүй, гуравдагч зах зээлээс алслагдмал Монгол Улс гадаад зах зээлээ нэмэгдүүлэх, бусад оронтой эдийн засгийн харилцаанд орохын тулд бүс нутгийн олон талт хамтын ажиллагаанд хамрагдах явдал чухал юм. Орос, Хятадын оролцоо голлосон бүс нутгийн интеграц болох ШХАБ-д Энэтхэг, Пакистан улс

гишүүнээр элссэн явдлыг Өрнөдийн судлаачид шийдвэр гаргах чадваргүй, хэнд ч сонирхолгүй байгууллага болж хувирлаа гэж одоогоор дүгнэж байна. Тэгвэл бүс нутгийн өөр нэг интеграц болох Евразийн эдийн засгийн холбооны ирээдүйн төлөв ямар байх вэ гэсэн асуулт гарч ирнэ. Тус өгүүллээр Евразийн эдийн засгийн холбооны өнөөгийн байдал, гишүүн орнуудын алдаа, оноо юунд оршиж байгааг тодруулахыг зорилоо.

Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцааны бодлогын үндсэн зорилго нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын үндсэн дээр тус улсын эдийн засгийн хэтийн болон цаг үеийн зорилтыг зохистой шийдвэрлэхэд гадаад хүчин зүйлийг оновчтой ашиглах, улмаар улс орны эдийн засгийг бүс нутгийн интеграцид өөрийн гэсэн байр суурьтай болгоход оршдог.¹ Монгол Улс Ази, Номхон далайн бүс нутагт өрнөж буй улс төр, эдийн засгийн олон талт үйл явцад идэвхтэй оролцохыг гадаад бодлогын тэргүүлэх зорилтын нэг гэж үзсээр ирсэн. Энэ зорилт нь эдийн засгийн хөгжлөө урагшлуулах, аюулгүй байдлаа улс төр, дипломатын аргаар хангах сонирхолтой уялдаатай. ОХУ, БНХАУ төдийгүй дэлхийн бусад оронтой эдийн засгийн харилцааг хөгжүүлэх зорилгоор Зүүн Ази, Төв Азийн бүс нутагт ихээхэн ач холбогдол өгдөг.

Зүүн Азийн хувьд АПЕК, Зүүн Азийн дээд түвшний уулзалт, Өмнөд Солонгос-Хятад-Японы гурван талын хамтын ажиллагаа, Төв Азийн хувьд ШХАБ, Евразийн эдийн засгийн холбоо (цаашид ЕАЭЗХ гэх) зэрэг олон талт хамтын ажиллагааны механизмууд байдаг. ШХАБ өөр хоорондоо зөрчилтэй Энэтхэг, Пакистан улсаар эгнээгээ тэлсэн явдал шинжээчдийн эргэлзээг төрүүлж тус интеграц гацаанд орно гэж дүгнэжээ. Харин ЕАЭЗХ дандаа хөгжил буурай орноор эгнээгээ тэлж байгаа нь анхаарал татаж байна.

ЕАЭЗХ-НЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Өнөөгийн байдлаар Беларусь, Казахстан, Кыргызстан, Армян улс ЕАЭЗХ-нд нэгдээд байна. ЕАЭЗХ-ны ажиллагаа зарим нэг талаараа идэвхжиж байгаа талаар тус холбооны албаны хүмүүс мэдэгдэх болсон. ЕАЭЗХ-ны тэргүүлэх чиглэл болох худалдааны саад тотгорыг арилгах, гадаадын бусад орнуудтай харилцан ашигтай хамтран ажиллах

боломжийг олгох эрх зүйн орчин, хуулийн зохицуулалтыг бий болгохоор ажиллаж байгаа гэнэ. Холбооны гишүүн орнууд нэг нэгнийхээ дотоод зах зээлд дасан зохицох үйл явц аажмаар явагдаж, 2014 онд 11.7 хувь байсан худалдаа 2016 онд 14.1 хувь болж нэмэгдсэн талаар Молдав улсад суугаа ОХУ-ын Элчин сайд Фарит Мухаметшин мэдэгдсэн.² Түүний хэлж байгаагаар Холбооны гишүүн орнуудын гадаад худалдаа 2017 оны эхний улиралд 2016 оны мөн хугацаатай харьцуулахад 11.8 тэрбум ам.доллар буюу 131.3 хувь өссөн аж. 2016 оны эхний улирлын байдлаар ЕАЭЗХ-ны АНД орнуудаас импортлосон хэмжээ анх удаа ЕХ-ноос давж гарсан талаар Ром хотод болсон ЕАЭЗХ-ны V семинарын үеэр мэдэгдэв.

Тус Холбооны гаргасан тоо баримтаас харахад ОХУ-аас бусад ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын хоорондын худалдааны харилцаа маш сул байгаа нь харагдаж байна (Хүснэгт 1). Тэр дундаа Армян улс шиг хөгжил буурай, экспортын барааны төрөл багатай орон Холбоо дотроо эдийн засгийн харилцаанд бараг ордоггүй, эдийн засагт нь эерэг нөлөө гараагүй байна.

¹ http://www.stockholm.mfa.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=32:iii-----&catid=6:2010-02-05-02-15-57&Itemid=15&lang=mn

² <https://ru.sputnik.md/economics/20170606/13004009/muhametshin-posol-evrazijskij-jekonomicheskij-sojuz-vzgljad-budushhee.html>

Хүснэгт 1. ЕАЭЗХ-ны гишүүн орнууд хоорондын худалдаа эргэлт

	Ам.доллар	2016 оны 1-3 сар	Хувийн жин %	
ЕАЭЗХ	11765,9	131,3	100	
Түүн дотор:				
Армян улс	102,5	138,5	0,9	100,0
Беларусь	1,0	77,5		0,9
Казахстан	0,8	166,8		0,8
Кыргызстан	0,2	166,8		0,2
ОХУ	100,5	139,3		98,1
Беларусь	2936,2	138,5	25,0	100,0
Армян	5,6	118,0		0,2
Казахстан	103,5	154,0		3,5
Кыргызстан	13,8	161,6		0,5
ОХУ	2813,3	138,0		95,8
Казахстан	1181,9	139,2	10,0	100,0
Армян	0,2	Х		0,0
Беларусь	23,3	в 6,8 р.		2,0
Кыргызстан	97,5	143,6		8,2
ОХУ	1 060,9	136,4		89,8
Кыргызстан	164,2	123,5	1,4	100,0
Армян	-	-		-
Беларусь	0,0	Х		0,0
Казахстан	75,6	86,0		46,0
ОХУ	88,6	в 2,1 р.		54,0
ОХУ	7 381,1	127,5	62,7	100,0
Армян	258,8	122,3		3,5
Беларусь	4 174,3	118,9		56,6
Казахстан	2 651,1	145,2		35,9
Кыргызстан	296,9	123,6		4,0

Эх сурвалж: eurasiancommission.org

Хүснэгт 2. ЕАЭЗХ болон гишүүн орон тус бүрийн бусад улс оронтой хийж буй худалдааны эзлэх хувь /2017 оны эхний улирлын байдал/

	Бусад улс оронтой	Холбоон дотор
ЕАЭЗХ нийтдээ	88.4	11.6
Армян	76.9	23.1
Беларусь	52.5	47.5
Казахстан	89.1	10.9
Кыргызстан	62.1	37.9
ОХУ	91.2	8.8

Эх сурвалж: eurasiancommission.org

Худалдааны бүтцийг нь авч үзвэл Холбооны экспортод Армян улсын оруулсан хувь нэмэр 0.8 хувиас 0.9, Беларусь 23.6 хувиас 25 хувь, Казахстан 9.5 хувиас 10.0 хувь болж тус тус нэмэгдсэн бол Кыргызстан 1.5 хувиас 1.4 хувь, ОХУ 64.6 хувиас 62.7 хувь болж тус тус буурчээ. Харин импортын бараанд Казахстаны эзлэх хувь 21.1 хувиас 22.6 хувь, ОХУ 33.1 хувиас 34.8 хувь болж өссөн бол Армян 2.8 хувиас 2.5 хувь, Беларусь 39.2 хувиас 37 хувь, Кыргызстан 3.8 хувиас 3.1 хувь болж тус тус буурсан аж.³ Түүнчлэн одоогоор ЕАЭЗХ дотооддоо худалдаа эргэлт тун бага бөгөөд ихэнх нь бусад улсуудтай худалдаа, эдийн засгийн харилцаа илүү хөгжүүлдэг нь тоо баримтаас харагдана (Хүснэгт 2). Ялангуяа ОХУ хамгийн бага буюу 8.7 хувийг эзэлдэг байна. Түүнчлэн дотооддоо хийдэг худалдаанд ОХУ-аас бусад гишүүд алдагдалтай байдаг (Хүснэгт 3).

Хүснэгт 3. ЕАЭЗХ-ны гишүүн орнууд хоорондын худалдаа 2016 оны 01-11 сар /сая ам.доллар/

	Экспорт	Импорт	Алдагдал
Армян	357.5	951.8	-594.3
Беларусь	10176.9	13888.4	-3714.5
Казахстан	3480.6	8465.1	-4984.5
Кыргызстан	317.2	1426.4	-1102.9
ОХУ	23090.4	12488.6	10601.8

Эх сурвалж: *eurasiancommission.org*

ЕАЭЗХ бусад улс орнуудтай харилцаагаа хөгжүүлэхдээ яриа хэлцлийн түншээс эхлээд Чөлөөт худалдааны бүс (ЧХБ), Чөлөөт худалдааны гэрээ (ЧХГ) хэлбэрээр харилцаагаа өргөжүүлэх хандлагатай байна. Дэлхийн 40 гаруй орон тус холбоотой хамтран ажиллах хүсэлтээ илэрхийлсэн талаар Төрийн думын дарга

³ http://www.eurasiancommission.org/ru/act/integr_i_makroec/dep_stat/tradestat/analytics/Documents/Analytics_I_201703.pdf

Сергей Нарышкин мэдээлсэн юм.⁴ Энэтхэг улстай ЧХГ байгуулах хэлэлцээрээ 2017 оны зургаадугаар сарын 03-ны өдөр албан ёсоор эхлүүлжээ.⁵ Энэтхэг улсын Аж үйлдвэр, худалдааны сайд Нирмала Ситхараманы мэдэгдэж байгаагаар хоёр орон худалдаагаа либеральчилсан тохиолдолд ЧХБ байгуулах юм байна. Шинжээчдийн үзэж байгаагаар худалдааны эргэлт 30-40 хувь нэмэгдэх аж. ЧХБ байгуулснаар ЕАЭЗХ-ны орнуудын ХАА, Газар тариалангийн бүтээгдэхүүний Энэтхэг рүү хийх экспорт нэмэгдэх гэнэ. ЕАЭЗХ, Исламын Бүгд Найрамдах Иран улс хоорондын ЧХБ байгуулах талаарх ээлжит уулзалт 2017 оны зургаадугаар сарын 13-14-ний хооронд Тегеран хотноо болж түр хэлэлцээрийн агуулгыг боловсруулж дууссан талаар мэдээллээ.⁶ Гурван жилийн хугацаатай түр хэлэлцээрийн дагуу талууд 200 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний импортын татварыг буулгах (хэдийгээр Иран Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн бус ч гэсэн тус байгууллагын журмыг баримтлах) талаар ярьсан бөгөөд энэ ажил амжилттай хэрэгжвэл цаашид

бүрэн хэмжээний ЧХБ байгуулах зорилготой аж. Мөн түүнчлэн 2017 оны зургаадугаар сарын 16-ны өдөр Бээжин хотноо ЕАЭЖ, БНХАУ-ын хооронд худалдаа, эдийн засгийн хамтын

ажиллагааны ирээдүйн асуудлаар харилцан ярилцсан талаар мэдээллээ.⁷ Талууд хоорондын хамтын ажиллагааны боломж болон яриа хэлэлцээгээ цаашид өргөжүүлэх талаар ярилцжээ.

⁴ <http://www.vestifinance.ru/articles/49799>

⁵ <http://www.eurasiancommission.org/ru/nae/news/Pages/3-06-2017.aspx>

⁶ <http://www.eurasiancommission.org/ru/nae/news/Pages/16-06-2017-4.aspx>

⁷ <http://www.eurasiancommission.org/ru/nae/news/Pages/19-05-2017-2.aspx>

УЧИРЧ БУЙ СОРИЛТ

ЕАЭЗХ-г 2025 он хүртэл өргөн цар хүрээтэй хөгжүүлэх төлөвлөгөөтэй байна. Энэ хугацаанд Холбооны хүрээнд төрийн худалдан авалтыг нэгдсэн нэг системээр хийх, 2019 он гэхэд эрчим хүчний нэгдсэн нэг зах зээл бүрдсэн байх, 2020 онд архи, тамхи, валютын нэгдсэн зах зээлтэй болохоор төлөвлөжээ. 2025 он гэхэд санхүү, байгалийн хий, газрын тос, нефтийн бүтээгдэхүүний нэгдсэн зах зээлийг бий болгох, эцэст нь санхүүгийн нэгдсэн бодлоготой болгох гэнэ. ЕАЭЗХ интеграц амжилттай явагдахад олон саад бэрхшээл байна гэж шинжээчид үздэг. Евразийн орон зайд орших орнуудын эдийн засаг, хөгжлийн асуудал ямар байгаагаас тус Холбооны үйл ажиллагаа хэрхэн өрнөхийг харж болох юм. Тухайлбал, дэлхийн даяарших явц удааширч байгаатай холбоотой нийгмийн хөгжлийн хувьд бусдын араас “хөөж” буй ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын хөгжил мөн саарах хандлагатай байна.⁸ Уламжлалт эрчим хүчний түүхий эдийн эрэлт буурсантай холбоотой экспортын бараа нь төрөлжөөгүй эдгээр орнуудын эдийн засгийн өсөлт буурах, зарим оронд бүр зогсонги байдалд шилжиж байгаа аж. Хэдийгээр эдийн засаг нь хүнд байгаа ч геополитикийн нөлөөгөө хадгалахыг эрмэлзэж буй ОХУ-д энэ байдал улам хүнд ачаа болох юм. Нэгдмэл эдийн засгийн орон зай бүрдүүлэх үйл явц 2017 онд дуусах байсныг 2024 он болтол хойшлуулсан нь үүнтэй холбоотой байх магадлалтай. Үндэстэн хоорондын удирдах байгууллагад ажиллагсдын тоо 10 дахин өссөнтэй холбоотой Евразийн эдийн засгийн комисс (/цаашид ЕАЭЗК гэх)-ын нэг шийдвэр гаргах зардал хуучин Гаалийн холбоотой харьцуулахад 20 дахин нэмэгдсэн аж. Гэхдээ ЕАЭЗК өнөөг хүртэл бие даасан санаачилга гаргаагүй

⁸ <http://eurasia.expert/longreads/eurasia-2017/>

зөвхөн Засгийн газруудын шийдвэрийг хэрэгжүүлж байгаа төдийгүй хэрэгжилтэд хариуцлага хүлээдэггүй байна.

Нөгөө талаас ядуу буурай орнуудыг чирч явснаар ОХУ эдийн засгаа хүчирхэг болгох нь битгий хэл эсрэгээр сулруулж байгаа гэж Оросын зарим шинжээчид үздэг (Хүснэгт 4).⁹ Өнөөгийн байдлаар Холбооны хөрөнгө оруулалтын¹⁰ 88 хувийг ОХУ гаргаж¹¹ байгаагийн зэрэгцээ гаалийн татвараас олсон орлогын үүнтэй тэнцэх хувийг Оросууд хүртдэг байна.¹² Энэ нь бусад хөгжил дорой гишүүн орнууд интеграцаас олох орлого бага, эдийн засгийн чадавх нэмэгдэхгүй (нэг хүнд ногдох ДНБ бага хэвээр) байна гэсэн үг юм.

Хүснэгт 4. Гишүүн орнуудын нэг хүнд ногдох ДНБ /ам.доллар/

	2011	2012	2013	2014	2015
Армян	3350	3512	3680	3852	3504
Беларусь	6207	6695	7644	8004	5639
Казахстан	11634	12387	13891	12807	10510
Кыргызстан	1178	1234	1342	1338	1154
ОХУ	14228	15042	15552	14052	9099
ЕАЭЗХ	12965	13716	14318	13038	8714

Эх сурвалж: eurasiancommission.org

Сүүлийн үед ЕАЭЗХ-ны дотоодын худалдаа аажмаар буурч байгааг дэлхийн болон Хятадын эдийн засгийн бууралттай холбон тайлбарладаг. 2015 онд ЕАЭЗХ-ны орнууд гуравдагч орнуудтай хийсэн худалдаа 33 хувь, хоорондын худалдааны эргэлт нь 25 хувиар багассан.¹³ Төлбөрийн чадвар муутай орнуудаар эгнээгээ тэлэх

⁹ <http://inosmi.info/panmongolizm-polshe-negrozhaet.html>

¹⁰ Одоогоор голчлон эрх зүйн орчинг бүрдүүлэх зэрэг баримт бичгийн төслүүд хэрэгжиж байна.

¹¹ <https://www.bundestag.de/blob/427424/566dd431041ef09b939d661bf55ddd7e/wd-5-030-16-pdf-data.pdf>

¹² <http://www.warandpeace.ru/ru/analysis/view/111554/>

¹³ https://ru.sputnik.md/world_economics/20160526/6884489.html

нь тус Холбооны цаашдын хөгжлийг хойш тагна гэж зарим шинжээчид үздэг.¹⁴ Тус Холбооны цаашдын хөгжилд хамтын худалдаанд ерөнхий дүрмээс гадуурх тусгай заалтууд ихээхэн саад учруулдаг байна. Тухайлбал, Армян, Кыргызстан улс гишүүн болсноор ийм тусгай заалтын тоо нэмэгдэж, Хятадын хямд бараа эдгээр улсуудаар дамжиж байгаагаас бусад гишүүн орны эдийн засагт чухал нэмэр оруулдаг бүтээгдэхүүний экспорт буурахад нөлөөлжээ. Тус холбооны гишүүн орон бие дааж бусад гуравдагч оронтой гэрээ хэлэлцээр хийх бараг боломжгүй (ОХУ-аас бусад нь) байдалд байдаг. ЕАЭЗХ дотоод зах зээлээ хамгаалах, өрсөлдөөнгүй байхад голчлон анхаарч байгаагаас бүтээгдэхүүний чанар муудах, өөрийн өртөг өсөхөд нөлөөлжээ. Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан орнууд тусгаар болсноос хойш, тэр тусмаа сүүлийн үед ЕХ болон Хятадтай харилцаагаар эрчимтэй гүнзгийрүүлж ирсэн. Харин ЕАЭЗХ бусад орноос орж ирэх импортын бараанд тавих татварын нэмэгдүүлэх бодлого барьж байгаагаас ЕХ-ноос маш бага, зарим тохиолдолд татваргүй орж ирдэг байсан чанартай, өндөр технологийн бүтээгдэхүүний

импорт эрс багасч оронд нь Хятадын эсвэл Холбооны дотоод зах зээлийн чанаргүй бараа бүтээгдэхүүн нийлүүлэгдэх, технологийн хоцрогдол өсөх хандлагатай байгаа аж. ОХУ-ын Европоос хийдэг импортын бараа тээвэрлэлт Беларусь, Казахстанар дамжин өнгөрөхөд саад тоггор учирдаг гэх зэргээр ихээхэн бэрхшээлтэй асуудлууд байна. ОХУ-аас бусад гишүүн орнуудад төрийн өмчит компаниуд голчилдог тул ЕХ-ны улсуудтай худалдаа хийхэд хүндрэлтэй байдаг аж. Түүнчлэн татварын нэгдсэн бодлоготой болох гэж байгаа нь татвар багатай хөгжил буурай орны иргэдэд нэмэлт ачаалал болно гэж шинжээчид харж байна (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Евразийн эдийн засгийн холбооны улсуудын татварын хувь хэмжээ¹⁵

Татварын төрөл	ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын татварын хувь хэмжээ				
	ОХУ	Беларусь	Казахстан	Армян	Кыргызстан
Нэмэгдсэн өртгийн албан татвар	0%, 10%, 18%	0%, 10%, 20%	0%, 12%	20%	0%, 12%
Орлогын албан татвар	20%	5%, 10%, 20%	10%, 15%, 30%	5%, 10%	0%, 5%, 10%
Хувь хүний орлогын албан татвар	9%, 13%, 15%, 30%, 35%	9%, 12%, 15%	5%, 10%	0%, 20%	10%
Онцгой албан татварууд	Онцгой татварт барааны нэр төрлөөс хамаарсан хатуу болон суурь үнэлгээнээс тогтоосон татвар				
Үл хөдлөх хөрөнгийн татвар	2,2 хувиас хэтрэхгүй	1%	0.5%, 1.5%	0.1 хувиас 0.8 хувь	0.35%, 0.5%, 0.8%
Борлуулалтын татвар	байхгүй				1.5%, 2.5%, 3.5%, 5%
Бооцоот бизнесийн татвар	Мөрийтэй тоглоомын бизнесээс хамааран хатуу тогтоосон хэмжээ				байхгүй
Тээврийн хэрэгслийн татвар	Тогтмол хэмжээ				Үл хөдлөх хөрөнгийн татварт хамааруулах болсон

¹⁴https://ru.sputnik.md/world_economics/20160526/6884489.html

¹⁵ <https://moluch.ru/archive/147/41363/>

ЕАЭЗХ-ны Чөлөөт худалдааны гэрээ хийх журам ЕХ-ны DCFTA¹⁶ буюу Чөлөөт худалдааны бүс (ЧХБ) байгуулах гэрээнээс илүү хагуу нөхцөлтэй байдгаас гишүүн орнууд өөр эдийн засгийн нэгдэл, байгууллагад элсэх, Холбооноос гадуур бие дааж хоёр талын Чөлөөт худалдааны гэрээ (ЧХГ) хэлцэл хийх боломжгүй, уян хатан бие даасан бодлого явуулах аргагүй байдалд оржээ.¹⁷ Түүнчлэн 2017 оны дөрөвдүгээр сард Беларусь улс ЕАЭЗХ-ны Гаалийн кодыг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан¹⁸ хэдий ч саяхан рублийг хүлээн авахаас татгалзсан¹⁹ явдал дотооддоо зөрчилтэй асуудлууд багагүй байгааг илтгэнэ. Хэдийгээр тус Холбоо зөвшилцөн шийдвэр гаргадаг гэдэг боловч ЕАЭЗХ-ны бусад гишүүн орнуудтай зөвшилцөөгүй Өрнөдийн эсрэг ОХУ эдийн засгийн хориг тавьсан байдаг. Холбооны бусад гишүүн орнууд энэ хориг арга хэмжээнд оролцоогүй юм. Гишүүн орнуудын хувийн бизнес эрхлэгчдэд өгөөжөө одоогоор өгөөгүйгээс гадна бие даан гадаад худалдаа явуулах боломж аажмаар хаагдаж байгаа талаар Казахстаны тал гомдоллох болсон. Тэд гишүүн орнууд тэгш эрхтэй шударга байх зарчим хэрэгждэггүй, маргаан гарсан үед зохицуулах хууль эрх зүйн орчин байхгүй байгааг шүүмжилж байна. Москвагийн зүгээс Евразийн интеграцийг дэлхийн шинэ дэг журамд гол үүрэг гүйцэтгэх интеграц гэж үзэн түүнийг эрчимжүүлэхийг эрмэлзэж, ЕАЭЗХ-ны гол

¹⁶ Deep and Comprehensive Free Trade Area, DCFTA

¹⁷ Кыргызстан улс БНХАУ-тай байгуулсан хувийн бизнес эрхлэгчид гаалийн татваргүй худалдаа эрхлэх талаарх гэрээ нь журмаас хазайсан ганц тохиолдол юм. Энэ нь Москвагийн зүгээс Кыргызстаныг Холбоондоо нэгтгэхийн тулд хийсэн алхам байх магадлалтай.

¹⁸ 2016 оны эцэст болсон ЕАЭЗХ-ны төрийн тэргүүний уулзалтаар Гаалийн кодекст гарын үсэг зурах байсан боловч Беларусын Ерөнхийлөгч ирээгүй төдийгүй тус гэрээг хүлээн зөвшөөрөх эсэхээ саяхан хүргэл мэдэгдэлгүй удсан юм. <https://www.nzz.ch/wirtschaft/eurasische-wirtschaftsunion-ld.137262>

¹⁹ <https://www.business-gazeta.ru/news/347021>

хөдөлгөгч хүч байсаар ирсэн.²⁰ Өнөөгийн байдлаар ОХУ хоёр талын харилцаа (заримдаа Евразийн эдийн засгийн орон зай нэрийн дор) хөгжүүлж ирсэн болохоос засгийн газар хоорондын харилцааны албан ёсны бүтцийг хөгжүүлэхийг эрмэлзээгүй гэсэн шүүмжлэлд өртдөг. Өнгөрсөн онд Вьетнамтай хийсэн ЧХБ-ийн хэлэлцээр нь ЕврАзЭС-ийн орон зайн орнуудын Зүүн Ази, Номхон далайн орнуудтай харилцах механизмын гол тулгуур болгох ОХУ-ын гадаад бодлогын тактикийн чухал асуудал байсан юм. ОХУ-ын ШУА-ийн шинжээч А.Н.Спартакийн үзэж байгаагаар зохион байгуулалттай хөдөлмөрийн дүрвэлт өнөөгийн шатанд ОХУ-ын эдийн засгийн өсөлтийн чухал хүчин зүйл болдог аж. Хэдийгээр энэ талаар Москва ярих дургүй ч өнөөгийн байдлаар ОХУ-ын ДНБ-ий өсөлтийн 6-10 хувийг дүрвэгсдийн хөдөлмөрийн хүч бүрдүүлдэг байна.²¹

ЦААШДЫН ХАНДЛАГА

Карнегийн төвийн судлаачдын үзэж байгаагаар Европын холбоонд багтах орон зай байхгүй гэдгээ Москва харсан учраас 2010 оноос Гаалийн холбоог байгуулж (2015 оноос ЕАЭЗХ гэх болсон) эхэлсэн гэж үздэг. Гаалийн татваргүй худалдаан дээр суурилсан тус Холбоо бат бэх бус бөгөөд ЕХ-г сонирхож байгаа бусад хөрш орнуудыг тус интеграцид татахыг Москва эрмэлздэг байна.²² Оросын зарим шинжээчид алсдаа ЕХ шиг Евразийн холбоо болох том амбицтай тус интеграц ЗХУ-ын туршлагыг давтаагүй ч зарим нэг байдлаар түүний үргэлжлэл мөн гэж үздэг.²³ Евразийн холбооны геополитикийн утгыг Өрнөдийг сөрөх, цаашлаад хуучны ЗХУ-ын үеийн бүрэлдэхүүнд байсан бүс нутагт ОХУ нөлөөгөө эргэн тогтоох бодит урьдчилсан нөхцөл гэж зарим шинжээчид хардаг. Мөн

²⁰ https://ria.ru/defense_safety/20170625/1497250639.html

²¹ <http://eurasia.expert/longreads/eurasia-2017/>

²² Мөн энд

²³ Геополитика и безопасность, 2012, №1(17)

түүнчлэн Арктикийг эзэмшихэд Евразийн холбоо шинэ хүч, нөөцийг бий болгох аж.²⁴ Арктикийн байгалийн баялгийг эзэмших эрхийн төлөөх өрсөлдөөнд түүнтэй хил залгадаггүй орнууд хүртэл оролцох болсон юм.

ЕАЭЗХ-ны хоёр талын шугамаар хөгжиж буй эдийн засгийн хамтын ажиллагааг олон талын хэлбэрт оруулж, бүс нутгийн интеграцын түвшинд хүргэхэд багагүй хугацаа шаардагдана гэж судлаачид үздэг. Тухайлбал, Польшийн стратегийн судалгааны Варшавын төвийн захирал Анджей Талагагын үзэж байгаагаар ТУХН, Хамтын аюулгүй байдлын тухай гэрээний байгууллагын (цаашид ОДКБ гэх) нэгэн адил ЕАЭЗХ амжилттай явагдах үндэслэл бага аж. Учир нь ЗХУ-аас тусгаар болсон тус интеграцын гишүүн орнууд буцаж Москвад захирагдахгүй байхын зэрэгцээ харилцаагаа бас муутгахгүйн тулд үндэстэн хоорондын энэ байгууллагын зорилт, агуулгыг жинхэнээсээ баяжуулах бодолгүйгээр нэгдсэн гэнэ. ОДКБ болон ЕАЭЗХ-ны тусламжтайгаар Оросууд удахгүй Евразид нөлөөгөө бэхжүүлнэ хэмээн Stratfor шинжилгээний төвийн шинжээчид үзжээ.²⁵ ОХУ бүс нутгийн энэ интеграцыг улам өргөжүүлэхийн зэрэгцээ ОДКБ-г Москвагийн Өрнөдийн эсрэг зогсож чадах хүчтэй, дэлхийн хэмжээний их гүрэн гэсэн имижийг бүрдүүлж өгөх тавцан болгох, ОДКБ нь НАТО-г орлох байгууллага гэдгийг харуулахыг хичээж ирсэн, бас ч үгүй энэ зорилгодоо хүрч байгаа аж. Энэ нь ЕАЭЗХ-нд Тажикистанаас бусад ОДКБ-ын гишүүн орнууд нэгдээд байгаагаас харагддаг. Шинжээчид ЕАЭЗХ цаашид цэрэг-улс төрийн нэгдсэн бодлого явуулахыг үгүйсгэхгүй байна. Учир нь Евразийн орон зайд уламжлалт бус аюул нэмэгдэж байгаагаар уялдан ОДКБ-ын орнууд дотоод болон цэргийн асуудлаар

²⁴ Мөн энд

²⁵ <https://www.stratfor.com/article/russia-regains-its-momentum-across-eurasia>

ОХУ-тай урьд урьдаасаа илүү нягт ажиллах шаардлагатай болжээ.

Москва тус Холбоог өргөтгөх, имижийг нь сайжруулахыг ихээхэн хичээдэг. Саяхан Астанад болсон хуралдаан дээр Оросуудын хийсэн мэдэгдэл анхаарал татлаа. Тухайлбал, 2017 оны 08 дугаар сард Астана хотод зохион байгуулагдсан “Евразийн долоо хоног” олон улсын форум дээр ОХУ-ын тэргүүн шадар сайд Игорь Шувалов гэнэтийн хачирхалтай мэдэгдэл хийсэн юм. Тэрээр интеграцын олон асуудлыг шийдвэрлэхэд Казахстан тэргүүлэх үүргийг гүйцэтгэх боломжтойг онцлоод Кремлийн геополитикийн төсөл гэсэн хардлагаас сэргийлэх үүднээс ОХУ тэргүүлэх үүрэгтэй байх нь осолтой байгааг анхааруулж, энэ санааг бусад гишүүн орнууд дэмжинэ гэдэгт итгэж байгаагаа илэрхийлсэн юм.²⁶ Астана түлхэгч хүч болсноор ЕАЭЗХ-ны эдийн засгийн байдал дээрдэнэ гэдэг нь эргэлзээтэй, тэгээд ч эдийн засгийн хүчин чадал, геополитикийн нөлөөгөөрөө Казахстантай харьцуулшгүй гэдгээрээ хүссэн, хүсээгүй ОХУ л ЕАЭЗХ-ны хөдөлгөгч хүч хэвээр байна гэж ажиглагчид дүгнэжээ. Нөгөө талаас сайн дураар гол тоглогч байхаасаа Кремль татгалзаж байгаа нь Өрнөдийн хориг тавигдаагүй Казахстан улс тэргүүлэх үүрэгтэй байх нь Холбооны хөгжилд тустай гэж үзсэнтэй холбоотой байх магадлалтай. Астана гол үүрэг хүлээх болсон талаарх Шуваловын энэ мэдэгдэл ЕАЭЗХ мухардалд орсныг харуулаа гэх судлаачид ч бас байна. Учир нь тус интеграц бүрэлдэх явц ЕХ-г хуулбарлаж байгаагаас өөрийн онцлогтой Евразийн орон зайд зохицохгүй, хөгжил дэвшил авчрахгүй байгаа аж.²⁷

ДҮГНЭЛТ

Одоогоор ЕАЭЗХ-нд нийтийг хамарсан бус зөвхөн хоёр талын харилцаа,

²⁶ <https://svpressa.ru/economy/article/179917/>

<https://www.bundestag.de/blob/427424/566dd431041ef09b939d661bf55ddd7e/wd-5-030-16-pdf-data.pdf>

хамтын ажиллагаа илүү зонхилж байна. ЕАЭЗХ-ны худалдааны үзүүлэлтээс харахад тус Холбооны хамгийн том эдийн засаг болох ОХУ-ын гүйцэтгэх үүрэг тун сул, гишүүн орнуудын эдийн засгийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэхгүй байгаа явдлыг одоогоор цэвэр геополитикийн өрсөлдөөнөөс үүдэлтэй ТУХН-ийн Баруун эсвэл Орос гэсэн сонголт нь тодорхойгүй орнуудыг өөрийн нөлөөндөө нэгтгэх бодлогыг урьтал болгож байгаагийн илрэл юм. Хуучин ЗХУ-ын үеийн техник, технологитой орнуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, эдийн засгийг нь эрчимжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт хийх, шинэ технологи, инноваци нэвтрүүлэх эдийн засгийн хүчин чадал ОХУ-т одоогоор байхгүй гэдэг өнцгөөс харвал Армян, Кыргызстан зэрэг улс хямд байгалийн хий, газрын тос импортлох, дэд бүтцэд Оросын хөрөнгө оруулалтыг татах зорилготойгоор тус Холбоонд нэгдсэн бололтой. ЕХ-ны гишүүн орнууд нэгдсэн зах зээлд шилжиж, амжилттай хөгжсөн нэг гол

шалтгаан нь тарифын бус саад тотгорыг арилгасан явдалд оршдог. Үүний тулд гишүүн орнууд бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн шаардлагад тавигдах нэгдсэн нэг стандарттай болох ёстой. Ийм нөхцөл одоогоор ЕАЭЗХ-д бүрдээгүй тул Холбоон дотроо олон талт харилцаа жинхэнэ утгаараа явагдахгүй байна. Түүнчлэн ЕАЭЗХ-ны гишүүн орнууд Хятад болон бусад оронтой хоёр талын харилцааг түлхүү хөгжүүлж байгаа явдал эдийн засгийн хамтын ажиллагаа өргөжихгүй байх шалтгаан болжээ. Бусад улс, орнууд тус Холбоотой ЧХГ, ЧХБ байгуулах гэсэн сонирхол нь ижил төрлийн бус экспортын бүтээгдэхүүнээ борлуулах шинэ зах зээл гэж харж байгаатай холбоотой. ЕАЭЗХ эрчим хүчний түүхий эдийн худалдаан дээр үндэслэгдсэн, ОХУ-аас бусад нь худалдааны алдагдалтай, техник технологийн хоцрогдолтой орнууд нэгдсэн байгаа нь гишүүн орнуудын эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, үр өгөөжөө ойрын ирээдүйд өгөх нь тодорхойгүй байна.

ЭХ СУРВАЛЖ

- Die Eurasische Wirtschaftsunion, <https://www.bundestag.de/blob/427424/566dd431041ef09b939d661bf55ddd7e/wd-5-030-16-pdf-data.pdf>
- https://ria.ru/defense_safety/20170625/1497250639.html
- Putins Klub ohne Einigkeit, <https://www.nzz.ch/wirtschaft/eurasische-wirtschaftsunion-ld.137262>
- Russia Regains Its Momentum Across Eurasia, <https://www.stratfor.com/article/russia-regains-its-momentum-across-eurasia>
- Делегация Евразийского экономического союза провела переговоры по созданию зоны свободной торговли с Ираном, <http://www.eurasiancommission.org/ru/nae/news/Pages/16-06-2017-4.aspx>
- ЕАЭС-тернистый путь интеграции, https://ru.sputnik.md/world_economics/20160526/6884489.html
- ЕАЭС и все-все-все. Внешний контур становления евразийской интеграции, <http://www.warandpeace.ru/ru/analysis/view/111554/>

- ЕАЭС и Индия начали официальные переговоры по заключению соглашения о свободной торговле, <http://www.eurasiancommission.org/ru/nae/news/Pages/3-06-2017.aspx>
- Евразийский экономический союз в цифрах, http://www.eurasiancommission.org/ru/act/integr_i_makroec/dep_stat/tradestat/analytics/Documents/Analytics_I_201703.pdf
- Евразия 2017. Что ждет евразийское пространство в 2017 году, <http://eurasia.expert/longreads/eurasia-2017/>
- ЕЭК и Китай обсудили перспективы переговоров о торгово-экономическом сотрудничестве, <http://www.eurasiancommission.org/ru/nae/news/Pages/19-05-2017-2.aspx>
- Геополитика и безопасность, 2012, №1(17)
- Зигзаг Шувалова: Командовать парадом в ЕАЭС будет Назарбаев, <https://svpressa.ru/economy/article/179917/>
- Медведев предложил странам Евразийского союза снять барьеры для движения капитала и рабочей силы, <https://www.business-gazeta.ru/news/347021>
- Мухаметшин: Евразийский экономический союз, взгляд в будущее, <https://ru.sputnik.md/economics/20170606/13004009/muhametshin-posol-evrazijskij-jekonomicheskij-sojuz-vzgljad-budushhee.html>
- Нарышкин: более 40 стран желают сотрудничать с ЕАЭС, <http://www.vestifinance.ru/articles/49799>
- Сравнительный анализ налоговых систем Евразийского Экономического Союза в контексте интеграционных процессов, <https://moluch.ru/archive/147/41363/>
- Эдийн засгийн гадаад харилцааны бодлого, http://www.stockholm.mfa.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=32:iii-----&catid=6:2010-02-05-02-15-57&Itemid=15&lang=mn



Д.УЛАМБАЯР Ph.D

ХОЙД СОЛОНГОСЫН ШИНЭ АЮУЛ БА НҮБ-ЫН ШИНЭ ХОРИГ

This article talks about last nuclear or h-bomb test of the DPRK, its outcomes, contents of the un's security council s/res/2375 (2017), impacts on technological development of nuclear and ballistic missile programme of North Korea, financial source, solution of tense situation, unification perspectives of two Koreas and position of Mongolia, etc

НҮБ-ЫН АЮУЛГҮЙН ЗӨВЛӨЛИЙН 2375 ДУГААР ТОГТООЛ БУЮУ ХОЙД СОЛОНГОСЫН ЭСРЭГ ШИНЭ ХОРИГ

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл (АЗ)-ийн 2375 дугаар тогтоолыг 15 гишүүн санал нэгтэй баталлаа. Хойд Солонгос жилд 4.5 сая баррель газрын тос импортоор авдаг ажээ. Тухайлбал, зөвхөн Хятадаас өдөрт 6 мянган баррель импортолдог байна. Шинэ хоригоор Хойд Солонгост нийлүүлж буй газрын тосыг 2.2 сая баррель буюу 50 хувиар танахаар болов. Нэхмэл, оёмол бүтээгдэхүүний экспортыг бүрэн хориглолоо. Тус улс 2016 онд 752.5 сая ам.долларын нэхмэл оёмол бэлэн бүтээгдэхүүн экспортолжээ. Хойд

Солонгосоос Хятадад нийт 2.3 тэрбум ам.долларын нэхмэл, оёмол бэлэн хувцас Энэтхэг 108 сая, Орос 79 сая, Тайланд 74 сая, Пакистан 43 сая, Филиппин 53 сая, Африкийн Буркина Фасо 33 сая ам.долларын хувцас экспортолсон байна. Үүний зэрэгцээ гадаад дахь Хойд Солонгосын 93 мянган иргэдийн мөнгөн шилжүүлгийг бүрэн хориглосон байна. Энэ нь ойролцоогоор 500 сая ам.доллар болж байгаа ажээ. Энэ бол маш том хориг. Тогтоолын анхны хувилбарыг ОХУ, Хятадын талтай зөвшилцсөний

дараа өөрчилж, зарим заалтыг сулруулсан байна. АНУ-ын анхны санал газрын тосны импортыг 100 хувь зогсоох байв.¹

АНУ-ын дангаараа хэрэгжүүлж буй хоригт Хойд Солонгостой худалдаа хийж буй улс орнуудтай АНУ худалдаа хийхгүй, банкны гадаад төлбөр тооцоонд хоригтавих, олон улсын долларын системээс гаргах арга хэмжээ авахаа мэдэгдсэн болно.²

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн баталсан шинэ тогтоолыг “Санаанд багтамгүй бөгөөд түрэмгий бүх арга хэрэгсэл” хэмээн БНАСАУ эрс буруушаан АНУ-ын санаачилсан уг тогтоолыг няцааж байна. Тухайлбал, “хориг арга хэмжээ авах тухай энэ тогтоол манай улсын өөрийгөө хамгаалах хууль ёсны эрхийг хасахад чиглэсэн бузар өдөөн хатгалгын үр дагавар юм” гэж Хойд Солонгосын Гадаад явдлын яамны мэдэгдэлд дурдсаныг тус улсын Төв цахилгаан мэдээний агентлаг уламжилсан байна. “НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шинэ тогтоол БНАСАУ зөв зам сонгосныг нотолж байгаа бөгөөд бид АНУ-тай бодит тэнцвэртэй байдалд хүрэх замаар эх орныхоо тусгаар тогтнох бүрэн эрх, бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хүчин чармайлтаа улам нэмэгдүүлнэ” хэмээн дээрх мэдэгдэлд мөн тэмдэглэжээ. Түүгээр зогсохгүй Пёньян наймдугаар сарын 29-нөөс хойш дахин есдүгээр сарын 15-ны Баасан гарагийн өглөө Японы Хоккайдо арлыг давуулан баллистик пуужингийн туршилтыг хийлээ.³ Пүрэв гарагт Пёньяны төв мэдээллийн агентлаг НҮБ-ын тогтоолыг дэмжсэний төлөө Японыг “живүүлж”, АНУ-ыг үнс нурам болгоно хэмээн сүрдүүлсэн байна.

¹ UN Security Council approves new North Korea sanctions. Sept. 11, 2017

² Matthew Cooper. Mnuchin Threat to China Over North Korea is Empty Because Beijing Owns America's Debt. Newsweek. Sept. 12, 2017

³ Jesse Johnson, Reiji Yoshida. North Korea responds to latest U.N. sanctions with second missile over Japan. The Japan Times. Sept. 15, 2017

БНАСАУ ЦӨМИЙН ЗЭВСЭГТЭЙ УЛС МӨН ҮҮ?

БНАСАУ 2006 оны 10 дугаар сарын 06-нд анх удаагийн цөмийн туршилт хийж, харин 2017 оны есдүгээр сарын 03-нд “устөрөгчийн” бөмбөгийн туршилт буюу зургаа дахь удаагаа цөмийн туршилт хийснээр “де факто” цөмийн зэвсэгтэй, мөн түүнийг алсын зайнд хүргэх баллистик пуужинтай улс боллоо гэж үзэхэд хүргээд байна. Хойд Солонгос 2016 оны нэгдүгээр сарын 06-нд “устөрөгчийн бөмбөг” хэмээх цөмийн төхөөрөмж буюу дөрөв дэх туршилт хийснээ мэдэгдэж байсан ч шинжээчдийн онцолж байснаар тэр нь устөрөгчийн бөмбөгийн гол үзүүлэлт, шалгуурыг бүрэн илэрхийлж чадаагүй аж. Харин 2016 оны тавдугаар сард хуралдсан Хойд Солонгосын Хөдөлмөрийн Намын VII их хурал тус улсыг цөмийн зэвсэгтэй гүрэн хэмээн албан ёсоор зарласан юм. БНАСАУ өөрийгөө дэлхийн улс төрийн бодлогод том тоглогч байх замаа засч, богино хугацаанд өөрийгөө харуулахын тулд бүх аргаа сүвэгчилж, угсаа залгамжилсан шинэ удирдагчаа тодорхой өндөрлөгт гаргаж ирэхийн тулд цэрэг арми, аюулаас хамгаалах хүчин нь дэндүү их хүчин чармайлт гаргаж байна.

Пёньян 2016 оны есдүгээр сард тав дахь цөмийн туршилтаа хийсэн. 2017 оны есдүгээр сарын 03-нд бүртгэгдсэн 6.3 магнитудын чичиргээний үнэлгээ тав дахь туршилтынхаас 5-6 дахин, дөрөв дэх туршилтаас 11 дахин хүчтэй болсон талаар мэргэжилтнүүд урьдчилсан байдлаар тэмдэглэж байна. Сүүлчийн устөрөгчийн бөмбөг хэмээх туршилтын эхний чичиргээнээс хойш найман минутын дараа дахин 4.6 магнитудын хүчтэй хоёр дахь чичиргээ бүртгэгджээ. Туршилтын хүч 60-120 килотон орчим буюу Хирошимад хаясан атомын бөмбөгнөөс гурав дахин хүчтэй байж болзошгүй байна. Энэ удаагийн туршилтын улмаас хиймэл дагуулаас авсан

зураглалаар хөрсний томоохон нурулт буй болж, Пүнгге-ри туршилтын хонгилд нурах аюул үүссэн байх магадлалтай байгаа аж. Хэрвээ нурвал тэнд хуримтлагдсан цацраг идэвхит бодис гадагш тарах аюултайг Өмнөд Солонгосын Сежон институтийн ахлах судлаач Пэк Хак-сон (Paik Hak-soon) хэлжээ.⁴ Туршилт ойр ойрхон үргэлжилбэл Бэктү галт уулыг идэвхжүүлж болзошгүй байгааг ч анхааруулж байгаа юм. Пүнгге-ри туршилтын талбайгаас 114 км зайтай Хятад, Хойд Солонгосын хилд оршдог энэ уул идэвхжиж дэлбэрвэл ноцтой байдал үүсч болох юм.

Устөрөгчийн бөмбөг гэдэг атомын бөмбөгнөөс үлэмж хүчтэй, халуун цөмийн гинжин урвалд орж, нүд сохлом гэрэл гарна. Манай нарны өдөр тутмын амьдрал бол халуун цөмийн гинжин урвал бөгөөд нарны эрчим хүчний эх үүсвэр цөмийн гинжин урвал протон-протон байх бөгөөд энэхүү процессийн үр дүнд устөрөгч гели болон хувирдаг тасралтгүй үйл явц ажээ.

Устөрөгчийн бөмбөгийн туршилтыг анх АНУ 1952 оны 11 дүгээр сард Номхон далайн Маршаллын аралд, ЗХУ 1955 оны 11 дүгээр сард Казахстаны Семипалатинскийн районд, Их Британи 1957 оны тавдугаар сард Номхон далайн Малден аралд, Хятад 1967 оны зургаадугаар сард Шиньжан-Уйгурын Лоб нуурын ойролцоо цөлд, Франц 1968 оны наймдугаар сард Номхон далайн Полинезийн шүрэн арал дээр туршсан байдаг. Зөвхөн АНУ-ын анхны устөрөгчийн бөмбөгийн туршилтын хүч 10.4 мегатон байсан явдал Нагасакид хаясан атомын бөмбөгнөөс 400 дахин илүү хүчтэй аж.

Хойд Солонгосын зохион байгуулсан зургаан туршилтын дөрвийг 2011 онд төрийн эрхийг авсан Ким Жон-Уны үед

⁴ Yi Whan-woo. Fears grow of radiation leak from N. Korea's nuke site. The Korea Times. Sept 11, 2017. <http://www.koreatimes.co.kr/www/nation/2017/09/103236269.html>

зохион байгуулжээ. Өмнө нь 3-4 жилийн хугацаанд нэг туршилт явуулдаг байсан бол Ким Жон-Уны үед найман сарын хугацаанд гурван туршилт хийлээ. Ямар ч байсан Хойд Солонгосын цөмийн болон пуужингийн технологийн хөгжил урагшилж буй нь тодорхой болов.

ХОЙД СОЛОНГОСЫГ ЭЗЛЭН ТҮРЭМГИЙЛЭХЭЭР ЗАНАЛХИЙЛЖ, ХОЁР СОЛОНГОСЫГ ХҮЧЭЭР НЭГТГЭХЭЭР ЗАВДАЖ БУЙ УЛС БИЙ ЮУ?

Пёньяны эрх баригчид Өмнөд Солонгосын тоглоомын дэглэм, АНУ-ын империалистэй хамтран тус улсыг хэзээ мөдгүй эзлэхээр зэхэж байна гэж суртал ухуулга явуулдаг. Иргэд нь ч ийм итгэл үнэмшилтэй байдаг бололтой. Өмнөд Солонгос АНУ-тай хамтран Хойд Солонгосын болзошгүй түрэмгийллээс хамгаалахын тулд хавар, намар “Foal Eagle”, “Key Resolve”, “Max Thunder”, “Ulchi - Freedom Guardian” хамтарсан цэргийн сургуулилт хийдэг. Солонгосын хойгийн status quo хүйтэн дайнаас хойш шийдвэрлэж чадалгүй тунаж үлдсэн цорын ганц цэг, дайн, зэвсэгт мөргөлдөөн гарах магадлалтай газар юм. Гол баталгаа болж байсан ЗХУ задран унасан явдал БНАСАУ улс төрийн дэглэм, үндэсний аюулгүй байдлаа цөмийн хөтөлбөрт дулдуйдан түүнийг хэрэгжүүлснээр хангана гэж үзэх болсонтой холбогддог.

Уг нь бүр 1991 оны есдүгээр сард хүйтэн дайны төгсөл үед НҮБ-ын индрээс АНУ-ын Ерөнхийлөгч эцэг Жорж Буш Өмнөд Солонгост байрлуулсан тактикийн цөмийн зэвсгийн 100 гаруй нэгжийг нийтэд нь тус улсын нутаг дэвсгэрээс бүрмөсөн гаргах нэг талын энхийн санаачилга гаргаж, Зөвлөлтийн удирдагч М.С.Горбачёв энэ санаачилгыг бүрэн дэмжсэн юм. Өмнөд Солонгос АНУ-ын нэг талын санаачилгыг таатай хүлээн авч тухайн үеийн Ерөнхийлөгч Но Тэ-үү

Солонгосын хойгийг Цөмийн зэвсэггүй бүс болгох тухай Тунхаглалыг гаргажээ. Түүнд цөмийн зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх, хадгалах, байршуулах, хэрэглэх, ураныг баяжуулахгүй байх, цөмийн эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглах чиглэлд Олон улсын атомын эрчим хүчний агентлагтай хамтран ажиллахаар заажээ.

Улмаар 1991 оны 12 дугаар сарын 31-нд Солонгосын хойгийг Цөмийн зэвсэггүйжүүлэх БНАСАУ, БНСУ-ын Хамтарсан Тунхаглалд Сөүл хотноо Ерөнхий сайд нарын түвшинд гарын үсэг зурж, 1992 оны хоёрдугаар сарын 19-нд хүчин төгөлдөр болсон юм. Тунхаглалд цөмийн зэвсэг турших, боловсруулах, үйлдвэрлэх, бүтээгдэхүүн болгох, хадгалах, байршуулах, хэрэглэх, уран баяжуулахыг хориглож, цөмийн эрчим хүчийг энхийн зорилгод ашиглахаар заасан байдаг.

Дэлхийн хамтын нийгэмлэг, олон улсын зүгээс ноцтой болгоомжилж буй зүйл бол Хойд Солонгосын удирдлага тун хариуцлагагүй, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлдэггүй явдал гэж үздэг. Хойд Солонгос “чүчхэ” буюу өөрийн хүчинд тулгуурлах үзэл баримталж буй явдал, тус орныг дэлхийн хамтын нийгэмлэгээс тусгаарлах тун хүнд байдалд оруулаад байна. Хойд Солонгос цөмийн хөтөлбөртөө дулдуйдсан бодлого явуулж буй нь одоогийн дэглэм өөрийгөө удаан хугацаанд хадгалж үлдэх гэсэн бодлоготой шууд холбоотой. Ирантай найман жил дайтаж, Кувейтыг түрэмгийлж байсан Саддам Хусейнаар толгойлуулсан Иракийн армийг АНУ бараг хоёрхон долоо хоногийн дотор л бут ниргэсэн бөгөөд дараагийн ээлж нь Хойд Солонгос гэж үзсэн байх магадлалтай.

АНУ, Өмнөд Солонгосын удирдлага хоёр Солонгосыг хүчээр нэгтгэх, Хойд Солонгосын дэглэмийг хүчээр нураахгүй гэдгээ маш тодорхой илэрхийлсэн. Хойд

Солонгосын харьцангуй тогтвортой байдал БНХАУ, ОХУ-д ч ач холбогдолтой. Хойд Солонгос Ойрхи дорнод, Сири лугаа тогтворгүй байдалд орвол солонгосын дүрвэгсэд гэх маш том асуудал үүсч мэдэх юм.

ХОЙД СОЛОНГОСЫН ЦӨМИЙН БОЛОН ПУУЖИНГИЙН ТЕХНОЛОГИЙН ХӨГЖИЛД НӨЛӨӨСӨН ХҮЧИН ЗҮЙЛС

Хойд Солонгосын Ёньбоны цөмийн судалгааны төвийн барилгын ажил зөвлөлтийн мэргэжилтнүүдийн тусламжтайгаар 1965 оноос эхэлж 1974 онд 2 мВ-ын хүчин чадалтай судалгааны реакторыг ашиглалтад оруулж, 1979 онд 8 мВ-ын хоёр дахь реакторын ажил эхэлсэн байдаг. БНАСАУ Зөвлөлтийн Дубна дахь Цөмийн судалгааны нэгдсэн институтэд 1956 онд нэгдэж, мэргэжилтнээ бэлтгэж эхэлсэн бөгөөд 1970 оноос Хятадад бэлтгэж эхэлжээ. Хойд Солонгос зөвхөн 2013 онд 400 мянга, 2014 онд 470 мянга, 2015 онд 530 мянган ам.долларын татвар Дубна дахь Цөмийн нэгдсэн институтэд төлсөн байдаг.⁵ ЗХУ задарсны дараа Украин, Оросын хар зах дээрээс цөмийн болон пуужингийн технологи, мэргэжилтнүүд олж авсан гэсэн бодитой хардлага байдаг. 1974 онд МАГАТЭ-д элсч, 1985 онд Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээнд нэгдэж, 1993 онд гарч, 1994 онд буцаж нэгдэн, 1995 онд Солонгосын хойгийн эрчим хүчний хөгжлийн байгууллага KEDO байгуулагдаж, эрчим хүчний гүн хямралд байсан үед Хойд Солонгосын зөвлөлтийн үеийн бал чулууны цөмийн эрчим хүчний реакторыг хөнгөн усны реактораар шинэчлэх ажил АНУ, Япон, БНСУ болон ЕХ-ны дэмжлэгтэйгээр эхэлсэн юм. Гэвч энэ ажил мөн л бүтэлгүйтсэн. 2003 онд

⁵ Россия Сегодня. Россию подозревают в нарушении резолюции Совбеза. На российских ядерных объектах обучаются специалисты из КНДР <http://inosmi.ru/politic/20141202/224616447.html>

үл дэлгэрүүлэх гэрээнээс дахин гарсан. 2007 онд зургаан талт хэлэлцээнээс гарч, 2009 онд МАГАТЭ-гийн шинжээчдийг нутгаасаа гаргасан. Энэ нь байнга давтагдаж ирсэн өдөөн хатгалга-хориг-яриа хэлэлцээ-буулт-тусламж гэсэн хэвшмэл арга барил үеэ өнгөрөөсөн байна.

САНХҮҮЖИЛТЫН ЭХ СУРВАЛЖ

2005 онд Өмнөд Солонгос, АНУ-ын тагнуулын байгууллага одоогийн залуу удирдагчийн эцэг Ким Жон-Илийн Макаогийн оффшор дахь Vanco Delta Asia банкны 50 дансанд тараан байрлуулсан 25 сая ам.долларыг илрүүлэн тэдгээр дансыг хаахыг БНХАУ-д шаардаж байсан бөгөөд удалгүй тэрхүү мөнгийг царцаасан. Үүний хариуд Умард Солонгос холын тусгалтай пуужин хөөргөж, 2006 онд анхны цөмийн туршилтаа хийсэн юм. 2008 оны хоёрдугаар сард БНСУ-ын Ерөнхийлөгч Ий Мён-Пак үүрэгт ажилдаа орсны дараа АНУ, БНСУ-ын тусгай албадын хамтран явуулсан эрчимтэй ажиллагааны үр дүнд оффшор бүс болох Макао, Лихтенштейн, Люксембург, Австри, Швейцарь, Сингапур, Карибын тэнгисийн банкинд гадаадын иргэний болон гадаадын компанийн өөр өөр нэрээр 200 гаруй дансанд байршуулсан галт зэвсэг, мансууруулах бодис, хар тамхины хууль бус наймаа, хуурамч мөнгө солилуулах, тамхи, ликорын худалдаанаас олсон дөрөв орчим тэрбум ам.долларыг илрүүлсэн байдаг. Тэдгээр нууц дансны ард одоогийн удирдагч Ким Жон-Ун байгаа нь тодорхой болсон бөгөөд зарим дансыг түүний эцэг Ким Жон-Илийг амьд сэрүүн байх үед нээжээ. Ким Жон-Илийн хамгийн ойрын итгэлтэй туслах, түүний далайн чанад дахь хууль бус ажиллагааг санхүүжүүлдэг нууц сангийн ерөнхий менежерээр олон жил ажилласан Жонь Ил-Чун Хойд Солонгосоос дүрвэсэн бөгөөд тэрбээр мэдэгдэхдээ, Пёньянаас ОХУ дахь Хойд Солонгосын ЭСЯ-нд их хэмжээний хуурамч мөнгийг шилжүүлж байсан

хийгээд 2008 онд Орост 30 сая ам.доллартай тэнцэх хуурамч мөнгийг эргэлтэд оруулж угаасан тухай нотолсон байдаг. Тэрээр цааш нь Хойд Солонгосын төрийн агентлаг Оросын зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлүүдтэй хамтарч хилийн чанадад Ким Жон-Илийн нууц сангийн халхавчаар санхүүгийн янз бүрийн ажиллагаа явуулж их хэмжээний хуурамч мөнгө угаадаг болохыг мэдэгдсэн байдаг. Урьд нь АНУ-ын хоригт орсон Хойд Солонгосын халхавч компани болох Daedong Credit Bank, түүний гүйцэтгэх захирал Ким Чол-Сам, хамтрагч Британийн иргэн Негил Кови /Negil Cowie/ нарын мэдээлэл 2016 оны дөрөвдүгээр сард Панамын баримт бичгүүдэд ил болсон юм. Цөмийн болон пуужингийн хөтөлбөрийн санхүүжилтэд мэдээж нүүрс болон бусад барааны экспортын орлого, гадаад дахь иргэдийн мөнгөн шилжүүлэг чухал үүрэгтэйг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

Хойд Солонгос 2000 онд Пёньянд зохиогдсон хоёр солонгосын анх удаагийн дээд уулзалтын болзолд Өмнөдөөс 400 сая ам.доллар авч тэр нь цөмийн хөтөлбөрт зориулагдсан хэрэг тодорхой болж 2005 онд ноцтой шуугиан дэгдэж байсан юм.

ХУРЦАДМАЛ БАЙДЛААС ГАРАХ ШИЙДЭЛ

Ким Жон-Ун-ийг хэлэлцээний ширээнд суулгах нэг арга бол түүний хийж буй үйлдлийн үр дагаврыг түүнд тодорхой харуулах явдал гэж АНУ үзэж байна. Д.Трамп Хойд Солонгос дайтахыг “гуйгаад” байна, “стратегийн тэвчээр” барагдлаа гэж мэдэгдэв. Үүнийг Батлах хамгаалахын сайд Жеймс Мэттис “... том хохирол гарна, ганцхан зүйл өөрчлөгдөх нь тодорхой. Одоогийн дэглэм нуран унана ...” гэж маш тодорхой хэлсэн юм.

“Зургаан талт хэлэлцээ”-ний хэлэлцэх үндсэн асуудал юун дээр төвлөрөх вэ гэдэг өнөөдөр тун ойлгомжгүй байна. Хэлэлцээ сэргэсэн тохиолдолд хэлэлцэх

хэргийн төлөвлөгөө Хойд Солонгосын цөмийн хөтөлбөрийг зогсоох асуудал лав биш болов уу. В.Путины хэлсэнчлэн хар ус ууж, хагд өвс идсэн ч цөмийн хөтөлбөрөөсөө ухрахгүй бололтой. Урагштай байж болохуйц гарц бол хоёр Солонгосын өндөр дээд төлөөлөгчид эхний ээлжинд, дараа нь Хойд Солонгос-АНУ хоёр VIS-A-VIS-ийн зарчмаар асуудлыг хэлэлцвэл боломжтой гарц байх магадлалтай. БНХАУ, ОХУ хоёр АНУ, БНАСАУ шууд яриа хэлэлцээ явуулах, хамтарсан цэргийн сургуулилтаа зогсоох, ТНААД системийг татан буулгахыг санал болгож байна. АНУ энхийн гэрээ байгуулах, шууд яриа хэлэлцээ хийхийн тулд Пёньян эхлээд цөмийн хөтөлбөрөө бүрэн зогсоох шаардлага тавьдаг.

Саяхан ХБНГУ-ын канцлер А.Меркель 2015 онд Ирантай байгуулсан цөмийн хөтөлбөрийг царцаах P5+1 хэлэлцээрийн механизмыг санал болгосныг анхаарч болох асуудал.

Хэрэв Хойд Солонгос Гуамд цохилт хийхэд хүрвэл Их Британийн Ерөнхий сайд Терезе Мэй саяхан Японд айлчлах үеэрээ мэдэгдэхдээ "...АНУ НАТО-гийн гишүүн. Умард Атлантын гэрээний тав дахь зүйлд "гишүүн оронд довтолбол гишүүн бүх оронд довтолсон гэж үзнэ" гэсэн заалтыг онцолж Атлантын болон Номхон далайн зааг хязгаар байхгүйг тэмдэглэсэн байна.

ХОЁР СОЛОНГОС ИРЭЭДҮЙД НЭГДЭХ ТӨЛӨВ

Судалгаагаар Өмнөд Солонгост Хойд Солонгостой энхтайвнаар нэгдэх хүсэлтэй иргэдийн тоо зогсолтгүй буурч тодруулбал, хойд нутагт төрсөн, ах дүү, садан төрлийн хэлхээ холбоотой бүхэл бүтэн үе нэгэнт дуусч байгаа аж. Өөрөөр хэлбэл тэдгээрийг нэгтгэж байсан гол хэлхээс үгүй болов. Эдүгээ хоёр Солонгосыг бүх талаараа хоёр өөр улс, үндэстэн гэж хэлж болно.

Солонгосын нэгдлийг Германы нэгдэлтэй харьцуулшгүй. Ер нь нэгдэх үйл явцын яриа хэлцэл XXI зууны туршид үргэлжилж магадгүй.

МОНГОЛ УЛСЫН БАЙР СУУРЬ

Солонгосын хойгийн хурцадмал байдал Монгол Улсад шууд болон шууд бусаар нөлөөлнө. Солонгосын хойгийн хурцадмал байдал ноцтой даамжирвал Өмнөд Солонгост ажиллаж, сурч, амьдарч буй 30 гаруй мянган монгол иргэдийн аюулгүй байдлын асуудал шууд хөндөгдөнө. Зөвхөн эдгээр иргэн жилд дунджаар 90-100 сая ам.долларыг (Олон улсын хөдөлмөрийн байгууллагын тайлангаар 2014 оны байдлаар дэлхийн хэмжээнд 583 тэрбум ам.доллар гуйвуулсан байна) эх орон руугаа гуйвуулдаг гэж тооцож үзэхэд ямар олон айл, гэр бүлийн амьдрал, бизнес, Монгол Улсын нийгэм-эдийн засгийн хөгжилд чухал нөлөө үзүүлж буй нь тодорхой.

Монгол Улс нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс хэмээн зарлаж, цөмийн зэвсгээс ангид статусаа олон улсын тавцанд баталгаажуулах чиглэлээр хүчин чармайлт гаргаж буй боловч Хойд Солонгосын сүүлийн үед гаргаж буй цөмийн болон баллистик пуужингийн заналхийлэлд маш идэвхгүй байр суурь баримталж байгааг тэмдэглэх хэрэгтэй.

НҮБ-ын АЗ дэх P5 "Цөмийн зэвсгээс ангид Монгол Улсын статусын талаарх хамтарсан Тунхаглал", дурьдсан статусын агуулгыг тодорхойлсон Монгол Улсын Тунхаглалд 2012 оны есдүгээр сарын 17-ны өдөр Нью Йорк хотноо тус тус гарын үсэг зурсан билээ. Дээрх баримт бичиг дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулсан, цөмийн зэвсэгтэй гүрнүүд цөмийн зэвсэггүй орнуудтай хэрхэн хамтран ажиллах боломжтойг харуулсан, цөмийн зэвсгийг хорогдуулах үйлсэд хувь нэмэр оруулж байгаагаараа ач холбогдолтой. P5

гаргасан Хамтарсан Тунхаглалдаа Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид статусын тухай хуулийг сайшааснаа анх удаагаа албан ёсоор мэдэгдсэн бөгөөд тэд Монгол Улсын статусыг хүндэтгэж, түүнийг зөрчих аливаа үйл ажиллагаанд оролцохгүй, тийм үйл ажиллагаа явуулахгүй байх амлалтыг Монголын талын саналаар тунхаглалд тусгасан юм. P5 Монголын энэхүү өвөрмөц статусыг бүрэн хүлээн зөвшөөрөн хүндэтгэж, түүнийг зөрчих аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх амлалт авсан нь улс төр-дипломатын чухал ач холбогдолтой үйл явдал болсноос гадна, P5 тодорхой асуудлаар нэгдмэл байр суурьтай байгаагаа дэлхий дахинд харуулсан явдал чухал ач холбогдолтой болсон билээ. Цөмийн зэвсэгтэй гүрнүүдээр хүрээлэгдсэн, цөмийн зэвсэггүй улс аюулгүй байдлаа хэрхэн баталгаажуулж болох Монгол Улсын энэхүү парадигм Солонгосын хойгийг ирээдүйд цөмийн зэвсгээс ангид бүс болгох хэрэгт чухал загвар болох боломж, магадлал байгаа юм.

Монгол Улс өөрийн санаачилгаа

Хойд Солонгосын талаар явуулж буй их гүрнүүдийн бодлоготой нягт уялдуулах шаардлага байгаа.

Өөр нэг асуудал нь Монгол Улсын энхийн зууч хийх магадлал юм. АНУ, БНАСАУ-ын төлөөлөгчид 2014 оны тавдугаар сард Улаанбаатар хотноо 2 дугаар сувгийн уулзалт хийж, зургаан талын хэлэлцээ зэрэг БНАСАУ-ын цөмийн асуудлыг хэлэлцэж байсан билээ. Дурдсан уулзалтад БНАСАУ-ын Гадаад хэргийн дэд сайд бөгөөд зургаан талын хэлэлцээний асуудал хариуцсан тусгай төлөөлөгч Ри Юн-хо (эдүгээ БНАСАУ-ын Гадаад хэргийн сайдаар ажиллаж буй Д.У) Зэвсэглэлийг хорогдуулах судалгааны хүрээлэнгийн зөвлөх гэсэн албан ёсны бус статусаар оролцжээ. АНУ-ын талаас Төрийн департаментын БНАСАУ-ын асуудал хариуцсан төлөөлөгч асан, Жонс Хопкинсийн их сургуулийн Олон улсын харилцааны сургуулийн судлаач Жоел Вит тэргүүтэй төлөөлөгчид оролцож байсан юм.⁶ Бид энэ чиглэлд дипломат ажиллагаагаа идэвхжүүлэх шаардлага бий.

⁶ "Track 1.5" US-N. Korea talks being held in Mongolia by Park Hyun, Washington correspondent and Gil Yun-hyung, Tokyo correspondent. The Hankyoreh. May 22, 2017



Л.БЯМБАХАНД

НАТО-ГИЙН ТҮНШЛЭЛИЙН ХЭЛБЭРҮҮД, МОНГОЛ-НАТО-ГИЙН ХАРИЛЦАА

Mongolia attempts to balance the influence of its two direct neighbours China and Russia with third parties. The relations between Mongolia and the North Atlantic Treaty Organization fall within the realm of the 'Third Neighbour' policy. Mongolia signed the Individual Partnership and Cooperation Programme with NATO in 2012 and ascended to become a 'partner across the globe'. However, concrete relations with NATO had been underway long before that. Mongolia has deployed troops to NATO-led missions in both Afghanistan and Kosovo.

This article explains partnership formats of NATO outside its region, focusing on partners across the globe. The second part of article is purported to examine Mongolia-NATO relations in changing security environment while providing practical recommendations to enhance this cooperation horizontally.

ОРШИЛ

Дэлхийн аюулгүй байдал, энх тайвныг нэг улс буюу эвсэл холбоо дангаараа шийдвэрлэдэг үе хэдийнэ ард үлдэж, өнөөдөр бид харилцан хамааралтай аюулгүй байдал, хамтын ажиллагааны ертөнцөд амьдарч байна. Энэ хандлага ч Умард Атлантын эвсэл (НАТО)-ийн үйл

ажиллагаанд ажиглагдаж ирсэн. НАТО дан ганц батлан хамгаалах, цэргийн зорилготой байсан нь өөрчлөгдөж, хямрал, мөргөлдөөнийг шийдвэрлэх, түүнээс сэргийлэх, бүтээн байгуулах, хөгжлийн чиглэлд анхаарал хандуулан хүний аюулгүй байдлыг хангахад үйл ажиллагаагаа

чиглүүлэх болсон.

Түүнчлэн, даяарчлалыг дагалдаад аюулгүй байдлын шинэ орчин, нөхцөл бүрэлдсэний улмаас үндэстэн дамнасан аюултай тэмцэх явдал хэзээ хэзээнээс илүү тулгамдах болов. Аюулгүй байдлын өөрчлөгдөж буй орчин нөхцөлд дасан зохицох гэсэн НАТО-гийн оролдлого Монгол Улсыг олон тулгуурт гадаад бодлогынхоо хүрээнд “Туравдагч хөрш”-ийн орнуудтай идэвхтэй харилцах боломж олгосон юм.

Энэхүү толилуулан буй өгүүллийн эхний хэсэгт “хүйтэн дайн”-ы дараах НАТО-гийн түншлэлийн хэлбэрүүд, түүний дотор даяарын түншлэлийн талаар товч дурдана. Дараагийн хэсэгт Монгол-НАТО-гийн харилцааны хөгжил, өнөөгийн байдлын талаар тоймлож, улмаар түүнтэй холбогдуулан зохиогчийн зүгээс Монгол-НАТО-гийн харилцааг хөгжүүлж болох салбар, чиглэлийн саналаа танилцуулах болно.

НАТО-ГИЙН ТҮНШЛЭЛИЙН ХЭЛБЭРҮҮД:

Дэлхийн түүхээс үзэхэд, илэрхий сөрсөн хүчин бий болсон буюу эсвэл аюул заналхийлж буй нөхцөлд түүнийг сөрөх зорилгоор цэргийн эвсэл, холбоо үүсдэг. Харин аюулгүй байдалд заналхийлж буй хүчин буюу аюул үгүй болбол цэргийн эвсэл оршин тогтнох шаардлагагүй болно. “Хүйтэн дайн”-ы дараа Варшавын гэрээний байгууллага, ЗХУ задарснаар Умард Атлантын эвслийн оршин байх зорилго үндсэндээ үгүй болсон. Гэвч НАТО өнөөг хүртэл үйл ажиллагаагаа явуулсаар байна. Энэ нь тус байгууллага аюулгүй байдлын орчны өөрчлөлтөд дасан зохицож чадсанд оршино. НАТО зорилго, зорилтоо шинээр тодорхойлон, терроризм, цөмийн зэвсэг дэлгэрүүлэхийн эсрэг тэмцэх зорилготой ажиллагаа явуулж, гүйцэтгэх болсон. Аюулгүй байдлын өөрчлөгдөж буй орчин

нөхцөлд нийцүүлэн Умард Атлантын эвсэл бүтэц, бүрэлдэхүүнээ өөрчлөн, богино хугацаанд хүчээ байрлуулах боломжтой байхаар зохион байгуулав. Нөгөөтэйгүүр, “хүйтэн дайн”-ы дараа эвсэлд багтаж байсан орнууд дийлэнх нь НАТО-г хэвээр үлдээхийн төлөө байсан. Тухайлбал, тэр үеийн Их Британийн Ерөнхий сайд М.Тетчер “амьдардаг гудамжинд чинь сүүлийн 12 сард цөөн хулгайч үзэгдэх боллоо гээд даатгал хийлгэхээ болих нь тэнэг хэрэг” хэмээн НАТО-г тараахын эсрэг буйгаа илэрхийлж байсан удаатай.¹

2010 оны 11 дүгээр сард чуулсан Лисабоны дээд хэмжээний уулзалтын үеэр баталсан НАТО-гийн шинэ Стратегийн үзэл баримтлалд “хамтын ажиллагааны аюулгүй байдал” (cooperative security)-ыг тус эвслийн үндсэн гурван үүргийн нэг хэмээн тодорхойлов. Энэ нь Евро-Атлантын аюулгүй байдал дэлхий даяарх улс, байгууллагуудтай түншлэлийн харилцаа тогтоосноор бүрэн хангагдана гэж үзсэнтэй холбоотой. Өнөөдөр ямар ч улс эсвэл байгууллага аюулгүй байдлын хувьсан өөрчлөгдөж буй орчны олон талтай, тааварлахад бэрх сорилтуудыг дангаараа шийдвэрлэх боломжгүй. Харин харилцан зохицуулсан олон талт үйл ажиллагааны хүрээнд тэдгээр сорилтыг давах шаардлагатай хэмээн НАТО-гийн орнууд үзэж байна. Тиймээс гишүүн биш боловч НАТО-гийн зорилго, үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулж буй орнууд, түүний дотор терроризм, шинээр гарч ирж буй аюулгүй байдлын сорилтуудын эсрэг НАТО-гийн тэргүүлсэн ажиллагаанд оролцож буй орнуудтай улс төр, аюулгүй байдлын асуудлаар яриа хэлэлцээ өрнүүлж, бодит хамтын ажиллагаа хөгжүүлэхийг эвслийн зүгээс эрмэлзэж байна.

Евро-Атлантын бүс чиглэлд НАТО 50

¹ The Brookings “NATO’s Purpose After Cold War” <https://www.brookings.edu/wp-content/uploads/2016/06/reportch1.pdf> (accessed Sep 18, 2017)

улсыг эгнээндээ нэгтгэсэн Евро-Атлантын түншлэлийн зөвлөл² (Euro-Atlantic Partnership Council)³ болон тус бүс нутгийн түншлэгч орнуудтайгаа хоёр талын хамтын ажиллагаа явуулдаг гол хөтөлбөр болох Энхийн төлөө түншлэл⁴ (Partnership for Peace)-ээр дамжуулан улс орнуудтай харилцаж байна. Үүний зэрэгцээ Орос, Украин, Гүрж улстай тусгай бүтэц үүсгэн хамтран ажилладаг. Умард Атлантын эвсэл Газар дундын тэнгисийн өмнөд эргийн орнуудтай Газар дундын яриа хэлэлцээ⁵ (Mediterranean Dialogue Istanbul)⁶, Булангийн орнуудтай Истанбулын хамтын ажиллагааны санаачилга⁷ (Istanbul Cooperation Initiative)⁸-ын механизмаар харилцаж байна.

² Тус зөвлөлд НАТО-гийн гишүүн 29 улс болон гишүүн бус 21 улс багтдаг. Зөвлөлийн хүрээнд элчин сайд нарын уулзалт сар бүр, гадаад хэрэг сайд, батлан хамгаалах сайд, жанжин штабын дарга нарын уулзалт жил тутам тогтмол болж байна. Мөн зарим тохиолдолд төр, засгийн тэргүүн нарын дээд хэмжээний уулзалт зохион байгуулдаг.

³ NATO “Euro-Atlantic Partnership Council” (June 17, 2017) http://www.nato.int/cps/en/natohq/topics_49276.htm (accessed Sep 18, 2017)

⁴ 1994 онд санаачилсан энэ түншлэлийн хэлбэрийн хүрээнд улс орнууд НАТО-тай хоёр талаар харилцах тэргүүлэх зорилтууд, түвшин, үе шатаа сонгон түншилдэг.

⁵ Энэхүү яриа хэлэл цээний механизмыг 1994 онд санаачилсан бөгөөд эвслийн гишүүн бус Алжир, Египет, Израил, Йордан, Мавритан, Марокко, Тунис зэрэг улс оролцдог.

⁶ NATO “Mediterranean Dialogue” (Feb 13, 2015) http://www.nato.int/cps/en/natohq/topics_60021.htm? (accessed Sep 18, 2017)

⁷ Туркийн Истанбулд 2004 онд хуралдсан НАТО-гийн дээд хэмжээний уулзалтаас гараагаа эхэлсэн энэхүү санаачилга нь НАТО-тай хоёр талын бодит хамтын ажиллагаа өрнүүлэх замаар дэлхийн болон бүс нутгийн энх тайван, аюулгүй байдалд хувь нэмрээ оруулах боломжийг Ойрхи Дорнодын бүс нутгийн орнуудад олгодог. Санаачилгад Булангийн зургаан орныг бүгдийг урьсан боловч одоогоор Бахрейн, Катар, Кувейт, Арабын нэгдсэн Эмират улс нэгдэн орсон. Харин Саудын Араб, Оман улс сонирхлоо илэрхийлжээ.

⁸ NATO “Istanbul Cooperation Initiative” (Nov 11, 2010) http://www.nato.int/cps/en/natohq/topics_58787.htm? (accessed Sep 18, 2017)

Дээр дурдсан хамтын ажиллагааны механизмд хамрагдаагүй бусад оронтой даяарын түнш (partner across the globe) хэмээх хамтын ажиллагааны хэлбэрийн хүрээнд харилцдаг бөгөөд үүнд Австрали, Афганистан, БНСУ, Ирак, Колумб, Монгол, Пакистан, Шинэ Зеланд, Япон улс багтана.⁹ 1990-ээд оноос эхлэн НАТО түншлэлийн хамтын ажиллагааныхаа гадна үлдсэн улсуудтай ad-hoc хэлбэрээр яриа хэлэлцээ өрнүүлж ирсэн. НАТО бүс нутгаасаа гадна Афганистан, Ливи зэрэг улсад ажиллагаа явуулах болсноор түншлэлийн гаднах орнуудтай хамтран ажиллах шаардлагатай болсон. Түүнчлэн, терроризм, цөмийн зэвсгийн дэлгэрэлт, далайн дээрэм, цахим халдлага зэрэг шинээр бий болсон сорилтыг амжилттай шийдвэрлэхэд улс орнуудтай өргөн хүрээнд түншлэхээс өөр аргагүйд хүрэв. НАТО 1998 оноос түншлэлийнхээ аль нэг хэлбэрт хамрагдаагүй улсуудыг өөрийнхөө үйл ажиллагаа, дадлага, сургууль зэрэгтээ урьж оролцуулах болжээ. Ингэснээр Умард Атлантын эвслийн бодлогод өөрчлөлт гарч, тус бүртэй нь тохиролцон үүсгэсэн бүтцийн хүрээнд Умард Атлантын Зөвлөлийн шийдвэрийн дагуу НАТО улс орнуудтай хамтын ажиллагаа явуулж эхлэв. Ийм орнуудыг “харилцаа холбоотой орнууд” (contact countries) гэж нэрлэж байсан юм. 2006 оны Ригагийн дээд хэмжээний уулзалтын үеэр НАТО түншлэгч орнуудтай хөгжүүлж буй хамтын ажиллагааныхаа ач холбогдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хэд хэдэн арга хэмжээ авсан бол 2008 оны Бухарестын дээд хэмжээний уулзалтаар өмнөх уулзалтын шийдвэрийг баталгаажуулан, эдгээр хамтын ажиллагааны зорилго, улс төрийн яриа хэлэлцээ явуулах арга замыг тодорхойлов. Ингэснээр холбогдох орнуудын сайд нар Умард Атлантын зөвлөлтэй тогтмол уулзалт, өндөр дээд хэмжээний айлчлал зохион байгуулах

⁹ NATO “NATO Partnerships” <http://www.natolibguides.info/partnerships> (accessed Sep 18, 2017)

боломжтой болсон. Түүнчлэн, түншлэгч улс орон бүрт тохирсон жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан, хэрэгжүүлж эхэллээ. Лисабоны дээд хэмжээний уулзалтын дараа НАТО түншлэлийн бодлогоо эргэн харж, 2011 оны дөрөвдүгээр сард шинэчилсэн.¹⁰

МОНГОЛ УЛС-НАТО-ГИЙН ХАРИЛЦААНЫ ХӨГЖИЛ

Манай улс 1995 оноос эхлэн тус байгууллагатай албан бус уулзалт хийж эхэлсэн бөгөөд 1998 онд АНУ-ын Конгрессоос Монгол Улсыг НАТО-гийн Энхийн төлөө түншлэлд нэгдэн орохыг 60 тоот тогтоолоороо урьсан юм. Ингэхдээ Монгол Улсын ардчилал, гадаад харилцааны ололтыг өндрөөр үнэлэн ийм шийдвэр гаргасан билээ. Энэ бол НАТО-гийн зүгээс Монгол Улсыг сонирхож буйн илрэл байсан боловч манай улс түншлэлийн энэ хэлбэрт нэгдэн ороогүй билээ. Үүнд хамгийн гол тээг болж байсан зүйл нь тухайн үед манай улс Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны гишүүн биш байсан явдал байв.¹¹

Манай зэвсэгт хүчин энхийг дэмжих ажиллагаанд 2005 оноос оролцож эхэлснээр НАТО-тай илүү өргөн хүрээнд хамтран ажиллах боломж бүрджээ. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн Косовод НАТО-гийн тэргүүлэн явуулсан ажиллагаанд 2005 оны 12 дугаар сараас 2007 оны гуравдугаар сар хүртэл үүрэг гүйцэтгэж байв. Улмаар Монгол Улс Афганистан дахь НАТО-гийн тэргүүлсэн Аюулгүй байдалд дэмжлэг үзүүлэх олон улсын хүчин (ISAF)-д 2010 оны гуравдугаар сараас цэргээ илгээж эхэлсэн. Ингэснээр Монгол Улс НАТО-гийн Афганистан дахь ажиллагаанд

¹⁰ NATO “Relations with Partners across the Globe” (May 19, 2019) http://www.nato.int/cps/en/natohq/topics_49188.htm (accessed Sep 18, 2017)

¹¹ О.Машбат, Монгол Улс, НАТО-гийн харилцаа, өнөөгийн байдал, хэтийн төлөв, ашиг сонирхлын нийцэл, Стратеги судлал 2004 (2): 65

цэргээ хандивласан 45 дахь улс болсон юм.¹² Манай улс анх Олон улсын аюулгүй байдлын хүчний Хойд бүсийн командлалд явган цэргийн батальон илгээж байсны зэрэгцээ Афганистан дахь Сургалтын хүчинд явган цэрэг, их буу, агаарын хүчний сургагч нараа илгээж байсан туршлагатай.

Монгол Улс, НАТО Түншлэл, хамтын ажиллагааны хөтөлбөрт 2012 оны гуравдугаар сард гарын үсэг зурж, НАТО-гийн даяарын түнш болсон. Түншлэл, хамтын ажиллагааны хөтөлбөрт зааснаар хоёр тал харилцан ажиллах чадвараа нэмэгдүүлэх, дэлхий нийтийн өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хямрал, мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, түүнийг зохицуулах механизм бий болгох, чадавх бэхжүүлэх чиглэлд хамтран ажиллахаар тохиролцсон юм.¹³

Өнгөрсөн хугацаанд Умард Атлантын эвслийн өндөр дээд хэмжээний цөөнгүй албан тушаалтан Монгол Улсад айлчилж байв. Тухайлбал, НАТО-гийн Олон улсын цэргийн штабын Ерөнхий захирал, дэслэгч генерал Юрген Борнеманн 2011 оны есдүгээр сард, НАТО-гийн Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч, генерал Жэймс Аппатурай 2011 оны тавдугаар сард, Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч, Элчин сайд Александр Вершбоу 2014 онд тус тус манай улсад айлчилжээ. Үүний зэрэгцээ, Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2010 онд болсон НАТО-гийн Лисабоны дээд хэмжээний уулзалтад оролцож байв.

МОНГОЛ УЛС-НАТО-ГИЙН ХАРИЛЦААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ:

Монгол, НАТО-гийн харилцааг

¹² NATO “Mongolia becomes the 45th nation contributing troops to the NATO-led mission in Afghanistan” (March 29, 2010) http://www.nato.int/cps/en/natohq/news_62450.htm (accessed Sep 18, 2017)

¹³ http://www.nato.int/cps/en/natohq/topics_85297.htm (accessed Sep 18, 2017)

тоймлон авч үзвэл дараах гурван чиглэлээр хөгжиж байна. Үүнд:

Нэгдүгээрт, Монгол Улсын НАТО-тай тогтоосон харилцаа манай улс төрийн харилцааны нэг хэсэг. НАТО-тай харилцаж байгаа нь аливаа нэг улсын эсрэг тус байгууллагатай эвсэж буй хэрэг огтоос биш юм. Харин энэ нь ардчилал, хүний эрх, эрх чөлөө зэрэг нийтлэг үнэт зүйлд тулгуурласан улс төрийн харилцаа билээ. Нөгөөтэйгүүр, НАТО-гийн Афганистан дахь ажиллагаа бүс нутгийн энх тайван, аюулгүй байдалд заналхийлэгч терроризмтой тэмцэхэд чиглэсэн бөгөөд тус эвсэлтэй хамтран ажилласнаар Монгол Улс “аюулгүй байдлыг хэрэглэгч” бус харин түүнийг үйлдвэрлэгч болж, дэлхийн энх тайван, аюулгүй байдалд хувь нэмрээ оруулж байгаа юм.

Хоёрдугаарт, НАТО нь Монгол Улс “Гуравдагч хөрш”-ийн орнуудтай харилцах талбар болж байна. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд заасан “Гуравдагч хөрш”-ийн бодлого өрнө, дорнын ардчилсан, өндөр хөгжилтэй орнуудтай хамтран ажиллах замаар хоёр хөршийн нөлөөг саармагжуулах зорилготой. Гэвч энэ бодлого нь ямар нэг байдлаар хоёр хөршийн эсрэг чиглээгүй, зөвхөн тэднээс хамаарах эдийн засгийн болон бусад хамаарлыг бууруулахад чиглэсэн. Иймээс дээр дурдсан зорилгод нийцүүлэн Монгол Улс “Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд Умард Атлантын эвсэлд багтах орнуудтай улс төрийн салбарт идэвхтэй харилцахын зэрэгцээ НАТО-гийн энхийг сахиулах ажиллагаанд оролцох зэргээр тус байгууллагын хүрээнд ч хамтран ажиллаж байна. Тухайлбал, НАТО-гийн хүрээнд Монгол Улс АНУ, ХБНГУ, Франц, Их Британи, Бельги, Польш, Турк, Нидерланд зэрэг “гуравдагч хөрш”-ийн оронтой хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлж байна. Афганистан дахь Аюулгүй байдалд дэмжлэг үзүүлэх олон

улсын ажиллагааны хүрээнд Монгол Улсын Зэвсэгт хүчин ХБНГУ, Бельгийн Вант улс, АНУ-ын цэргийн хүчнүүдтэй хамтран баазын аюулгүй байдал, нисэх онгоц хөөрөх болон буух үеийн нисэх зурвасын харуул хамгаалалт, ойрын зайн өдөр, шөнийн эргүүл хийх зэрэг үүргийг гүйцэтгэсээр ирсэн.¹⁴

Гуравдугаарт, Монгол Улс НАТО-тай шинжлэх ухаан, технологи, сургалтын чиглэлээр түлхүү хамтран ажиллаж байна. НАТО-гийн тэргүүлсэн энхийг сахиулах ажиллагаанд оролцож, олон орны цэргүүдтэй мөр зэрэгцэн дэлхийн “халуун цэгүүд”-эд үүрэг гүйцэтгэснээр манай зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний техникийн болон хэлний мэдлэг, чадвар ихээхэн сайжирч байна. Тухайлбал, манай цэргүүд Афганистанд нисдэг тэрэгний манёвр, тактикийн сургалт хийсэн. Энэхүү ур чадвар, мэдлэгийг дайн, байлдаанаас гадна байгалийн гамшигт үзэгдэл тохиолдсон нөхцөлд ард, иргэдээ авран хамгаалахад ашиглах боломжтой. Нөгөөтэйгүүр, НАТО-гийн энхийг сахиулах ажиллагаанд оролцсоноор манай цэргүүдийн ур чадвар дэлхийн хэмжээнд үнэлэгдэхээр өсч байгаа явдал бидэнд томоохон давуу талыг олгож байгаа юм.

Шинжлэх ухааны салбарт идэвхтэй ажиллаж, НАТО-гийн Энхийн төлөө шинжлэх ухаан хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын ГХЯ, БХЯ, ШУА, НАТО-гийн хамтын ажиллагааны хүрээнд “Цэргийн зориулалттай газар нутгийн экологийн эрүүл ахуйн орон зайн мэдээллийн сан байгуулах нь”, мөн “ШУА-ийн компьютерийн сүлжээг дэмжих, мэдээллийн аюулгүй байдлыг хангах”

¹⁴ Зэвсэгт хүчний Соёмбо сонин “Монгол Улсын цэргийн баг Исламын Бүгд Найрамдах Афганистан улсад” (2012 оны 11 дүгээр сарын 01) http://www.soyombo.mod.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=743:2012-11-01-02-23-36&catid=30:the-community (accessed Sep 18, 2017)

гэсэн 2 төсөл хэрэгжсэн.¹⁵ Үүний зэрэгцээ, Монгол Улсын Стратеги судалгааны хүрээлэн НАТО-гийн Энхийн төлөө шинжлэх ухаан хөтөлбөрийн хүрээнд “Ази, Номхон далайн орнууд дахь НАТО-гийн талаарх ойлголт” төслийг 2014 оны 11 дүгээр сараас 2016 оны гуравдугаар сард амжилттай хэрэгжүүлж дууссан. Энэ төсөлд манай улсаас гадна НАТО-гийн Даяарын түншүүд болох Австрали, БНСУ, Шинэ Зеланд, Япон зэрэг улс хамрагдаж, эдгээр улсад тус эвслийг хэрхэн ойлгож, хүлээн авч байгаад дүн шинжилгээ хийж, судалгаа хийсэн болно.¹⁶

Түүнчлэн, Монгол Улсын Батлан хамгаалахын их сургууль НАТО-гийн гишүүн орнуудын батлан хамгаалах их сургууль, коллежуудын хамтарсан консорциумтай хамтарсан төслийг 2013-2017 онд хэрэгжүүлж дууссан. Энэхүү төсөл нь цэргийн мэргэжлийн боловсролын тогтолцоог боловсронгуй болгох зорилготой хэрэгжиж, Батлан хамгаалахын их сургуулийн сургалтын цөм хөтөлбөрийг шинэчлэн, багшлах арга зүйг сайжруулахад анхаарахын зэрэгцээ англи болон бусад хэлийг заахад ихээхэн ач холбогдол өгсөн юм.¹⁷ Монгол Улсын Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн Энхийг дэмжих ажиллагааны сургалтын төв (ЭДАСТ) НАТО-гийн боловсрол, сургалтын төвүүдийн сүлжээнд 2014 оны наймдугаар сард нэгдэн оров. Ингэснээр манай улс НАТО-гийн боловсрол, сургалтын төвүүдийн сүлжээнд нэгдсэн 24 дэх орон, Зэвсэгт хүчний ЭДАСТ нь 27 дахь төв болсон юм.¹⁸

Монгол Улс, НАТО-гийн хүрсэн харилцааны өнөөгийн түвшнээс үзэхэд хоёр талын хамтын ажиллагаа байж болох хамгийн дээд хязгаартаа хүрсэн гэж үзэж

¹⁵ <https://dnn.mn/>

¹⁶ <http://iss.gov.mn/?q=mn/node/498>

¹⁷ http://www.nato.int/cps/en/natohq/news_146824.htm

htm

¹⁸ <http://www.mnb.mn/i/32708>

байна. Учир юу хэмээвээс НАТО бол цэргийн эвсэл. Гадаад бодлогын үзэл баримтлалд зааснаар, Монгол Улс аливаа цэргийн эвсэл, холбоонд нэгдэхгүй байх бодлоготой. Харин НАТО-тай даяарын түншлэлийн хүрээнээс хальж харилцаж эхэлбэл эвсэлд үл нэгдэх бодлогод сорилт учруулахын зэрэгцээ хоёр хөршийн дургүйцлийг өдөөх магадлалтай. Иймд Монгол Улс, НАТО-тай өнөөгийн байгаа харилцааны хүрээнд хамтын ажиллагаагаа өргөжүүлэх боломжийг эрэлхийлэх шаардлагатай.

Тус эвсэлтэй байгуулсан Түншлэл, хамтын ажиллагааны гэрээнд заасанчлан, аюулгүй байдлын шинээр бий болсон сорилтуудтай тэмцэхэд хоёр тал хамтын ажиллагаагаа өргөжүүлэх боломжтой. Тухайлбал, гамшигтай тэмцэх чиглэлээр хоёр тал харилцах өргөн бололцоо байна. Хэдийгээр гамшигийн удирдлага, зохицуулалтын асуудал онцгой байдлын байгууллагын ажил боловч гамшиг тохиолдоход батлан хамгаалах, цэргийн байгууллагууд эн тэргүүнд дайчлагдан, ард иргэдийг авран хамгаалах үүрэг хүлээдэг. Иймээс гашгийн удирдлага, авран хамгаалах чиглэлээр манай зэвсэгт хүчний бүрэлдэхүүний чадавх, бэлэн байдлыг сайжруулахад НАТО-гийн тусламж, дэмжлэгийг авах, хамтарсан сургалт, сургуулилт хийх боломжтой.

Түүнчлэн, Монгол Улс кибер аюулгүй байдлаа хангахад дэд бүтэц, хүний нөөц, чадавх дутагдалтай байдаг. Нөгөө талд, НАТО болон түүний гишүүн орнууд энэ чиглэлээр туршлагатай, технологийн өндөр чадамжтайн дээр мэргэжилтэн, боловсон хүчний чадавх нь дэлхийд шилдэгт тооцогддог. Тиймээс хоёр тал энэ чиглэлээр хамтран ажиллах бололцоог эрэлхийлэх, манай нөхцөлд тохирсон дэд бүтэц үүсгэх, мэргэжилтэн, боловсон хүчнийг бэлтгэж, сургахад анхаарч ажиллах саналтай байна.

ДҮГНЭЛТ

Умард Атлантын эвсэл гишүүн бус орнуудтай түншлэлийн олон хэлбэрээр дамжуулан харилцаж байна. Түүний нэг нь даяарын түншлэл бөгөөд Монгол Улс, 2012 онд Түншлэл, хамтын ажиллагааны гэрээ байгуулснаар НАТО-гийн даяарын түнш болсон. Хоёр тал олон салбарт хамтран ажиллаж байгаагаас шинжлэх ухаан, технологи, сургалтын харилцаа Монгол Улсын эвсэгт хүчин болон бусад байгууллагын хүний нөөцийг бэхжүүлэх, чадавхыг бий болгоход чухал үүрэгтэй байна. Цаашид Монгол Улс, НАТО гамшгийн удирдлага, кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр

хамтран ажиллах бололцоо нээлттэй байна.

Нөгөөтэйгүүр, НАТО бол цэргийн эвсэл учраас Монгол Улс тус байгууллагатай харилцах харилцааны түвшинг ахиулах боломж хязгаарлагдмал юм. Энэ нь нэг талаар манай хууль, тогтоомжинд заасан эвсэлд үл нэгдэх бодлогод сорилт учруулахын зэрэгцээ хоёр хөрштэй харилцахад нөлөөлөх магадлалтай. Хоёр талын харилцаанд бодолцох шаардлагатай хамгийн чухал хүчин зүйл нь ОХУ, БНХАУ-ын байр суурь байдаг. Иймээс НАТО-тай харилцахад энэ хүчин зүйлийг ямагт харгалзан, НАТО-тай харилцаж буй талаараа тэдэнд ил тод, нээлттэй мэдээлж байх нь чухал юм.



М.ЭРДЭНЭБАЯР Ph.D

ПАРЛАМЕНТЫН ЗАСАГЛАЛД ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ

The implementation of parliamentary system in Mongolia has impacted positively on consolidation of sovereignty and independence of the country. In recent years, however, the public has become apparently distrusted in the system. Currently, the reputation of the political parties, which has spiraled down among the public, and the narrow decisions made by the ruling political party bring big challenges to the system.

УДИРТГАЛ

Монгол Улс 1990 оноос Үндсэн хуулийн шинэчлэлийг тайван замаар хийж, төлөөллийн ардчиллыг хөгжүүлээд 26 жилийн нүүр үзэж байна. Америкийн судалгааны байгууллага “Freedom house”-ийн үнэлэмжээр 1991 онд бүрэн чөлөөт улс болж, улмаар нэрт эрдэмтэн Хантингтоны “two turnover test”-ийн¹ дагуу парламентын

¹ Хантингтоны үзсэнээр эрх баригч хүчин сонгуулиар ялсан дараагийн хүчинд төрийн эрх мэдлийг ардчилсан тогтолцооны хүрээнд тайван замаар хүлээлгэн өгсөн байвал, энэ шинэ эрх баригчид мөн аль нэг өөр улс төрийн хүчинд эрх мэдлийг тайван

болон ерөнхийлөгчийн аль аль сонгуулиар хамгийн багадаа 2 удаа төрийн эрх баригч улс төрийн хүчин сонгуульд ялсан улс төрийн хүчинд төрийн эрх мэдлийг тайван замаар хүлээлгэн өгснөөр ардчиллын бэхжилтийн шалгуурыг хангасан билээ. Гэвч сүүлийн жилүүдэд ардчиллын нэр хүнд ард иргэдийн дунд унаж, улс төр, эдийн засгийн хүндрэлүүдийг төлөөллийн замаар дамжуулсан байвал сая ардчилал бэхжсэн гэж үздэг. Samuel, Huntington, 1991, The Third Wave: Democratization in the Late Twentieth Century, Norman University of Oklahoma Press, pp.166-167.

ардчилал, засаглалын хэлбэртэй холбон үзэх олон нийтийн хандлага бий боллоо.

Ардчиллыг сонгодог утгаар нь шууд ба төлөөллийн хэмээн ангилдаг. Товчдоо иргэд аливаа асуудлыг шийдвэрлэхэд хэн нэгнээр дамжуулалгүй өөрийн биеэр оролцохыг шууд ардчилал, харин өөрийн өмнөөс үүрэг хүлээсэн албан тушаалтныг сонгож, түүгээрээ дамжуулан засаглах эрхээ хэрэгжүүлэхийг төлөөллийн ардчилал хэмээдэг. Төлөөллийн ардчилалд сонгуулийн тогтолцооны төгс бус байдал, хувь хүний саналыг бүрэн тусгах боломжгүй, булхай, луйвар, санал худалдаж авах зэргээс шалтгаалан сонгогдож гарч ирсэн улс төрчид ард иргэдийг бүрэн дүүрэн төлөөлж чаддаггүй байна.²

Шууд ардчилал иргэдэд саналаа шууд өгөх боломжийг олгодог. Төлөөллийн ардчиллын гол элемент сонгууль байдаг бол шууд ардчиллыг гол элемент нь санал асуулга бөгөөд иргэдийн олонхын саналаар асуудлыг шийддэг.

Монгол Улсын хувьд төрийн шийдвэр гаргах үйл явцад иргэд шууд оролцох боломжгүй, шийдвэр гаргах хүндийн жин нь ард иргэдэд бус төлөөлөгчдөд, тодруулбал, төлөөлөгчдийн ард байгаа улс төрийн намуудад төвлөрч, засаг төрийг ард түмнээс хөндийрүүлснээр түүний хүлээн зөвшөөрөгдөх шинж (легитим шинж) буурсаар байна.³ Засаг төрийн хүлээн зөвшөөрөгдсөн байдал дутагдах нь түүний үйл ажиллагаанд иргэд дургүйцэхэд хүргэх бөгөөд богино хугацаанд төрийн бодлого, санаачилгыг хэрэгжүүлэхэд саад, хүндрэл учруулах, харин урт хугацаанд төр эрх мэдлээ хадгалахын тулд дарангуйллын арга

² Duverger, Maurice, 1980, A New Political System Model: Semi-Presidential Government, European Journal of Political Research, p.82.

³ Ч.Энхбаатар, “Төлөөллийн ардчилал, тулгамдсан асуудал”, “Ардчиллын хөгжил-Иргэний оролцоо” эрдэм шинжилгээний бага хурал, 2017 он.

хэрэгслийг ашиглах хандлага нэмэгдэх эрсдэлтэй ажээ.⁴

ПАРЛАМЕНТЫН ЗАСАГЛАЛД ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ

Монгол Улс дахь парламентын засаглал улс орны бүрэн эрхт байдал, үндэсний аюулгүй байдлыг бататгахад өргөн утгаараа эерэг нөлөөлөл үзүүлж ирсэн хэмээн дийлэнх судлаач дүгнэж байна. Парламентын засаглалын дараах шинж чанарууд Монгол Улсад үндэсний эв нэгдлийг хангах, нийгмийн тогтвортой байдлыг хамгаалахад чухал нөлөө үзүүлж ирсэн. Үүнд:

- Үндэсний аюулгүй байдалтай холбоотой чухал асуудлуудыг нэг удирдагчийн үзэл, хандлагаар бус, олон нийтийн хүсэл зориг, олон намын зөвшилцлөөр хэлэлцэн шийдвэрлэх боломжийг олгож ирсэн. Ийнхүү олонхоороо гаргасан бодлого, шийдвэр нь нэг талаас гадны нөлөөлөлд шууд автах магадлал харьцангуй бага учир улс орны бүрэн эрхт байдлыг бататгахад эерэг нөлөөтэй.
- Ардчиллын төлөвшилд ерөнхийлөгчийн засаглалаас илүү эерэг нөлөөтэй гэж үздэг⁵

⁴ Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, 2016 он.

⁵ Ерөнхийлөгчийн засаглал нь иргэдээс сонгогдон засгийн газраа тэргүүлдэг ерөнхийлөгчийн институт, мөн иргэдээс сонгогдон байгуулагддаг парламентад аль алинд нь ихээхэн эрх мэдэл олгодог бөгөөд ерөнхийлөгч, парламентын олонх өөр өөр улс төрийн хүчнээс сонгогдсон нөхцөлд 2 институцийн хооронд зөрчил тэмцэл тасрахгүй байх, улмаар зөрчлийг арилгахын тулд зэвсэгт хүчнийг ашиглах сонирхол нэмэгддэг ажээ.

Монгол Улсын хувьд Ерөнхийлөгч бүх ард түмнээс сонгогддог боловч гүйцэтгэх засаглалыг парламентаас томилогдсон Ерөнхий сайд тэргүүлдэг нь хурц зөрчлөөс зайлсхийх боломж олгож иржээ. Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн

бөгөөд ерөнхийлөгчийн засаглал дарангуйлагч тогтолцоо руу илүү амархан ухарч болохыг Төв Азийн улсуудын туршлага харуулсан билээ.

- Парламентын түвшинд улс төрийн намуудын зөвшилцлөөр гарсан шийдвэр харьцангуй урт хугацаанд тогтвортой байх боломжтой зэрэг шинжээр Монгол Улсын парламентын тогтолцоо үндэсний эв нэгдлийг хангах, нийгмийн тогтвортой байдлыг хамгаалахад нааштай нөлөө үзүүлж ирсэн гэж дүгнэж болно.

Харин улс төр, эдийн засгийн хүндрэлийг одоогийн засаглалын хэлбэртэй холбон үзэж засаглалын өөр хэлбэрийг сонгох шаардлагатай гэсэн олон нийтийн хандлага өсөж буй бөгөөд төрийн институцууд иргэдийн итгэл буурсаар байгааг “Сант марал” сангаас хийсэн цуврал судалгаа харуулж буй. Тухайлбал, эдийн засгийн өсөлт хамгийн өндөр хувьтай байсан 2012 онд иргэдийн 54.9 хувь нь “төр засаг иргэдийн төлөө зөв зүйл хийж байгаа гэдэгт бараг итгэхгүй болон огт итгэхгүй байна” гэж хариулж байсан бол ийм байр суурьтай иргэдийн тоо 2016 онд 59.9 хувь болж өссөн. Тус Сангийн 2010 оны судалгаагаар судалгаанд оролцогчдын 37.9 хувь нь Ерөнхийлөгчид, 51.4 хувь нь УИХ-д итгэдэггүй хэмээн хариулж байсан бол 2016 онд 44.6 хувь нь Ерөнхийлөгчид, 53.9 хувь нь УИХ-д итгэдэггүй хэмээн хариулсан.⁶

Түүнчлэн 2003 онд “одоогийн нөлөө байдалд хийсэн дүн шинжилгээ, 2016 он.

⁶ “Сант марал” сангийн улс төрийн барометр судалгаа. www.santmaral.mn

бүхий ерөнхийлөгчтэй Парламентын засаглал” болон “улс төрийн намуудын нөлөөллийг хязгаарласан Ерөнхийлөгчийн засаглал”-ыг дэмжигчдийн хувь адил 30 орчим байсан бол түүнээс хойш “ерөнхийлөгчийн засаглал”-ыг дэмжигчдийн тоо өссөөр 2017 оны судалгаагаар 48 хувьд хүрч, харин “одоогийн парламентын засаглалын хэлбэр”-ийг дэмжигчид зөвхөн 25.3 хувийг эзэлж байна /График 1/.

График 1. Засаглалын хэлбэрийн дэмжлэг



Эх сурвалж: “Сант марал” сан


Мөн “Азийн барометр” судалгаагаар 2002 онд судалгаанд оролцогчдын 66.1 хувь “хүчтэй удирдагчийг хүлээн зөвшөөрөхгүй” гэж хариулж байсан бол 2014 онд энэ үзүүлэлт 34.2 хувь болон буурчээ.⁷ Ийнхүү “хүчтэй удирдагч” буюу Ерөнхийлөгчийн засаглалыг дэмжигчид өсөж буйн үндсэн шалтгааныг нийгэмд шударга ёс алдагдсан, ажилгүйдэл, ядуурал, авлига газар авсан, нийгмийн сэтгэл зүй парламентын үйл ажиллагаа, намуудын хэт улс төржилтөөс залхаж, тогтвортой үйл ажиллагаатай, чадварлаг засаг төрийг хүсэж байгаатай холбон тайлбарлаж болохоор байна.⁸

⁷ Д.Ганбат, “Монгол дахь ардчилал ба түүний чанар”, 2014.12.10

⁸ 2017 оны 3 дугаар сарын “Сант марал” сангийн судалгаагаар судалгаанд оролцогчдын 79.9 хувь нь

Иргэд төлөөллийн ардчиллын чухал институт болох⁹ улс төрийн намаас /цаашид УТН гэх/ хүнийсэх хандлага газар авч байгаа нь УТН сонгогчдыг “дайчлах”, үнэт зүйлсийг түгээн байршуулах, иргэний нийгэм, улс төрийн эрхийг дэмжих, иргэдийн эрх ашгийг илэрхийлэх үүргээ гүйцэтгэж чадахгүй байгаагийн илэрхийлэл болж байна /График 2/.

График 2. Улс төрийн намын дэмжлэг



Эх сурвалж: “Сант марал” сан

Дээрх судалгаанууд иргэдийн улс төрийн намуудад итгэх итгэл алдарч, улс орондоо ардчиллыг хөгжүүлж чадна гэдэгт эргэлзэж, УИХ зэрэг гол институцийн хүлээн зөвшөөрөгдөх түвшин доошилж, нийгэм хүчтэй удирдагч хүсэмжилж эхэлснийг харуулж байна.

Харин дийлэнх улс төрч, судлаач Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар засаглалын чанарыг сайжруулах боломжтой хэмээн үзэж буй бөгөөд өнөөгийн хэрэгцээнд тулгуурлан засгийн газрын эрх мэдэл, танхимийн зарчмаар ажиллах чадавхийг нэмэгдүүлэх,

нийгэмд шударга бус нь илүү байна гэж хариулсан. Харин 45.2 хувь нь УИХ-д итгэдэггүйгээ илэрхийлсэн бол 60.6 хувь нь улс төрийн намуудад итгэдэггүйгээ илэрхийлсэн, мөн судалгаанд оролцогчид ажилгүйдэл, амжиргаа, эдийн засаг гуравыг хамгийн тулгамдсан асуудлаар нэрлэсэн.

⁹ Улс төрийн нам нь сонгогчдын төлөөллийг хэрэгжүүлэх, үзэл бодлыг нэгтгэх, шийдвэр гаргах, засаглалыг зохион байгуулах, ардчилсан хариуцлагыг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

ерөнхийлөгчийн эрх мэдлийг багасгах шаардлагатай гэсэн хандлага голлон илэрч байна.¹⁰

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал өнгөрсөн жилүүдэд олон удаа яригдаж, төслийн хувилбарууд өргөн баригдаж, ажлын хэсгүүд гарч ажиллан тодорхой саналууд боловсруулж байсан.¹¹ Одоогийн УИХ судлаачид болон олон нийтийн санал бодлыг судлах, УИХ-ын түвшинд ажлын хэсэг байгуулж судлах, Зөвлөлдөх санал асуулга явуулах, Үндэсний зөвшилцлийн комисс ажиллах, Үндсэн хуулийн төслийн талаар эрх

¹⁰ “УИХ-д Засгийн газрын томилгоо болон улсын төсвийг хуваарилах, байгалийн баялагийн ашиглалтын асуудлаар шийдвэр гаргах онцгой эрх мэдэл төвлөрч, гүйцэтгэх засаглалд байх ёстой эдгээр онцгой эрхийг эдэлж байгаа нь парламент хууль тогтоох үндсэн үүргээсээ хазайж, албан тушаал, хөрөнгө мөнгө хуваарилахын төлөөх өрсөлдөөний талбар болон хувирахад хүргэж байна” хэмээн үзэж буй. Түүнчлэн хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын хяналтын болоод хэрэгжүүлэх эрх мэдлийн дундуур орж үймүүлээд байдаг Ерөнхийлөгчийн эрх мэдлийг багасгах ёстой хэмээн үзэж буй. *Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, 2016 он. Н.Батбаяр, Д.Лүндээжанцан, бусад нарын боловсруулсан “Монгол Улсын Үндсэн Хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөл”, 2015 он. Х.Тэмүүжин, “Ямар ч хүн сонгогдсон тогтолцоо нь түүнийг мангас болгодог юм”, 2017 он. О.Мөнхсайхан, “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хуульд нийцсэн байхын зэрэгцээ судалгаанд үндэслэсэн байх ёстой”, 2015 он.*

¹¹ 2000 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаас хойш УИХ-ын гишүүдээс 2011, 2012, 2015 онд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг өргөн мэдүүлж байсан. 2012-2016 оны УИХ-ын бүрэн эрхийн хугацаанд УИХ-ын дэд дарга Л.Цогоор ахлуулсан ажлын хэсэг ажиллаж “Үндсэн хуульд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай” гэсэн дүгнэлт гаргасан. Үүний дагуу УИХ-ын гишүүн Н.Батбаяраар ахлуулсан УИХ-д суудалдтай намуудын төлөөлөл оролцсон ажлын хэсэг ажиллаж нэмэлт, өөрчлөлтийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн ч хэлэлцэж амжаагүй. 2016 оны 12 дугаар сард Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын захирамжаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэхийг судлах, санал дүгнэлт боловсруулах Ч.Энхбаатараар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж тодорхой санал, дүгнэлт боловсруулан Засгийн газарт хүлээлгэн өгсөн. Мөн 2016 онд УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцангаар ахлуулсан УИХ-ын гишүүд, судлаач, мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсэг ажиллаж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг судалсан.

бүхий эдгээдүүдээс санал авах,¹² Хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх зэрэг шат дамжлагаар оруулж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийхээр зорьж буй нь сайшаалтай байна.¹³

УИХ-аас байгуулсан ажлын хэсгээс “Зөвлөлдөх санал асуулга”-аар хэлэлцүүлсэн сэдвүүд, одоо ард нийтээр хэлэлцүүлж буй Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд “УИХ, Засгийн газрын эрх мэдлийн хяналт-тэнцлийг хангах”, “Ажил үүргийн давхардлыг арилгах үүднээс Ерөнхийлөгчийн эрх үүргийг тодорхой болгох”, өөрөөр хэлбэл Ерөнхий сайдын эрх мэдлийг нэмэгдүүлэх, Ерөнхийлөгчийн эрх мэдлийг хязгаарлах нэмэлт, өөрчлөлт голлон хэлэлцэгдэж байна.¹⁴

Дээрх нэмэлт өөрчлөлтийн дагуу Ерөнхий сайд танхимаа өөрөө бүрдүүлж, түүнийхээ төлөө хариуцлага хүлээдэг болсноор гүйцэтгэх засаглалын бие даасан байдал, хариуцлага хүлээх чадвар сайжрах боловч УТН-уудын төрийн “толгой дээр гарах” байдал улам лавшрах, нам төвтэй, ялангуяа намын дарга төвтэй тогтолцоо бий болох эрсдэл нэмэгдэнэ.¹⁵ Ерөнхийлөгчийг

¹² Ерөнхийлөгч, Засгийн газар, ҮАБЗ, Шүүхийн ерөнхий зөвлөл, Хүний эрхийн үндэсний комисс, Монгол банкны ерөнхийлөгчөөс санал авсан.

¹³ УИХ-ын дарга М.Энхболд, “Долоо хэмжиж, нэг огтлохын учир”, 2017.04.27. www.parliament.mn

¹⁴ УИХ-ын даргын 78 дугаар захирамжаар Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж төслийг боловсруулаад байна. УИХ, ЗГ-ын эрх мэдлийн хяналт-тэнцлийг хангах; Ерөнхийлөгчийн эрх үүргийг тодорхой болгох; Улс төрөөс хараат бус, мэргэшсэн төрийн албыг бэхжүүлэх; Засаг захиргаа, нутгийн удирдлагын тогтолцоог төгөлдөржүүлэх; Төрийн хариуцлага, сахилга, шударга ёсыг бэхжүүлэх, хууль хэрэгжүүлэх тогтолцоог сайжруулах гэсэн 5 сэдвийн хүрээнд ард нийтээр хэлэлцүүлж байна.

¹⁵ Хэдийгээр УИХ сайд нарыг томилох, огцруулахад оролцохгүй болсноор улс төрийн талцал хуваагдал, төрийн албан дахь улс төрийн нөлөө багасах боловч Ерөнхий сайд, намын даргыг тойрсон бүлэг, фракцын эрх ашигт үйлчилсэн тогтолцоо бэхжих, улмаар Ерөнхий сайдын “диктатур” тогтох эрсдэл үүсч

УИХ-аас сонгодог болсноор түүний гүйцэтгэх эрх мэдэлд оролцох, Ерөнхий сайдтай зөрчилдөх байдлыг багасгах боловч УИХ, орон нутгийн сонгуульд ялсан намаас нэр дэвшигч Ерөнхийлөгчөөр сонгогдох өндөр магадлалтай ба ингэснээр улс төрийн бүх эрх мэдэл нэг улс төрийн хүчинд төвлөрч, хариуцлага, хяналт суларна.¹⁶ Харин Ерөнхийлөгчийн хууль санаачлах болон Засгийн газарт чиглэл өгсөн зарлиг гаргах эрхийг хассан тохиолдолд түүний Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн бүрэн эрх, хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэнэ.¹⁷ Өөрөөр хэлбэл, ҮАБЗ-ийг хэн удирдах асуудлыг өөрийн орны онцлогийг харгалзан сайтар судлан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр нэг мөр шийдэх шаардлага тулгарч байна.¹⁸

болзошгүй. Учир нь парламентын засаглалын нэг сул тал нь засгийн газрыг парламентын олонх байгуулдаг ба тэд дэмжиж байж засгийн газар оршин тогтнодог. Энэ нь засгийн газар олонхоо хянаж байж оршин тогтноно гэсэн үг. Ийм олонхийг ялсан улс төрийн хүчний лидерийг тойрсон бүлэг, фракц бүрдүүлэх боломжтой ба тэд улс төрийн амьдралын гол зохион байгуулагч болдог. *Richard Albert, The Fusion of Presidentialism and Parliamentarism, Boston College Law School, 2009.*

¹⁶ Хууль тогтоох, гүйцэтгэх, мөн Ерөнхийлөгчийн хориг тавих эрх нэг улс төрийн хүчний гарт төвлөрснөөр тэд хүссэнээ хийх боломжтой болно. Ард түмэнд тэднийг хазаарлах, тэнцвэржүүлэх өөр хэрэгсэл үлддэггүй. Герман зэрэг оронд ийм байдал асуудал бага үүсгэдэг нь холбооны улсын онцлогтой нь холбоотой бөгөөд тус улсад холбооны 16 улсын ЗГ-ын итгэмжилсэн төлөөлөл орсон Бундесрат гэдэг мэргэшсэн байгууллага парламентын дэргэд ажилладаг.

¹⁷ Монгол Улсын Их Хурал, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулга явуулах сэдвийн танилцуулга, 2017 он.

¹⁸ ҮАБЗ-ийн үндсэн үүрэг нь үндэсний аюулгүй байдлыг хангах ЗГ-ыг байгууллагуудын ажлын уялдааг хангахад оршдог. Олон улсын жишигт ҮАБЗ нь ихэнхдээ гүйцэтгэх засаглалын харьяа байгууллага байдаг бөгөөд Ерөнхийлөгчийн засаглалтай оронд Ерөнхийлөгч, парламентын засаглалтай оронд Ерөнхий сайд тэргүүлдэг. Б.Мэргэн, “Аюулгүй байдлын салбарын хөгжил, шинэчлэл: Ерөнхийлөгч ба ҮАБЗ”, Монгол Улсын Аюулгүй байдлын салбар, Алманах 2017.

ДҮГНЭЛТ

Монгол Улс дахь төлөөллийн ардчилал, парламентын засаглал улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг бэхжүүлэхэд эерэг нөлөөлөл үзүүлж ирсэн боловч эдүгээ олон нийтэд түүнд үл итгэх хандлага илрэх болов. Нэг талд парламентын засаглалыг хэрэгжүүлэгч гол институц, төр ба иргэнийг холбогч УТН-ын нэр хүнд ард иргэдийн дунд эрс унасан, нөгөө талд УТН засаг төрийн дээр гарсан, парламентын шийдвэр нэрээр эрх баригч намын шийдвэр гарч хэрэгжиж байгаа нь цаашид томоохон бэрхшээл дагуулж болзошгүй. Энэ байдлыг Үндсэн хуулийг засаж сайжруулснаар тодорхой хэмжээнд шийдэж болох боловч улс төрчдийн байр суурь, ард иргэдээр хэлэлцүүлж буй Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгагдсанаар Ерөнхий сайдын эрх мэдлийг нэмэгдүүлэх нь нам төвтэй, намын даргыг тойрсон бүлэг фракцад үйлчилсэн тогтолцоо бэхжих сул талыг агуулж байна.¹⁹ Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн ийм нэмэлт, өөрчлөлтөөр тулгарч буй асуудлыг шийдэхгүй харин УТН төрийн дээр гарах байдлыг улам өөгшүүлэх томоохон эрсэдлийг агуулж байна.

Эцэст нь дүгнэхэд, парламентын хөгжлийг дэмжихүйц дотоод ардчилалтай, олон нийтийн дэмжлэг хүлээсэн УТН-уудыг төлөвшүүлэх асуудал тулгамдаж байна. УТН-ууд иргэний нийгмийн эд эс болох шинж чанараа нэмэгдүүлэх, олон түмнийг улс төрийн хувьд гэгээрүүлэх, нийгэм төрийг холбох, улс төрийн системийн үйлчлэлийг хангах үүргээ

¹⁹ Парламентын засаглалын нэг сул тал нь засгийн газрыг парламентын олонх байгуулдаг ба тэд дэмжиж байж засгийн газар оршин тогтнодог. Энэ нь засгийн газар олонхоо хянаж байж оршин тогтноно гэсэн үг. Ийм олонхийг ялсан улс төрийн хүчний лидерийг тойрсон бүлэг, фракц бүрдүүлэх боломжтой ба тэд улс төрийн амьдралын гол зохион байгуулагч болдог. Хүчтэй Ерөнхий сайдтай болбол энэ байдал улам даамжирах эрсдэлтэй.

ухамсарлах хэрэгтэй байна.²⁰

Засаг төрийн бодлого, шийдвэр гарахад олон нийтийн оролцоог хангах буюу шууд ардчиллын элементүүдийг оруулж ирвэл нэг талаас түүний институцүүдийн легитим шинж нь дээшилж, тогтвортой үйл ажиллагаа явуулах, нөгөө талаас ардчиллыг цаашид бэхжүүлэх мэдээлэл, мэдлэгтэй иргэд бэлтгэгдэх юм.

²⁰ Э.Гэрэлт-Од, “Улс төрийн нам, иргэний нийгмийн оролцоо”, “Ардчиллын хөгжил-Иргэний оролцоо” эрдэм шинжилгээний бага хурал, 2017 он.



Х.НОМИНБОЛОР

ОРЧНЫ БОХИРДОЛ, ХҮН АМЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛД УЧРУУЛАХ ЭРСДЭЛ

The Constitution of Mongolia states that “Citizens of Mongolia are guaranteed the privilege to enjoy the right to a healthy and safe environment, and to be protected against environmental pollution and ecological imbalance.” In recent years, however, there has been an increasing threat to human health, environment and ecology caused by environmental pollution and degradation as a result of urbanization and industrialization.

This article summarizes the current situation of environmental pollution, and the legal, policy and regulatory environment for pollution reduction in Mongolia and provides recommendations to address these challenges.

ОРШИЛ

Монгол Улсын Үндсэн хуулинд “Монгол Улсын иргэн эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” хэмээн заасан хэдий ч өнөөгийн байдлаар иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрэн хангагдаагүй. Сүүлийн жилүүдэд хотжилт, үйлдвэржилтийн нөлөөгөөр улам бүр

ихэсч буй хүрээлэн буй орчны бохирдол, доройтлоос үүдэлтэй байгаль экологи, хүн амын эрүүл мэнд, амьдрах орчинд учруулах аюул улам нэмэгдэж байна. Улаанбаатар хот болон бусад томоохон хот суурин газрын агаар, орчны бохирдол улам бүр ихсэх хандлагатай байгаагийн дээр орон нутагт уул уурхай, хөдөө аж ахуйн үйл ажиллагаанаас үүдэлтэй ус, хөрсний

бохирдол нэмэгдэж байна^{1,2}.

Орчны бохирдол, доройтлыг бууруулах хүрээнд хууль эрхзүйн орчин тодорхой хэмжээнд бүрдээд буй ч үүсээд буй агаар, орчны бохирдлыг богино хугацаанд, дорвитой бууруулахад ойрын хугацаанд үр дүнгээ өгөх, бодитой үйл ажиллагааг тодорхойлсон нэгдсэн бодлого боловсруулж, техник, технологи, хөрөнгө санхүү, нөөцийн боломжид тулгуурлан салбар дундын зохицуулалт хийх шаардлагатай байна. Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газраас Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг боловсруулан батлаад удаагүй байна. Мөн хөрс хамгаалах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу Засгийн газраас хөрс хамгаалах үндэсний хөтөлбөрийг боловсруулж байна. Иймд орчны бохирдлын өнөөгийн нөхцөл байдал, бохирдлыг бууруулах хууль, эрхзүй, бодлого зохицуулалтын орчин, цаашид анхаарвал зохих асуудлуудыг энэ өгүүлэлд тоймлов.

НЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОХИРДЛЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

1.1. Агаарын бохирдол

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (цаашид ДЭМБ гэх)-ын 2010 оны судалгаагаар Улаанбаатар хот дэлхийн хамгийн их агаарын бохирдолтой 10 хотын тоонд багтжээ. Нийслэл хот, аймгийн төвүүдэд агаарын бохирдол ихэсч, ялангуяа өвлийн улиралд Улаанбаатар хотод бохирдлын түвшин нийт ажиглалтын 50 гаруй хувьд Монгол Улсын агаарын чанарын стандартаас давж байна. Өвлийн улиралд Улаанбаатар хотын агаар дахь

¹ Эрүүл мэндийн яам (2011). “Хүрээлэн буй орчны бохирдол хүний эрүүл мэндэд” судалгаа шинжилгээний тайлан.

² Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (2015). Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2013-2014 он.

нарийн ширхэглэгт тоосонцорын хэмжээ 1985 мкг/м³ хүрч байгаа явда ДЭМБ-ын зөвлөмжид заасан хэмжээ (24 цагийн туршид дунджаар 25мкг/м³-аас хэтрэхгүй байх)-нээс даруй 80 дахин хэтэрч байгаа юм. Агаарын бохирдол аюултай түвшинд хүрч хотын хүн ам ДЭМБ-ын олон улсын стандартад заасан жилийн дундаж нарийн ширхэглэгт тоосонцорын (PM_{2.5}) зөвлөмж хэмжээнээс долоо дахин их³, Монгол Улсын үндэсний стандартад заасан жилийн дундаж зөвшөөрөгдөх дээд түвшингээс буюу 25 мкг/м³-ээс гурав дахин өндөр бохирдолд өртөж байна⁴.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг эх үүсвэрээр авч үзвэл бохирдлын 80 хувь нь гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгжийн халаалтын зуух, 10 хувь нь автомашин, 5-6 хувь нь дулааны цахилгаан станцууд, дөрвөн хувь нь бусад эх үүсвэрээс ялгарч байна. Улаанбаатар хотоос бусад томоохон суурин газруудад сүүлийн хоёр жилийн буюу 2015-2016 оны байдлаар агаар дахь PM₁₀ тоосонцорын жилийн дундаж агууламж зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрэлттэй байна.

Томоохон хот, суурин газрын агаар дахь азотын давхар исэл, хүхэрлэг хий, хар тугалга болон нарийн ширхэглэгт тоосонцорын хэмжээ эрүүл ахуйн зөвшөөрөгдөх хэмжээнээс өндөр байгаа явдал хүн амын дунд амьсгалын замын өвчлөл, түүн дотроо уушгины цочмог, архаг үрэвсэл, хорт хавдар, зүрх судасны эмгэг, харшлын өвчин нэмэгдэх, хүний дархлааны түвшин буурах, бага насны хүүхэд нас барах, бие бялдрын өсөлт,

³ Allen R. W. et al. (2013). An assessment of air pollution and its attributable mortality in Ulaanbaatar, Mongolia. *Air Quality, Atmosphere & Health*, 6(1), 137–150; Guttikunda S. et al. (2013). Particulate Pollution in Ulaanbaatar, Mongolia. *Air Quality, Atmosphere and Health*, 6, 589-601.

⁴ НҮБ-ын хүүхдийн сан, 2016. Хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын үзүүлэх нөлөө, шийдвэрлэх арга зам.

хөгжилт саарах зэрэг сөрөг нөлөө үзүүлж байна. 2013 оны байдлаар улсын хэмжээнд агаарын бохирдлоос үүдэлтэй гурван төрлийн өвчний уулмаас хүний амь цаг бусаар үрэгдэж байгааг тогтоожээ⁵. Зүрх-уушигны өвчний улмаас нас барсан хүний 29 хувь, уушигны хорт хавдраас нас барсан хүний 40 хувь нь бохирдлоос үүдэлтэй болохыг судалгаа харуулж байна. Улаанбаатар хотын хүн амын дунд зүрх судасны өвчлөл (зүрхний ишеми өвчин болон цус харвалт) хамгийн түгээмэл байгаа бөгөөд хөдөлмөрийн чадвар алдсан амьдралын жилүүдийн (ХЧААЖ) зонхилох шалтгаан зүрх судасны тогтолцооны өвчлөл, хүүхдийн хатгалгаа өвчин байна⁶.

Хүснэгт 1. Улаанбаатар хотын агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөл, 2015 он

Улаанбаатар хотын хүн амын өвчлөлийн дарамтын тооцоолол, 5 өвчин, 2015 он			Холбогдох зэрэглэл
Өвчин	Нас баралт	ХЧААЖ	Алдсан жил
5 хүртэлх насны хүүхэд			
Амьсгалын доод замын халдвар болох хатгалгаа (0-4 нас)	435	37,290	2
Насанд хүрэгсэд			
Зүрхний ишеми өвчин	2,151	47,903	1
Цусны эргэлтийн тогтолцооны өвчин (цус харвалт)	1,493	34,321	3
Уушигны архаг бөглөрөлт өвчин	453	17,739	17
Цагаан мөгөөрсөн хоолой, бронх, уушигны хорт хавдар	233	5,826	18

Эх сурвалж: С.Очир ба бусад, 2014.

1.2. Усны бохирдол

2016 оны байдлаар манай орны нийт 94 гол мөрөн, 18 нуурын 127 харуулын 191 цэгт гадаргын усны чанар, бохирдлын

⁵ Institute for Health Metrics and Evaluation (IHME). Монгол 2013. www.healthdata.org.

⁶ С.Очир ба бусад, 2014. Төслийн төгсгөлийн тайлан: Улаанбаатар хотын агаарын бохирдол ба эрүүл мэнд. Улаанбаатар хот.

байнгын ажиглалт, судалгаа хийснээс 91 хувь маш цэвэр, цэвэр ангилалд, таван хувь бага бохирдолтой, нэг хувь бохирдолтой, бохир, гурван хувь маш бохирдолтой байна. Маш цэвэр, цэвэр ангилалд багтах цэгийн тоо жил тутам буурч, бохирдолтой цэгийн тоо нэмэгдэж байна⁷. Бохир, маш бохир голд Туул голын Улаанбаатар хотоос доош буюу Сонгиноос Алтанбулагийн гүүр хүртэл хэсэг, мөн Хиагт голын Алтанбулаг харуул, Хангал голын Эрдэнэт хотын доод цэг, Хүдэр голын Хүдэр хяналт-шинжилгээний цэг тус тус багтаж байна.

Улаанбаатар хот, бусад суурин газрын хувьд цэвэрлэх байгууламжийн техник технологийн хоцрогдол, хүчин чадлын хэтрэлт усны бохирдлын гол эх үүсвэр болдог⁸. Монгол Улсын нутаг дэвсгэрийн 3.2 хувийг эзлэн оршиж, 1.6 сая хүнийг ундаалж буй Туул голын сав газрыг манай улсын онцгой объект. Гэтэл Туул голын дагуух усны чанарын хяналт-шинжилгээний 13 цэгт хийдэг усны химийн найрлага, чанарын хяналт-шинжилгээний дүнгээр төв цэвэрлэх байгууламжаас


гарч буй бохир ус Туул голд нийлснээр Улаанбаатар хотоос доош буюу Сонгиноос Алтанбулагийн гүүр хүртэлх хэсэг өндөр

⁷ Байгаль орчин, аялал жуулчлалын яам, 2017. Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2015-2016 он.

⁸ Улсын хэмжээнд нийт 130 гаруй цэвэрлэх байгууламж байгаагаас талаас илүүгийнх нь үйл ажиллагаа доголдсон, эвдрэлтэй байгаагийн улмаас жилд 120 сая шоо метр бохир ус байгальд хаягдаж, Туул, Хараа, Ерөө зэрэг голуудыг ихээр бохирдуулж байна.

бохирдолтой байна. Анхлан 1964 онд 500 мянган хүн амын ахуйн хэрэглээний бохир усанд биологийн цэвэрлэгээ хийх зориулалтаар байгуулсан төв цэвэрлэх байгууламж өдгөө хүчин чадлаасаа гурав дахин их ачаалалтай ажилла, хоногт дунджаар хими, биологийн бохирдол бүхий 150,000-160,000 шоо метр усанд биологийн цэвэрлэгээ хийн 26-81 хувийн цэвэршүүлэлттэйгээр Туул голд нийлүүлж байна. Бохирдлын гол шалтгааны нэг нь нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй хүнсний болон боловсруулах үйлдвэрүүд, авто угаалгын газар ба эдгээр аж ахуйн нэгжийн технологийн хаягдал бохир усны найрлага, агууламж стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрч байгаа явдал цэвэрлэх байгууламжийн ачаалал, цэвэрлэгээний түвшинд нөлөөлж улмаар дутуу цэвэрлэгдсэн бохир усыг хүрээлэн буй орчинд нийлүүлэн бохирдуулах нөхцөлийг бүрдүүлж байна.

Зураг 1. Төв цэвэрлэх байгууламжийн хаягдал бохир ус



цэвэршүүлсэн чадвар (2015-2016 он)

Орон нутагт гадаргын усны бохирдол бий болох гол шалтгаан бол голын сав газарт явуулж буй уул уурхайн үйл ажиллагаа байдаг. Тухайлбал, Хүдэр голын сав газарт үйл ажиллагаа явуулж буй алтны уурхайн

нөлөөгөөр голын усны чанар буурч, их бохирдлын түвшинд хүрэх болжээ.

1.3. Хөрсний бохирдол

Манай улсын хөрсний бохирдлын голлох эх үүсвэр уул уурхай, боловсруулах үйлдвэрүүд, гэр хорооллын ариун цэврийн байгууламж, хог хаягдал, агаарын бохирдол юм. Хот, суурин газарт гэр хорооллын ариун цэврийн байгууламжтай холбоотой нянгийн бохирдол их байдаг бол орон нутагт уул уурхай, аймаг сумын төвүүдийн хог хаягдал хөрсний бохирдол үүсгэх гол шалтгаан болдог.

Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотын хэмжээнд хөрсний бохирдол ихэссэн тухай судалгааны үр дүн гарсаар байна. Хот суурин газрын хөрсний бохирдлыг хөрсөн дэх хүнд металлын түвшин, органик бодисын агууламж, хөрсний нянгийн бохирдол, эдгээрээс үүдэлтэй өвчлөл зэрэг хэд хэдэн үзүүлэлтээр гаргах боломжтой. Монгол Улс хөрсний бохирдлын 77 стандарт, байгаль орчин, эрүүл мэндийн сорилын долоон лаборатори, цэвэрлэх

байгууламжийн 20 гаруй стандарт мөрдөж байна. 2014 онд Улаанбаатар хотод хийсэн хөрсний судалгаагаар хүнд металлын бохирдлын ерөнхий түвшин Монгол Улсад мөрдөж буй стандартаас хэтрэхгүй, алаг цоог байдлаар тархсан хар тугалга, хром, цайр, хүнцлийн бохирдолтой

байжээ. Улаанбаатар хотын өнгөн хөрсний бохирдол, хүнд металлын тархалтын зураглалыг орон нутгийн суурь агуулгатай харьцуулан гаргасан судалгааны дүнгээр хөрсөнд агуулагдах хар тугалганы бохирдлын түвшин 29 хувь дунд, 68 хувь их, цайрын 34 хувь дунд, 64 хувь их, никелийн 61 хувь, хромын 73 хувь, зэсийн 83 хувь нь дунд зэргийн бохирдолтой бөгөөд бохирдлын гол эх үүсвэр нь гэр хорооллын болон автомашины утаа, томоохон зах, шатах тослох материалын цэг, авто засварын газар байна.

Хэдийгээр стандартаас хараахан хэтрээгүй байгаа ч хот суурин газрын хөрс, ус, агаараар дамжин хуримтлагдаж буй хүнд металл хүний эрүүл мэнд, байгаль экологид хор хөнөөл учруулах эрсдэлтэй. Хүнд металлууд бүлгийн хүнцэл (As), хар тугалга (Pb), кадми (Cd), хром (Cr), мөнгөн ус (Hg), зэс (Cu), никель (Ni), цагаан тугалга (Tn) зэрэг нь хүний дархлааны тогтолцоог хямраах, хорт хавдар үүсгэх, хоол боловсруулах, дотор эрхтнийн өвчлөл, сэтгэцийн хямрал, генийн өөрчлөлтийг бий болгох зэргээр хүний эрүүл мэндэд ихээхэн хор уршигтай⁹. Иймд жилээс жилд өсч, зарим газарт зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан агууламжтай байгаа хүнд металлын бохирдлыг бууруулах, саармагжуулах арга хэмжээг цаг алдалгүй төлөвлөн хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай болно. Улаанбаатар хотын

⁹ Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас тодорхойлсноор хүний эрүүл мэндэд хамгийн их хор нөлөө учруулах химийн бодисуудад мөнгөн ус, хар тугалга, фтор, диоксин, кадми, хүнцэл, бензол, пестицидийг оруулсан байдаг.

хэмжээнд жилд нэг удаа 102 цэгт, орон нутгийн хувьд хоёр жилд нэг удаа 296 цэгт хүнд металл болон агрохимийн хяналт шинжилгээ хийдэг. Энэ нь тухайн орчны хөрсний бохирдлыг бүрэн илэрхийлж чаддаггүй¹⁰. Тиймээс хөрсний бохирдлын хяналт-шинжилгээ хийх давтамж, хяналтын цэгийн тоог нэмэгдүүлэх, лабораторийн хүчин чадлыг сайжруулах шаардлага оршоор байна.

ШУА-ийн Газарзүйн хүрээлэнгээс 2014 онд Улаанбаатар хотод хийсэн хөрсний судалгаагаар нийт 340 гаруй цэгээс авсан дээжний 88 хувьд нянгийн бохирдол илэрснээс гэр хороолол, томоохон зах, хур хогийн цэг орчмын хөрсөнд нянгийн бохирдол их байна. Мөн хөрсөнд органик гаралтай бохирдол (52.6 хувь), шивтрийн (88.4 хувь) болон сульфатын бохирдол (72 хувь) их байсан. Гэвч өнөөдөр энэхүү байдал хэрхэн өөрчлөгдсөн талаар давтан хийсэн судалгаа алга байна.



Зураг 2. Улаанбаатар хотын хөрсний бохирдлын тархалт

Эх сурвалж: ШУА-ийн Газарзүйн хүрээлэнгийн судалгааны үр дүн, 2014 он

¹⁰ Байгаль орчин, аялал жуулчлалын яам, 2017. Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2015-2016 он.

Улсын хэмжээнд нийт хүн амын 60 хувь буюу 1.8 гаруй сая хүн энгийн, доторлогоогүй нүхэн жорлон ашигладаг бөгөөд Улаанбаатар хотын хэмжээнд 2016 оны байдлаар 210 мянган уламжлалт ариун цэврийн байгууламж, 140 гаруй мянган угаадасны нүх тоологдсон байна. Үүний улмаас хүний ялгадас хөрсөнд шууд шингэж, хөрс, усны бохирдол үүсэх гол шалтгаан болж байгаа бөгөөд гэр хорооллын зарим бүсэд гэдэсний халдварт өвчин нэмэгдэх хандлагатай байна. 2008 онд хийсэн судалгаагаар Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн нийт гол, булаг шандны усны 45.4 хувь нь гэдэсний эмгэг төрөгч (E coli) бактериар бохирдсон дүн гарчээ¹¹. Хөрсний бохирдлоос үүдэлтэй гэдэсний халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо буурахгүй байгаа бөгөөд хүний эрүүл мэндэд үзүүлэх бусад нөлөөллийн судалгааг төдийлэн хийхгүй байна.

явдал хөрс бохирдох гол шалтгаан болж байна. Тухайлбал, газар тариалангийн зориулалтаар ашиглаж буй хөрсөнд хүнд металлууд, химийн хортой болон аюултай бодисын агууламж суурьшлийн болон үйлдвэрлэлийн бүс дэх дээрх бодисын зөвшөөрөгдөх агууламжаас бага байх зайлшгүй шаардлагатай. Хөрсний үржил шим буурахын хэрээр газар тариаланд химийн бордоо, пестицидийн хэрэглээ улам бүр өсөн нэмэгдэж байна.

Монгол Улсад химийн бодисын хяналтын эрхзүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн боловч хэрэгжилт хангалтгүйн улмаас хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд ноцтой хор хөнөөлтэй, байгальд удаан задардаг химийн бодис уул уурхай, арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэрт их хэмжээгээр ашиглаж, байгаль орчинд хаягдаж байна. Уул уурхайн

Халдварт өвчин (ӨОУА-10 нэршлээр)	2011		2012		2013		2014		Өсөлт бууралт 10,000 хүн амд
	Бодит тоо	10,000 хүн амд	Бодит тоо	10,000 хүн амд	Бодит тоо	10,000 хүн амд	Бодит тоо	10,000 хүн амд	
Балнад	2	0.0	0	0.0	0	0.0	4	0.0	0.0
Сальмонеллэз	118	0.4	112	0.4	83	0.3	95	0.3	0.0
Цусан суулга	2120	7.6	2051	7.3	1982	7.0	2312	7.9	+0.9
Суулгалт халдвар	75	0.3	86	0.3	84	0.3	162	0.6	+0.3
Цочмог А гепатит	13612	49.0	5892	21.0	1589	5.7	325	1.1	-4.6

Хүснэгт 2. Гэдэсний халдварт өвчин, 2011-2014 он

Эх сурвалж: Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн

Түүнчлэн орон нутагт уул уурхайн үйл ажиллагаа, дэд бүтэц, хөдөө аж ахуй, газар тариаланд химийн бодис ашиглах, хэрэглэх

¹¹ Amarzaya J. et al., 2015. The impact of the environment on health in Mongolia: A systematic review, *Asia-Pacific Journal of Public Health*, 27 (1), 45-75.

зориулалттай химийн бодисын ашиглалт, хэрэглээнээс үүдэлтэй хөрсний бохирдлын талаарх нэгдсэн статистик мэдээлэл хомс байгаа хэдий ч уул уурхайн үйл ажиллагаа, химийн бодисын зохисгүй хэрэглээнээс хөрс ихээр бохирдож, хүн амын эрүүл мэнд, байгаль орчин, экологид ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байгаа талаарх судалгааны үр дүн, мэдээлэл хангалттай байна¹².

¹² Хаан хор хүнцлээр Дорнодын хөрс бохирдсон түүх. <http://www.ikon.mn/n/fsq>, Дэлхийн байгаль

ХОЁР. ОРЧНЫ БОХИРДОЛ, ДОРЙТЛЫГ БУУРУУЛАХ ХУУЛЬ ЭРХЗҮЙ, БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ТОГТОЛЦОО

Монгол Улсад агаар, орчны бохирдлыг бууруулах, хүрээлэн буй орчныг хамгаалах хүрээнд хууль, бодлого, үндэсний хөтөлбөр зэрэг олон баримт бичгүүдээр эрхзүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн гэж үзэж болно¹³.

Агаарын бохирдлын хүрээнд:

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах бодлогын хүрээнд засгийн газрын түвшинд томоохон ажлуудыг хийсээр байгаа ч салбар хоорондын харилцан уялдаа хангалтгүй байна. Тухайлбал, нүүрс хямд худалдан авах үнийн хөнгөлөлт, нүүрсний нэг төрлөөс нөгөө рүү шилжих ажил агаарын бохирдлыг бууруулах тодорхой бодлогоор зохицуулагдах ёстой. Эрчим хүчний ашиглалттай холбоотой бодлого хотын агаарын бохирдлыг бууруулах ерөнхий бодлоготой уялдах учиртай. Сүүлийн хэдэн жил агаарын бохирдлын эх үүсвэрээс ялгарч буй утааны стандарт, техникийн шаардлагын талаар эрх зүйн тодорхой арга хэмжээг авч ирсэн байдаг. Гэсэн хэдий ч эдгээр хууль эрх зүйн актыг мөрдөхөд шаардагдах нөөц, эрх зүйн бүтэц хангалтгүй байна. Тухайлбал утааны ялгарлын стандарт мөрдүүлэх ажлыг хариуцдаг хэлтэс, газруудад утааны ялгарлыг хянах тоног төхөөрөмж, нөөц дутагдалтай байна. Тоног төхөөрөмж, техникийн мэдлэг, мэдээлэлгүй бол тухайн стандарт мөрдөгдөж буй эсэхийг тодорхойлох, эсвэл стандартын зөрчилтэй байгаа эсэхийг хянах боломжгүй юм.

хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, 2007. Химийн хорт бодис ба уул уурхайн асуудал тайлан.

¹³ Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995), Усны тухай хууль (2012), Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль (2010), Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль (2012), Хог хаягдлын тухай хууль (2017), болон үндэсний хөтөлбөрүүд

Хөрсний бохирдлын хүрээнд:

Хөрс хамгаалах, хөрсний доройтол, бохирдлыг бууруулах талаар Монгол Улсад олон тооны хууль эрхзүйн баримт бичиг бий. Сүүлийн байдлаар хөрс хамгаалах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2016 оны 158 тоот зарлигийн дагуу Засгийн газраас хөрс хамгаалах үндэсний хөтөлбөрийг боловсруулж байна. Хөтөлбөр боловсруулах ерөнхий агуулгын хүрээнд хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд судалгаа хийн эрх зүйн орчинг сайжруулахаас гадна салбар дундын зохион байгуулалт, шинжлэх ухааны байгууллага, судалгааны лабораториудын хүчин чадал, чадавхийг бэхжүүлэх, мэргэшүүлэх зэрэг асуудлыг тусгах аж. Хөрсний доройтол, бохирдлыг бууруулахад тус хөтөлбөрийг Засгийн газраас ойрын хугацаанд баталж, орон даяар системтэй хөрсний бохирдлын судалгаа явуулах, хөрсний бохирдлын үндэсний мэдээллийн нэгдсэн сан байгуулах, хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээрх төслийн жагсаалтыг боловсруулах зэрэг олон ажлыг шат дараалан хийж гүйцэтгэх шаардлагатай болно.

Усны бохирдлын хүрээнд:

Усны нөөц, усан орчныг бохирдол, доройтлоос хамгаалах чиглэлээр хийсэн бодлогын гол шинэчлэлүүдийн нэг болох бохирдуулагч нь төлбөр төлөх зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор “Усны тухай хууль”, “Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль”-ийг 2012 онд УИХ-аар баталсан юм. Гэвч өнөөг хүртэл ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх журмыг батлаагүйн улмаас бохирдуулагч нь төлбөр төлөх зарчим хэрэгжихгүй, усны нөөцийг зохисгүй ашиглах, бохирдуулах явдлыг гааруулж байна.

Тухайлбал, Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газартай гэрээ байгуулж, бохир ус нийлүүлж буй нийт 225 аж

ахуйн нэгж (машин угаалгын 55, махны үйлдвэр 37, архи ундааны үйлдвэр 33, арьс ширний үйлдвэр 24, ноосны үйлдвэр 23, ресторан зочид буудал 23, өлөнгийн үйлдвэр 18, сүүний үйлдвэр 12)¹⁴ байна. Гэвч “Усны тухай хууль”¹⁵, “Ус бохирдуулсны тухай хууль”¹⁶-ийн холбогдох заалтууд буюу ус бохирдуулагч аж ахуйн нэгж ус бохирдуулсны төлбөр төлөх, ус бохирдуулагчийн гаргаж буй хаягдал усанд агуулагдах бохирдол зохих стандартаас давбал ус бохирдуулсны төлбөрийг гурав дахин нэмэгдүүлж нөхөн төлбөр төлөх заалтууд эдгээр хуулиудыг дагаж мөрдөх журам байхгүйн улмаас хэрэгжихгүй байгаагаас ус бохирдуулагч аж ахуйн нэгжүүд зөвхөн бохир ус татан зайлуулсны үйлчилгээний төлбөрийг төлж, ус бохирдуулсны хариуцлагыг хүлээхгүй байгаа нь зохисгүй юм. Иймд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, холбогдох

¹⁴ Г.Одгарав, 2017. Сая хүний ундны усыг угаадас болгож буй үйлдвэрүүд “өрөө төл”. Эх сурвалж: <http://news.gogo.mn/t/209397>

¹⁵ Усны тухай хуульд: “25.1.Ус бохирдуулагч нь хаягдал усныхаа тоо хэмжээ, найрлагад хяналт тавих, хаягдал усны стандартын шаардлагад нийцүүлэн бохир усыг цэвэрлэж зайлуулах, ус бохирдуулсны төлбөр төлөх үүрэг хүлээнэ. 25.2.Ус бохирдуулагч нь бохирдуулах бодисыг хаягдал усны стандартад заасан хэмжээнээс хэтрүүлэн гаргасан тохиолдолд мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн байгаль орчны байцаагч ус бохирдуулсны нөхөн төлбөрийг ногдуулж, төлөлтөд хяналт тавих бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг ус бохирдуулсны төлбөрийг экологи-эдийн засгийн үнэлгээг үндэслэн гурав дахин нэмэгдүүлж бохирдуулах бодис бүрээр тогтооно.” гэж заасан байдаг.

¹⁶ Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд: “5.1.Ус бохирдуулсны төлбөр төлөгчийн гаргасан дараах хаягдал усанд ус бохирдуулсны төлбөр ногдуулна: 5.1.1.хаягдал усны стандартад нийцүүлэн зөвшөөрсөн хязгаарын дотор байгальд шууд нийлүүлж байгаа хаягдал ус; 5.1.2.ариутгах татуургад нийлүүлэх бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд агууламжийн стандартад нийцүүлэн ариутгах татуургад нийлүүлж байгаа хаягдал ус.” гэж заасан байдаг.

журмуудыг нэн яаралтай боловсруулан батлуулах шаардлагатай байна.

Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр:

Орчны бохирдол, доройтлын асуудлыг сүүлийн үед хурцаар хөндөж байгаад төрөөс анхаарал хандуулж 2017 оны 1 дүгээр сард Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нээлттэй хуралдан хийж, 03/03 тоот зөвлөмж гаргасан юм. Энэхүү зөвлөмжийн дагуу Засгийн газраас хот суурин газрын агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг боловсруулан 2017 оны 3 дугаар сард баталсан. Тус хөтөлбөрийн хүрээнд орчны бохирдлыг бий болгож буй эх үүсвэрийг бууруулах, арилгахад чиглэсэн 5 зорилт, 58 арга хэмжээг 2025 он хүртэл 2 үе шаттайгаар авч хэрэгжүүлэхэд 9.9 их наяд төгрөг зарцуулахаар төлөвлөж байна. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлснээр Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь бууруулна гэж үзэж байна. Гэхдээ хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийж үзэхэд дараах зүйлсэд анхаарах нь зүйтэй. Үүнд:

Хөтөлбөрт агаар, хөрс, усан орчны бохирдлыг бууруулахад авах арга хэмжээнүүдийг цогц байдлаар оруулаагүй, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны дараалал тодорхой бус байгаа нь хөтөлбөрийн эцэст орчны бохирдлыг дорвитой бууруулахад сөргөөр нөлөөлж болзошгүй.

Хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулах хүрээнд хэрэгжиж буй үндэсний бусад хөтөлбөртэй хэрэгжүүлэх үйл ажиллагааны давхцал их байна. Хөтөлбөр бүр түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, зориулсан төсөвтэй. Иймд энэхүү давхцыг арилгах нь зүйтэй. Тухайлбал, хог хаягдлын менежментийг сайжруулах

үндэсний хөтөлбөрт туссан асуудлыг давхар тусган төсөв хөрөнгө гарган хэрэгжүүлэхээр заасан байдаг.

Бохирдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлэхээс гадна бохирдлын хэмжээг доод түвшинд байлгахад байгаль орчны стандартууд чухал юм. Эдгээр стандарт нь агаар, ус, хөрсөнд агуулагдаж болох бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх (хүлцэх) дээд хэмжээг нэгдсэн байдлаар тогтоон, хөрсний бохирдол, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, тухайн газар нутгийн байгаль орчны мониторинг, хяналт, байгаль хамгаалал, хүн амын эрүүл ахуй, эрдэм шинжилгээ, хөдөө аж ахуйн чиглэлээр хийж буй судалгааны ажлуудад мөрдлөг болгохоор заасан байдаг. Иймд агаар, хөрс, усан орчны чанарын стандартыг чангатгах шаардлагатай байна.

Орон нутагт орчны бохирдол, нэн ялангуяа гадаргын болон газрын доорх ус, хөрсний бохирдлын асуудал анхаарал татсан хэвээр байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн орчны бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар дорвитой арга хэмжээг тусгаагүй байна. Монгол Улсын Засгийн газраас ирэх онуудад уул уурхай, ашигт малтмалын олборлох, боловсруулах үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх бодлого баримталж байна. Иймд орон нутагт үйлдвэрлэл түлхүү хөгжихийн хэрээр орчны бохирдлын асуудлууд урган гарах учир байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, мониторинг, хяналт шинжилгээг сайжруулах зайлшгүй шаардлагатай болно.

ДҮГНЭЛТ

Өнөөдрийн байдлаар үйлдвэржилт бага хөгжсөн явдал Улаанбаатар хот, бусад суурин газрын хөрсний хүнд металл, удаан задардаг органик нэгдлүүдээр харьцангуй бага бохирдох шалтгаан болж байгаа хэдий ч бохирдлыг бууруулах, хөрс

хамгаалах бодлого, арга хэмжээг тууштай хэрэгжүүлэхгүй бол хүрээгээ тэлж буй хотжилт, үйлдвэржилтийн нөлөөгөөр хүн амын эрүүл мэндэд өндөр эрсдэл учруулахуйц бохирдлын агууламж улам нэмэгдэхээр байна.

Нөгөө талаар хүнсний аюулгүй байдалд чухал нөлөө үзүүлэх хөдөө аж ахуйн газрын хөрсний бохирдлын асуудалд ач холбогдол өгч урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Ингэхдээ хөрсний чанарын стандартыг орон нутгийн хөрсний суурь нөхцөлтэй уялдуулан шинэчлэх, хөрсний бохирдлыг стандарт түвшинд байлгахад илүүтэй бохирдлын түвшинг нэмэгдүүлэхгүй байх, бууруулах арга хэмжээг орон нутгийн түвшинд түлхүү авч хэрэгжүүлэх нь зүйтэй. Мөн суурьшлын, хөдөө аж ахуйн, үйлдвэрлэлийн бүс зэрэг газар ашиглалтын ялгаатай хэлбэрүүдэд хөрсний чанарын стандартыг ялгаатай байдлаар тогтоох нь зүйтэй.

Хот суурин газрын агаар, орчны бохирдол, түүний улмаас эдийн засаг, байгаль орчин, хүн амын аюулгүй байдалд учруулж буй эрсдлийг бууруулахад Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр чухал ач холбогдолтой. 2025 он хүртэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад байгаль орчныг хамгаалах хүрээнд хэрэгжиж буй үндэсний бусад бодлого, хөтөлбөртэй уялдаа холбоог сайжруулах, бохирдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, арилгах (pollution prevention) зарчмыг үндэс болгохоос гадна бохирдлын хэмжээг доод түвшинд байлгах агаар, хөрс, усан орчны чанарын стандартыг чангатгах бохирдлын хяналтын зарчим (pollution control)-ыг давхар хэрэгжүүлэх; хот суурины орчны бохирдлоос гадна орон нутгийн байгаль орчны бохирдлыг бууруулах, бохирдлоос урьдчилан сэргийлэхэд онцгой анхаарч уул уурхайн олборлолт, боловсруулалт, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дэх байгаль орчны хяналт, үнэлгээг сайжруулах арга хэмжээг нэмж

.....оруулах; холбогдох
ямд болон олон
улсын байгууллагуудын үйл ажиллагааны харилцан уялдаа холбоог сайтар хангаж ажиллах явдал
чухал байна.

Эх сурвалж

- Allen R. W. et al. (2013). An assessment of air pollution and its attributable mortality in Ulaanbaatar, Mongolia. *Air Quality, Atmosphere & Health*, 6(1), 137–150. <http://doi.org/10.1007/s11869-011-0154-3>
- Amarzaya J. et al. (2015). The impact of the environment on health in Mongolia: A systematic review, *Asia-Pacific Journal of Public Health*, 27(1), 45-75.
- Guttikunda S. et al. (2013). Particulate Pollution in Ulaanbaatar, Mongolia. *Air Quality, Atmosphere and Health*, 6, 589-601. <http://dx.doi.org/10.1007/s11869-013-0198-7>
- Institute for Health Metrics and Evaluation (IHME). Монгол 2013. www.healthdata.org.
- Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (2015). Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2013-2014.
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам, 2017. Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2015-2016 он.
- Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, 2007. Химийн хорт бодис ба уул уурхайн асуудал, тайлан.
- Г.Одгарав, 2017. Сая хүний ундны усыг угаадас болгож буй үйлдвэрүүд “өрөө төл”. Эх сурвалж: <http://news.gogo.mn/r/209397>
- НҮБ-ын хүүхдийн сан, 2016. Хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын үзүүлэх нөлөө, шийдвэрлэх арга зам.
- С.Очир ба бусад, 2014. Төслийн төгсгөлийн тайлан: Улаанбаатар хотын агаарын бохирдол ба эрүүл мэнд. Улаанбаатар хот.
- Эрүүл мэндийн яам (2011). “Хүрээлэн буй орчны бохирдол хүний эрүүл мэндэд” судалгаа шинжилгээний тайлан.



Э.ЭНХМАА Ph.D
Ж.БАТСУУРЬ Sc.D

МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ОРОН ЗАЙН БАЙРШИЛ БА НЯГТРАЛЫН ГАЗАРЗҮЙН ТАРХАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

We have studied current situation of the geographical location and density of the Mongolian population. Based on three year average between 2013-2015, total of 1568358 people were living in 21 aimags, of which 38.2% were in the aimags' centers, 0.3% were in the villages, 22.1 % were in the soums' centers and 39.4% were living in the rural baghs. These results show the growing imbalance in the spatial distribution of the Mongolian population. At the aimag level, the Selenge has the highest population density and Umnugovi has the lowest population density. It has been observed that "mean population density" in the non-boundary soums was two times higher than that in the boundry soums.

ОРШИЛ

Өргөн уудам нутаг дээр цөөн хүн амьдрах нь хүн амын удмын сангийн аюулгүй байдал болон нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангахад ихээхэн эрсдэл дагуулдаг. Хүн амын нягтрал хэт сийрэг байх нь гэрлэх насны залуус бие биеэ сонгох сонголтыг хязгаарлаж улмаар хүн ам дахь цус ойртолтыг өсгөх ноцтой шалтгаан

болдог жамтай. Үндэсний Статистикийн Хорооны албан ёсны статистик мэдээлэл¹ тулгуурлан Монгол Улсын 21 аймгийн 2013-2015 оны хүн амын орон зайн байршил, нягтралыг гурван жилийн дунджаар

¹ Үндэсний Статистикийн Хорооны мэдээллийн www.1212.mn цахим хуудас, ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны мэдээлэл

тооцоолж, нарийвчилсан судалгаа хийхэд дараах үр дүнгүүд гарч байна.

ХҮН АМЫН ОРОН ЗАЙН БАЙРШИЛ

2013-2015 оны дунджаар 21 аймагт 1,568,358 хүн амьдарч байгаагаас 38.2 хувь нь аймгийн төвд, 0.3 хувь нь хот тосгонд, 22.1 хувь нь сумын төвд, 39.4 хувь нь хөдөөд байна.

Аймгийн нийт хүн амд аймгийн төвийн эзлэх хүн ам 17.6-95.2 хувийн хооронд үлэмж


хэлбэлзэлтэй байгаа ба дундаж нь 38.2 хувь байна (Зураг 1). Аймгийн нийт хүн амд сумын төвийн хүн ам дунджаар 22.1 хувийг харин хөдөөгийн хүн ам 39.4 хувийг эзэлдэг ажээ (Зураг 2, 3).

Ийнхүү 2013-2015 оны дунджаар аймгийн төвийн суурин хүн ам хөдөөгийн хүн амтай ойролцоо (Зураг 1, 3) байгаа нь хүн амын хэт төвлөрлийн улмаас Монгол Улсын хүн амын орон зайн байршил нэлээд тэнцвэргүй болсныг илэрхийлж байна.

Зураг 1. Аймгийн нийт хүн амд аймгийн төвийн хүн амын эзлэх хувь



Зураг 2. Аймгийн нийт хүн амд сумын төвийн хүн амын эзлэх хувь




Зураг 3. Аймгийн нийт хүн амд сумын хөдөөгийн хүн амын эзлэх хувь



АЙМГИЙН ТҮВШИН ДЭХ ХҮН АМЫН НЯГТРАЛ

Аймгийн төвийн болон сумын төвийн суурин хүн амыг оролцуулан макро түвшинд тооцоолж гаргасан 2013-2015 оны хүн амын дундаж нягтралаас үзвэл хүн амын нягтрал багатай эхний таван аймагт Өмнөговь (0.37), Говь-Алтай (0.40), Дорноговь (0.58), Дундговь (0.59), Дорнод (0.62) багтаж байгаа бол Сэлэнгэ аймагт (2.54) хүн амын нягтрал хамгийн их байна (Зураг 4).

Зураг 4. 2013-2015 оны хүн амын дундаж нягтралын аймагчилсан тархалт




2013-2015 оны хүн амын дундаж нягтралын газарзүйн тархалтын зураглалаас харвал их нягтралын голомт төв нь (эпицентр) Сэлэнгэ аймагт байгаа бол Баян-Өлгий аймагт хоёр дахь түвшний, Архангай, Өвөрхангай аймагт гурав дахь түвшний голомтууд байршиж байна. Харин Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь, Баянхонгор, Говь-Алтай зэрэг хилийн аймагт бараг бүхэлдээ, цаашилбал Ховд, Увс, Завхан, Хөвсгөл, Хэнтий зэрэг 5 аймгийн улсын хилийн дагуух нутагт хүн амын нягтрал хэтэрхий багасчээ. Өөрөөр хэлбэл, Монгол орны нутаг дэвсгэрийн даруй 50 хувьд хүн амын суурьшлын хэт

сийрэгжилт үүссэнийг атлас зургаас тодорхой харж болно (Зураг 5). Хүн ам цөөн тоотой амьдарч буй дээрх аймагт цус ойртолтын түвшин өндөр

байдаг.² Ийнхүү хүн амын нягтрал багасахын хэрээр цөөн хүн хүссэн хүсээгүй олон үе удам дамнан өөр хоорондоо гэрлэж алсуур цус ойртолтыг өсгөсөөр байна.

Зураг 5. 2013-2015 оны хүн амын дундаж нягтралын газарзүйн тархалт



СУМЫН ТҮВШИН ДЭХ ХҮН АМЫН НЯГТРАЛ

Монгол Улсын засаг захиргаа өнөөгийн байдлаар 21 аймаг, 330 сум, 1615 багт хуваагдсан бүтэцтэй байгаа. Сумдын түвшинд хүн амын нягтралыг бодитой гаргахын тулд аймгийн төв болон сумын төвийн суурин хүн амыг хасч тооцоолсон болно. Учир нь суурин хүн ам нь өөрийн жингээр нэг хавтгай дөрвөлжин километр нутагт оногдох хүний тоог өсгөөд байдаг. Ийнхүү тооцоход Монгол Улсын хилийн бус сумдын түвшинд хүн амын дундаж нягтрал 0.05-2.38-ын хооронд хэлбэлзэж дундаж нь 0.63 байв.


Харин Монгол Улсын хилийн дагуух

14 аймгийн 67 сумыг тусад нь ялгаж тооцоолоход хүн амын дундаж нягтрал 0.05-1.36-ын хооронд хэлбэлзэж дундаж нь 0.34 байв. Ийнхүү хилийн сумдын хүн амын дундаж нягтрал хилийн бус сумдын хүн амын дундаж нягтралаас бараг хоёр дахин бага байгаа нь тогтоогдлоо.

ОХУ-тай хил залгаа 32 сумын хүн амын дундаж нягтрал 0.07-1.36-ын хооронд хэлбэлзэж дундаж нь 0.40 (Зураг 6) байгаа бол БНХАУ-тай хиллэдэг 37 сумын хүн амын дундаж нягтрал 0.05-1.12-ын хооронд хэлбэлзэж дундаж нь 0.31 байна (Зураг 7).


Ийнхүү БНХАУ-тай хиллэдэг сумдын хүн амын дундаж нягтрал нь ОХУ-тай хиллэдэг сумдын хүн амын дундаж нягтралаас 1.3 дахин бага байгааг онцгой анхаарвал зохилтой.

Зураг 6. ОХУ-тай хиллэдэг сумдын хүн амын дундаж нягтрал (2013-2015 он)



² “Монгол Улсын иргэн угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загвар” ном. УБ., 2010 он

Зураг 7. БНХАУ-тай хиллэдэг сумдын хүн амын дундаж нягтрал (2013-2015 он)



ДУГНЭЛТ

2013-2015 оны дундаж үзүүлэлтээр Монгол Улсын 21 аймгийн хүн амын 60 гаруй хувь нь аймаг, сумын төвд, 40 орчим хувь нь хөдөөд амьдарч байгаа төдийгүй аймгийн төвийн хүн ам (38,2 хувь) хөдөөгийн нийт хүн ам (39,4 хувь)-тай ойролцоо байгаа нь манай улсын хүн амын орон зайн байршил ихээхэн тэнцвэргүй болсныг харуулж байна.

Аймаг, сумын төвийн суурин хүн амыг оруулан тооцсон хүн амын нягтралын газарзүйн тархалтын зургаас үзэхүл үндсэндээ Монгол орны өргөргийн 460-ын

зурвасаас 410 зурвас руу, уртрагийн 1090-ын зурвасаас 1200 зурвас руу ойртох тусам хүн амын суурьшлын хэт сийрэгжилт бий болсон үзэгдэл илэрч байна.

Монгол Улсын хилийн дагуух сумдын хүн амын дундаж нягтрал хилийн бус сумдынхтай харьцуулахад хоёр дахин бага, мөн өмнөд хөрштэй хил залгаа сумдад хүн амын дундаж нягтрал хойд хөрштэй хиллэдэг сумдынхаас 1.3 дахин бага байгаа нь хил хязгаар нутагт эзэнгүйдэл бий болсныг гэрчилж байна.



С.АЛТАНЧИМЭГ

МЭДЛЭГИЙН МЕНЕЖМЕНТ ТӨРИЙН БОДЛОГЫН ЗАЛГАМЖ ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ НЬ

The article aims to clarify what knowledge management and knowledge are, how the knowledge management for the public sector is understood, and the effectiveness of knowledge management of public institutions in the continuity of public policy.

ОРШИЛ

Өнөөдөр дэлхий ертөнц глобалчлагдаж өндөр мэдлэг боловсрол бүхий оюуны чадамжтай чадварлаг боловсон хүчний эрэлт хэрэгцээ улам нэмэгдэж, аливаа байгууллага, хувь хүний өрсөлдөх чадварын гол цөм мэдлэг болсон төдийгүй шинэ зууны хөгжлийн хөдөлгөгч хүч мэдлэгт суурилсан эдийн засаг болж буй явдал мэдлэгийн менежментийг хөгжүүлэх шаардлага, нөхцөлийг бүрдүүлж байна.

Дэлхий дахины энэ шинэ хандлагыг манай улс соргоогоор мэдэрч, хөгжил дэвшил, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн суурь баримт бичигтээ тухайлан

зааж, бодлогын үндсийг тодорхойлсон юм. Тухайлбал, Монгол Улсын “Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”¹-д 2015 оноос Монгол Улс мэдлэгт суурилсан эдийн засагт шилжихээр заасан билээ.²

Үндэсний аюулгүй байдлын Үзэл баримтлалын 1.2.4-д “Аюулгүй байдалд хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагаа нь мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээнд суурилна” хэмээн үндэсний

¹ УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоол

² Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого

аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчмыг тодорхойлсон байдаг.³

Дээрх учир шалтгаанаас үүдэн энэхүү өгүүлэлд мэдлэгийн менежмент, мэдлэгийн тухай ойлголт өгч, төрийн байгууллагууд мэдлэгийн менежментийг хэрхэн ойлгож буй болон төрийн бодлогын залгамж чанарт төрийн байгууллагын мэдлэгийн менежмент ямар нөлөөтэй болохыг тодруулахыг зорилоо.

Мэдлэгийг удирдаж, хөгжил дэвшлийг хурдасгах хэрэгцээ, шаардлагыг төрийн бүхий л байгууллагад тавьж, улс орны хөгжлийн тулгуур мэдлэг болж байна. Иймд мэдлэгийн менежмент гэдэг чухам юу болох, ямар ач холбогдолтой байдаг талаар судлаачид хэрхэн авч үзсэнийг товч өгүүлье.

Эрдэмтэн Пандиа (Pandya.K,C) “Төрийн салбарын доод түвшний ажилтнаас эхлэн менежерүүдийн хувьд мэдлэгийн менежментийг мэдэх хэрэгцээ өсч байна”⁴ гэжээ. Харин эрдэмтэн Питер Дракер (Peter Drucker) “Мэдлэгийн менежмент бол мэдэж байгаа нэгнийг мэдэх хэрэгцээтэй байгаа нэгэнтэй үр дүнтэйгээр холбох, хувь хүний мэдлэгийг байгууллагын мэдлэг болгон хувиргах явдал юм” гэжээ.

Эрдэмтэн Прукэ (Pryke.J,F) “Мэдлэгийн менежмент нь байгууллагын хэмжээнд их хэмжээний мэдлэгийг системтэйгээр бий болгох, хамгаалах, хуваалцах, хэрэглэх үйл явцыг хамарсан процесс”⁵ гэж томъёолсон байна.

Мэдлэг бол “хэрэглэх мэдээлэл” буюу “боловсруулсан мэдээлэл” бөгөөд үе шат бүр нь өмнөх үе шатаасаа хамааралтай

байдаг.⁶ Харин өгөгдөл бол түүхий тоо, баримт харин мэдээлэл нь боловсруулсан өгөгдөл бөгөөд мэдлэг нь баталгаатай мэдээлэл юм.⁷

Эрдэмтдийн гаргасан дээрх дүгнэлтээс үзвэл төрийн байгууллагын мэдлэгийн менежмент бол шинэ үзэл санаа бөгөөд төрийн байгууллагуудад өрсөлдөх чадварыг сайжруулах шинэлэг арга юм.

Монгол Улсад 2000-аад оноос төрийн байгууллагын мэдлэгийн менежментийн талаар судалж эхэлсэн бөгөөд цөөн тооны судалгаа хийсэн байна. Үүнд:

Доктор, дэд профессор С.Энхсайхан 2010 онд төрийн байгууллагын 321 ажилтан албан хаагчдыг хамруулсан “Төрийн байгууллагын бүтээмж” судалгааныхаа хүрээнд төрийн бүтээмжид анализ хийж, эрдэмтэн судлаачид, төрийн захиргааны байгууллагын удирдах ажилтнуудыг оролцуулан нийт 21 экспертээр үнэлүүлэхэд Монгол Улсын төрийн байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх хувь хүний хүчин зүйлд мэдлэг боловсрол хамгийн өндөр ач холбогдолтой байжээ⁸.

Доктор Д.Төмөрпүрэв 2011 онд “The Effect of Socio-Technical Enablers on Knowledge Sharing in E-Government of Post-Socialist Countries: A Mongolian Case Study” диссертацийнхаа хүрээнд Монгол Улсын төрийн байгууллагын ажлын үр дүн болон мэдлэгийн менежментийн хамаарлыг судалж, түүнд нөлөөлөх нийгмийн (стратегийн, манлайлал, бүтэц, урамшуулал, итгэлцэл болон танилын холбоо) болон техникийн (мэдээллийн технологийн дэд

⁶ Minnaar, F. &. (2005). Public management in the information age, Van Schaik, Pretoria.

⁷ Alavi, M., and Leinder, D.E. (2001). Knowledge Management and Knowledge Management Systems:

Conceptual Foundations and Research Issues. *MIS Quarterly, March*, 107-136.

⁸ Төрийн байгууллагын бүтээмж, С.Энхсайхан, 2010 он

³ Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлал

⁴ Pandya, K, C. &. (2003). Issues of KM in the public sector. *Electronic Journal of Knowledge Management* 1(2), 25-33.

⁵ Pryke, J, F. &. (2003). KM in public service provision: The child support agency. *International Journal of Service Industry Management* 14(3), 254-28.

бүтэц болон мэдээллийн технологийн хэрэглээ) хүчин зүйлийн нөлөөллийг шинжилжээ.⁹

Доктор Д.Байгал 2013 онд “Төрийн захиргааны албан тушаалын мэдлэг чадварын шаардлагын шинжилгээ” диссертацидаа мэдлэг чадварын тухай онол, үзэл баримтлал, хөгжлийн хандлага болон өнөөгийн төрийн захиргааны албан тушаалд тавигдаж байгаа мэдлэг чадварын бодит байдал, шаардлагыг тодорхойлжээ.¹⁰

Дээрх судалгааны үр дүнгээс үзэхэд Монгол Улсын төрийн албан хаагчид мэдлэг хэрэгтэй гэдгийг маш сайн ойлгож, хүлээн зөвшөөрч буй бөгөөд төрийн байгууллагын ажлын үр дүн мэдлэгийн менежменттэй эерэг хамааралтай болох нь тодорхой байна. Түүнчлэн төрийн байгууллагад мэдлэгийг удирдах арга механизм хангалтгүй, мэдлэгийн менежментийн ач холбогдлыг бүх шатандаа сайн ойлгохгүй байгаа дүр зураг харагдаж байна.

Аливаа улс орны төрийн алба хэдий чинээ мэргэшсэн, тогтвортой байх тусам тухайн орны улс төр, эдийн засаг, нийгмийн хүрээг хамарсан өөрчлөлт, шинэтгэлийн үр дүн төдий чинээ сайжирч, нийгмийн хөгжлийн хөтөч болж чаддаг байна. Иймд Монгол Улсын төрийн албан хаагч дэлхийн бусад орны төрийн албан хаагчаас дутахааргүй мэдлэг чадвар, зүтгэлтэй байх явдал төрийн бодлого чанартай, бодитой, төрийн үйлчилгээ чанартай, ард иргэдэд хүртээмжтэй байх, улс үндэсний язгуур эрх ашгийг сахин хамгаалах дархлаа батжих, олон улсын тавцанд эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулахад зайлшгүй шаардлагатай суурь нөхцөл болно. Түүнчлэн төрийн алба тогтвортой,

⁹ The Effect of Socio-Technical Enablers on Knowledge Sharing in E-Government of Post-Socialist Countries: A Mongolian Case Study, Tumurpurev Dulambazar, 2011

¹⁰ “Төрийн захиргааны албан тушаалын мэдлэг чадварын шаардлагын шинжилгээ”, Д.Байгал, 2013 он

мэргэшсэн байх явдал улс орны тогтвортой хөгжлийн чухал хүчин зүйл төдийгүй Монгол төрийн бодлогын залгамж чанар, төрийн удирдлагыг бэхжүүлэх үндэс юм.


Төрийн алба тогтвортой байх гэдэгт төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын тогтвортой байдал болон төрийн албан хаагчийн тогтвортой ажиллах баталгаа багтдаг.

Манай улс 1995 онд Төрийн албаны хуулиа баталж, Төрийн албаны зөвлөлийг байгуулсан байдаг. 2008 онд Төрийн албаны хуулинд нэмэлт өөрчлөлт оруулан улс төрийнхөөс бусад ангиллын төрийн албан хаагчдыг намын харьяалалгүй байлгах шийдвэр гаргасан юм. Гэсэн хэдий ч Засгийн газар бүтцээ тухай бүр өөрчлөх эрх зүйн зохицуулалт үйлчилж байгаа тул яам, агентлагийн бүтэц бүрэлдэхүүний өөрчлөлт сонгууль болгоны дараа хөндөгдөж байна. Төрийн захиргааны албан тушаал мэргэшсэн, тогтвортой байхыг чухалчилдаг онцгой байр суурьтай бөгөөд түүний чиг үүргийг Төрийн албаны тухай хуулийн 7.1-д “төрийн бодлого боловсруулахад мэргэшлийн зөвлөгөө өгөх, уг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах” хэмээн заасан байдаг.

Манайд Засгийн газар солигдох тоолонд төрийн байгууллагуудыг судалгаагүйгээр бүтцийн өөрчлөлт нэрээр нэгтгэх, салгах, шинээр байгуулах болон татан буулгаж, албан хаагчдыг байнга сольж өөрчлөн улмаар нэгэнт бүрдсэн мэдлэг, туршлага, чадавхийг сарниулах үзэгдэл элбэг болохыг доорх жишээ харуулж байна.¹¹

¹¹ Төрийн албаны зөвлөлийн тайлан, 2015

Зураг 1. Засгийн газрын бүтцийн өөрчлөлт



Эх сурвалж: “Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого 2015-2040” төсөл

Монгол Улсын Засгийн газар 2016 оны УИХ-ын сонгуулиас хойш 14 яам 27 агентлагтай ажиллаж байна.

Төрийн захиргааны байгууллагыг ингэж өөрчлөх явдал төрийн байгууллагын хэмжээнд их хэмжээний мэдлэгийг системтэйгээр бий болгох, хамгаалах, хуваалцах, хэрэглэх үйл явц буюу төрийн байгууллагын мэдлэгийн менежментийг алдагдуулах төдийгүй төрийн албан хаагчдын тогтвортой ажиллахад сөргөөр нөлөөлж, төрийн бодлогын залгамж чанар алдагдахад хүргэж байна. Өөрөөр хэлбэл, Засгийн газар солигдох болгонд бүтцийн өөрчлөлт хийснээр өмнөх засгийн газрын үед бүрэлдэж бий болсон хэрэгтэй мэдлэг, мэдээлэл, туршлага буюу төрийн чухал бодлого хамгаалж, хадгалж дараагийн засгийн газрын үйл ажиллагаанд хэрэглэж, хуваалцах боломжгүй болдог

учраас төрийн бодлогын залгамж чанар алдагдаад байна.

Иймд төрийн бодлогын залгамж чанар гэдэгт зөвхөн төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын тогтвортой байдал болон төрийн албан хаагчийн тогтвортой байдлыг авч үзэх нь хангалтгүй бөгөөд төрийн байгууллагын мэдлэгийн менежментийг орхигдуулж болохгүй юм.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын төрийн албан хаагчид мэдлэг хэрэгтэй гэдгийг маш сайн ойлгож, хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд төрийн байгууллагын ажлын үр дүн мэдлэгийн менежменттэй эерэг хамааралтай болох нь тодорхой байна. Түүнээс гадна төрийн байгууллагуудад мэдлэгийг удирдах арга механизм хангалтгүй, мэдлэгийн менежментийн ач холбогдлыг бүх шатандаа сайн ойлгохгүй байгаа дүр зураг харагдаж байна.

Засгийн газар солигдох болгонд бүтцийн өөрчлөлт хийснээр өмнөх засгийн газрын үед бүрэлдэж бий болсон хэрэгтэй мэдлэг, мэдээлэл, туршлага буюу төрийн чухал бодлогыг хамгаалж, хадгалж дараагийн засгийн газрын үйл ажиллагаанд хэрэглэж, хуваалцах боломжгүй болдог учраас төрийн бодлогын залгамж чанар алдагдаад байна .

Төрийн бодлогын залгамж чанар гэдэгт зөвхөн төрийн байгууллагын бүтэц, зохион

байгуулалтын тогтвортой байдал болон төрийн албан хаагчийн тогтвортой байдлыг авч үзэх нь хангалтгүй бөгөөд төрийн байгууллагын мэдлэгийн менежментийг орхигдуулж болохгүй юм.

Иймд төрийн байгууллагад мэдлэгийн менежментийг нэвтрүүлэх асуудлыг төрөөс дэмжиж, энэ талаарх судалгааны шинжилгээний ажлыг олон хувилбараар хийх зайлшгүй хэрэгцээ шаардлага урган гарч байна.

ЭХ СУРВАЛЖ

- Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого
- “Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого 2015-2040” төсөл
- “Төрийн захиргааны албан тушаалын мэдлэг чадварын шаардлагын шинжилгээ”, Д. Байгал, 2013 он
- Төрийн албаны зөвлөлийн тайлан, 2015 он
- Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлал
- Төрийн байгууллагын бүтээмж, С.Энхсайхан, 2010 он
- Alavi, M., and Leinder, D.E. (2001). Knowledge Management and Knowledge Management Systems: Conceptual Foundations and Research Issues. MIS Quarterly, March , 107-136.
- The Effect of Socio-Technical Enablers on Knowledge Sharing in E-Government of Post-Socialist Countries: A Mongolian Case Study, Tumurpurev Dulambazar , 2011
- Pandya, K. C. &. (2003). Issues of KM in the public sector. Electronic Journal of Knowledge Management 1(2), 25-33.
- Pryke, J. F. &. (2003). KM in public service provision: The child support agency. International Journal of Service Industry Management 14(3), 254-28.
- Minnaar, F. &. (2005). Public management in the information age, Van Schaik, Pretoria.



Б.ЭРДЭНЭБАТ

ЗЭВСЭГЛЭЛ, БАЙЛДААНЫ ТЕХНИКИЙН ХАНГАЛТ БОЛ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БАЙГУУЛАЛТЫН ЧУХАЛ АСУУДАЛ МӨН

In the article entitled “Weapons and technical supplies are important for structure of armed forces”, the author shares his concerns and proposes several recommendations on strengthening and developing Mongolian Armed forces in the 21st century.

Mongolia is a full-fledged member, independent and sovereign state. As it is stated in the Constitution, Mongolia is entitled to have armed forces for self-defence. Since Mongolia is not a manufacturing nation of armament and destructive weapons, it is inevitable to purchase weapons from other countries to maintain its armed forces.

The article details some measures to provide Mongolia Armed Forces with necessary weapons, military equipment and ammunition without placing an extra burden on the country’s economy and state budget.

ОРШИЛ

XX зууны сүүлийн 20-иод жилийн нөхцөл байдал ямар байсныг өнөөдрийн Монгол орны ерөнхий төлөв байдалтай, ялангуяа эдийн засгийн бодит өсөлттэй харьцуулж дүгнэхэд, цэргийн шинэчлэл

хийх илүү таатай боломж бүрдсэн дүр зураг харагдаж байна.

Гэхдээ манай улсын эдийн засгийн өнөөгийн байдал, гадаадад буцааж төлөх хугацаа “хаяанд тулсан” өр зээлийн

асуудал энэ аядуу нөхцөлийг яах ч аргагүй хязгаарлаж байгааг хэн хүнгүй ойлгож буй.

Орчин үед, олон улсын жишигт нийцүүлсэн бүтэц, зохион байгуулалт хийж буй манай Зэвсэгт хүчний анги, байгууллагыг зориулалт, чиг үүрэг, байлдааны цагийн орон тоонд зохицсон зэвсэг, байлдааны болон хангалтын техникээр нөхөн хангах асуудлыг үнэхээр “тулгамдсан асуудал” гэж үзэхээс өөр аргагүй юм. Энд Монголын Зэвсэгт хүчин гэдэг нэр томъёог “Зэвсэгт хүчний тухай хууль”-д заасан тодорхойлолтын агуулгаар авч үзэж байгаа болно.

Зэвсэгт хүчний байгуулалтын тулгамдсан асуудлын хүрээнд зэвсэглэл, байлдааны техникийн хангалтын талаар дараах зарим санаа бодлоо тус сэтгүүлээр дамжуулан уншигч, судлаач нарын сонорт хүргэхийг хичээв.

НЭГ. ЗЭВСЭГ, БАЙЛДААНЫ ТЕХНИКИЙГ ШИНЭЧЛЭХ ТУХАЙ

Зэвсэгт хүчний анги, салбарт нөхөн хангалт хийх зорилгоор шинэ хийц загварын байлдааны техник худалдаж авах зардалд батлан хамгаалахын нийт төсвийн 30 шахам хувийг зориулдаг байх хандлага дэлхий дахинаа ажиглагдаж байна. Гэхдээ орчин үеийн өндөр шаардлагад нийцсэн тактик-техникийн үзүүлэлт бүхий байлдааны ба байлдааны хангалтын техникээр Зэвсэгт хүчнээ хангаж байгаа улс орон тийм ч олон байдаггүй нь ойлгомжтой. Ийм стандарт гэмээр үзүүлэлтийн тухай Лондонгийн Стратеги судлалын хүрээлэнгээс санаа гаргасан байдаг.

Монгол Улсын хувьд, арабын ертөнц дэх хэт баян орнууд шиг зэвсэг, байлдааны техник үйлдвэрлэгч улс гүрний ижил төрлийн олон бүтээгдэхүүнийг нэг дор цуглуулан “үзүүлэх-шоу” хийлгэж байгаад сонжиж, харьцуулж үзээд худалдаж авах зарчмаар ажиллах боломжгүй гэдэг нь ойлгомжтой. Гэсэн ч тусгаар улсын нэг

чухал илэрхийлэл болсон өөрийн Зэвсэгт хүчинтэй, түүнээ орчин үеийн цэрэг, зэвсэгтэй болоход шаардагдах асар их зардлын багагүй хэсгийг ч болов бүрдүүлэх зарим боломж байгааг төр засагт болон нийгэмд сонордуулахад илүүдэхгүй.

Өнөөгийн байдлаар авч үзвэл, Зэвсэгт хүчний өмнө тулгамдаж буй энэ асуудлыг шийдвэрлэхээр багагүй хүчин зүтгэл гаргаж, зэвсэглэлийн хувьд шаардлагад нэлээд дөхүүлж хангалт хийсэн зарим анги, байгууллага манайд байдгийг бас дурдах ёстой.

Зэвсэг, байлдааны техникийг сольж шинэчлэхдээ, юуны өмнө Монгол орны байгаль, цаг уур, газар зүйн онцлогт зохицох чанар бүхий тийм зэвсэг техникийг сонгож авах явдал нэгдүгээрт тавигдах нь зүйн хэрэг. Үүний зэрэгцээ ямар төрлийн зэвсэг, байлдааны техникийг, аль анги байгууллагад нөхөн хангаснаар тэдгээрийг ямар зорилгод ашиглах асуудлыг урьдчилан бодож, төлөвлөж, харьцуулсан үнэлгээ дүгнэлт хийсний үндсэн дээр эцсийн шийдвэр гаргах ёстой байх. Иймд, орчин үед:

- Өргөн фронтоор, их цэргийн хүчээр байлдааны ажиллагаа явуулах үзэл баримтлал нэгэнт үеэ өнгөрөөж байгааг;
- Орчин үед байлдааны ажиллагааг, заавал зах нийлсэн байдлаас явуулдаг зэвсэгт тэмцэл, гэж үзэхээ больсоныг;
- Дээд технологи ашиглаж зохион бүтээсэн, нэн цэцгэй, ухаалаг зэвсэг техник шинээр буй болсоор байгааг;
- Терроризм гэдэг шинэ маягийн “мангас” хамаг улс, нийгмийг айлган цочроодог болсныг;
- Тэр тусмаа манай хоёр хөрш улсын, манайхтай хил залгаа нутагт

дэвсгэрт тодорхой террорист бүлэг, ил далд байдлаар оршсоор байгааг;

- Мөнгөтэй л бол шинэ зэвсэг, техникийг хаанаас ч гэсэн худалдан авах боломжтой болжээ, гэдэг байр суурийг даяаршиж буй дэлхийн нийгэмлэг ойлгож байна.

Энэ бүгдийг анхаарч тооцвол, Монгол эх орны эрс тэс цаг агаар, хүрээлэн буй хахир хатуу орчинд төвөг багатай ашиглаж хэрэглэж болохуйц, дээр хэлсэн олон шинэ нөхцөл байдалд нийцсэн зэвсэг техник амархан олдоно гэвэл бас ташаа ойлголт болохыг сайтар тунгаан тооцох шаардлагатай юм.

Түүнээс гадна Зэвсэгт хүчний байгуулалтын асуудлын чухал бүрэлдэхүүн болсон “зэвсэг, техникийн хангалтын асуудал”-ыг хөндөхдөө аль анги, салбарыг ямар бүтэцтэй, ямар чиг үүрэгтэй байлгах талаар ҮАБЗ, төрийн захиргааны төв байгууллага, цэргийн мэргэжлийн дээд удирдлага сайтар бодож, цэгнэн хэлэлцэх асуудал зайлшгүй тулгарна.

Зэвсэгт хүчний өмнө тавигдах үүрэгт нийцсэн зэвсэг, байлдааны техниктэй болох асуудлыг, нэг талаас харж, өрөөсгөл шийдвэр гаргахгүйн тулд даяаршиж байгаа дэлхийд энд тэндгүй болж буй зэвсэгт мөргөлдөөн, террорист халдлага гэх зэрэг үйл явдлыг дүгнэж, задлан шинжилж, “шалтгаан-үр дагаврын” холбоог тодруулж байж сонголтоо хийх нь зүйтэй юм.

Түүнчлэн цэргийн мэргэжлийн байгууллага, байлдааны ажиллагаанд биечлэн оролцох хүч бүрэлдэхүүн гэдэг байр сууринаас авч үзвэл ямар зэвсэг, техниктэй, ямар “эсрэг тал”-тай учрах тохиолдол тулгарч болзошгүйг бас тооцож сонголтоо хийх хэрэгтэй болно.

Байлдааны ажиллагаа, эсвэл зэвсэгт мөргөлдөөн, хилийн будлиан, террорист бүлгийн болзошгүй халдлага гэх мэт

ажиллагааны аль нь ч байлаа гэсэн манай зэвсэг, байлдааны техникийн хүчин чадал “нөгөө талынхаас” дутуу, доогуур байж болохгүй, гэдэг зарчмыг, нэгэнт “аксиом” гэж үзэж цаашид хатуу баримтлах ёстой. Тухайлбал, израилийн үйлдвэрийн, gem.223 сумаар бууддаг “Галил” автомат, оросын үйлдвэрийн сургалт-байлдааны Як-130 онгоц, хятадын цоо шинэ загварын J-9 нисдэг тэрэг зэрэг зэвсэглэл дээр дурдсан зарчимд нийцэж байгаа учраас манай цэргийн мэргэжилтнүүд аливаа сонголт хийхдээ тооцно гэдэгт итгэлтэй байна.

Дээр нь зэвсэглэсэн жижиг бүлэг, террорист үйлдэл хийхийг мөрөөдсөн хэсэг этгээдийн эсрэг тэмцэхэд, мөн хилийн будлиан, мөргөлдөөний үед ч гэсэн дизель хөдөлгүүртэй, туулац сайжруулсан хийц бүхий дугуйт хуягт тээвэрлэгч, “олон үүргийн” байлдааны нисдэг тэрэг зэргийг илүү оновчтой зэвсэг, техник гэж үзэх чиглэл давамгайлах хандлагатай болжээ.

ХОЁР. ЗЭВСЭГ, ТЕХНИК ХУДАЛДАЖ АВАХ, ЭДИЙН ЗАСГИЙН БОЛОМЖИЙГ ХЭРХЭН ТООЦОХ ТУХАЙ

XXI зууны Монгол Улс, Зэвсэгт хүчнээ зэвсэг, байлдааны техникээр хангах асуудал дээр “хандивын” эсвэл “буцалтгүй тусламжийн” гэсэн ойлголтыг бүрмөсөн орхих учиртай, гэж хэлэх нь зүйтэй.

Өнөөгөөс 20 гаруй жилийн өмнөхийг бодвол манай улсын эдийн засгийн чадавх дээшилсэн, “валютын нөөц” багагүй нэмэгдсэнийг анхаарч үзвэл тэр нь зэвсэгт хүчний шинэчлэлд дэм болох “эерэг” хүчин зүйл мөн. Тийм болохоор орчин үеийн хийц загварын зэвсэг, байлдааны техникээр хангалт хийх харьцангуй таатай нөхцөл бүрдэхэд бас нэг алхам ойртуулж байна.

Бас шинэ зэвсэг, техник яг худалдаад авах дээрээ тулахаар шилжүүлэг хийчих мөнгө валют байхгүй ч юм шиг. Үүнийг

шинжлэх ухааны нэр томъёогоор илэрхийлбэл энэ асуудалд аль хэднээ “энтропия” байдал үүсчээ гэлтэй.

Тэгвэл бодит байдал бас арай өөр бөгөөд гадаад, дотоодгүй л Монголын эдийн засгийн чадавх нэмэгдэж байгаа тухай “ил тод” шуугих болсон. Тэр ч байтугай “World Ultra Wealth Report”¹ гэдэг цахим хуудсанд Төв Азийн орнуудын хэт баян хүмүүсийн талаар хийсэн судалгааг дэлхий дахинаа тайлагнасан мэдээ байдаг.

Энэ судалгаанд 30 сая ам.доллараас дээш хөрөнгөтэй хүмүүсийн тухай, тэдний нийт хөрөнгийн хэмжээг тооцсон, үзүүлсэн мэдээ байдаг. Үүнд, монголын ийм баячуудын тоо 40 хол давсан бөгөөд нийт хөрөнгө нь зургаан тэрбум гаруй ам.доллар болохыг дурджээ.

Энэ бол үнэн тоо баримт гэж итгэхэд хэцүү ч байж магадгүй. Хэрэв энэ үнэн бол тэднийг мэдээж хэрэг монгол орны байгалийн, ард түмний өмч болох асар их баялгийг хулгайлж гадаадад худалдаж гаршсан авилгач нар, бас “лиценз эзэмших эрх” гэгчээр халхавчилж төрийн өмчийг хувьдаа завшиж булхайгаар баяжсан хүмүүс, төрөөс төрсөн “тэрбумтан” нарыг хэлжээ, гэж ойлгож болно.

Тийм ч учраас Монгол Улсын шинэ Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч саяхан холбогдох байгууллагад үүрэг өгч, “офшорт нуусан” их хөрөнгийн асуудлыг 49 хоногийг дотор шийдэхийг даалгасан.

Тэгвэл, хэт баяжигч нарын гадаадын банкинд нуусан үлэмж их валютыг “төрийн төмөр нүүрээр” хурааж, Монголд аваад ирэх юм бол зэвсэг, техникийн шинэчлэлийн салбарт асар их хөрөнгө оруулалт хийх эх үүсвэр аяндаа олдох болно. Зэвсэгт хүчний хэрэгцээнд дутагдаад байгаа өчнөөн олон зүйлийг ч гаднаас худалдаж авах төсөв

¹ <https://www.wealthx.com/report/the-wealth-x-world-ultra-wealth-report-2013/>

мөнгийг, эндээс “босгоод авч” болох нь тодорхой.

Гэхдээ ийм асуудал биеллээ олох боломж гарсан тохиолдолд 1932 оны нугалаа, 1937-39 оны хэлмэгдүүлэлт шиг, хазгай алхам хийж яавч таарахгүй гэдгийг бас нэмж хэлбэл зохино.

Дээр хэлснээс гадна авлига, хахуулийн “салбарт” эргэлдэж байгаа их хөрөнгийг, жишээлбэл, Үндэсний татварын ерөнхий газрын дарга нарын зувчуулсан 17 тэрбум, “Анод” банкаар дамжуулж будлиулсан 14 тэрбум төгрөг зэрэг мөнгөөр нэлээдгүй тооны шинэ хийцийн зэвсэг, техник худалдаад авч болох байсан юмдаг.

Монголын төр, ҮАБЗ, засгийн газраас ийм асуудал дээр зоригтой, тодорхой шийдвэр гаргах аваас, Зэвсэгт хүчний хувьд хөрөнгийн шинэ эх үүсвэртэй болж “Зэвсэгт хүчний хөгжлийн сан” гэдэг, хувийн данснаас ялгаагүй шахам болчихоод байгаа багаахан хөрөнгөтэй харьцуулахад хавьгүй өргөн боломж нээгдэх бөгөөд зэвсэг, байлдааны техникийн дэвшилд хүрэх нэг нөхцөл болно, гэхэд хилсдэхгүй биз ээ. Эдгээрт үндэслэж хэлэхэд, Монгол Улс өөрийгөө хамгаалах Зэвсэгт хүчнээ чадварлаг байлгахын тулд хэрэгцээтэй зэвсэг, байлдааны техникээр нөхөн хангахын тулд аль бололцоотой арга замыг олж хэрэгжүүлнэ гэдэг нь ойлгомжтой.

ГУРАВ. ШИНЭ МАРКИЙН, ОРЧИН ҮЕИЙН ЗЭВСЭГ, ТЕХНИК АВЧ ХАНГАЛТ ХИЙХ ХҮРТЭЛХ ҮЕ ШАТ, ХЭСЭГ ХУГАЦААНД ЯАХ ВЭ? ГЭДЭГ ТУХАЙД

Шинэ хийц загварын зэвсэг, байлдааны техникийн тухайд гэвэл бид аль орчин үеийн гэх бүхний хойноос ухаангүй хөөцөлдөж болохгүй. Тэгэхээр, одоо байгаагаа үргэлжлүүлж сайн эзэмшиж хэрэглэлэг байхаас өөр замгүй. Ингэж ашиглахад бас учир бий. Үүнийг жаахан дэлгэрүүлбэ.

Зэвсэгт хүчний анги, салбарын тайван ба байлдааны цагийн оронд байгаа, бидний ашиглаж, хэрэглэсээр ирсэн зэвсэг, техникийг “ад үзэх” арай болоогүй. Хэрэв тэгвэл, “уулын буга хараад, унасан бухаа голох” гэгчийн үлгэрийг давтах учраас, эдүгээ бидэнд байгаа зэвсэг, байлдааны болон хангалтын техник тус бүрийн, тактик-техникийн үзүүлэлтийг ёстой л “чинээнд нь тулгаж” ашиглах зорилго, өнөөдөр ч хүчин төгөлдөр хэвээр байгаа, гэж үзэх ёстой.

Энэ бол БХЯ-наас баримтлах цэрэг-техникийн бодлогын нэг зорилттой уялдаж байгаа асуудал мөн болно. Одоо гоочлогдож байгаа тэр зэвсэг техник бол тухайн үедээ дэлхийн түвшинд тэргүүний гэж тооцогдож байсан, сайн технологийн үр дүнд бүтээсэн техник мөн билээ.

Цэргийн техникийн үйлдвэрлэл өндөр хөгжсөн орнуудын зэвсэглэлийг хооронд нь болон манайхтай харьцуулбал олонх загвар нь мэдээж хэрэг, тодорхой хоцрогдолд орсон. Гэхдээ, эдгээр зэвсэг, байлдааны техникийг өнөө үед манай дайчид аль хэр бүрэн эзэмшиж, “баруун солгойгүй” ашиглаж чадаж байна вэ? гэхээр, тийм ч ам бардам хэлэх үггүй болчих мухардал бас байгаа.

Энд зэвсэг техникийн шинэчлэл гэдэг тэр нүсэр асуудлыг шийдэхийн өмнө, тэр шинэ зүйлийг чинь мэддэг, ашиглаж чаддаг бие бүрэлдэхүүнээ, мэргэжилтнээ эхлэж бэлтгэсэн байхын чухлыг онцлох гээд байгаа юм. Эс тэгвэл ямар ч шинэ хийц загварын, автомат ажиллагаатай, компьютержсэн зэвсэг, байлдааны техниктэй боллоо гэхэд үр өгөөж ямар байх тал дээр хэлэхдээ хэнбугай ч гэсэн түгдрэх байх аа.

Зэвсэг, техникээ үнэхээр гаргуун мэддэг, “нүдээ аниад” ч хэрэглэж чаддаг мэргэжилтнийг бэлтгэх асуудлыг өндөр түвшинд гаргаж тавих хэрэгтэй, түүнд

шинэ төрлийн зэвсэг, техник худалдаад авахаас ч дутахгүй ач холбогдол өгөх ёстой болно.

Ганцхан бодитой жишээ дурдахад, өнгөрөгч зууны 70-аад оны үед Монголын төр, засаг, манай олон залуусыг ЗХУ-д цэргийн янз бүрийн сургуульд явуулж сургаад, төгсч ирэхийн үест нь буюу зэвсэг техникийн өндөр зэрэглэлийн мэргэжилтэн болж бэлтгэгдээд ирэх тэр цаг хугацаанд нь уялдуулж байгаад чухам тийм төрөл загварын зэвсэг, техникийн шинэчлэл хийж байсан холч ухааныг бахдаж хэлэх хэрэгтэй юм.

Монгол түмэн нэг үеэ бодвол, орчин үеийн дээд технологийн хийц загварын, ахуйн болон үйлдвэрийн зориулалттай шинэ техникийг ашиглаж сурч байна. Жишээлбэл, дижитал фотоаппарат, видеокамераас эхлээд германд, японд үйлдвэрлэсэн электрон багажаар “дүүргэсэн” автомашин, Европ, Азийн тэргүүний хөгжилтэй улс орнуудад үйлдвэрлэсэн уул уурхайн ба зам гүүрийн зориулалттай, өндөр үр ашигтай тоног төхөөрөмж болон хамгийн сүүлийн үеийн загварын компьютерыг хүртлэх олон төрлийн хэрэгслийг дурдаж болох байна.

Гэхдээ, инновацид суурилсан энэ бүх технологийг унтаад сэрэхдээ сурчихсан байна гэвэл ёстой л “сэрүүн зүүдлэсэн” хоосон мөрөөдөл болно.

Иймээс хүнээ, боловсон хүчнийг, мэргэжилтнийг бэлтгэх асуудлын ач холбогдлыг ийнхүү өндөрт өргөх шаардлага аяндаа урган гарч байгаа юм. Дээр өгүүлсэн жишээ бол ийм чухал, стратегийн шинж чанартай хоёр асуудлыг хослуулан цогцолбороор шийдэж чадсан байдгийг түүх бэлхэнээ гэрчилсний нотолгоо юм.

Өнөөдөр Зэвсэгт хүчний өмнө тулгараад буй “шинэ юм авмаар байдаг, авья, гэхээр нэг л болж өгөхгүй байгаа” таагүй, бас хүсээд баймааргүй тэр нөхцөл

байдалд бид амгалан суугаад байх аргагүйн улмаас чухам юу хийвэл оновчтой болохыг төсөөлж зарим санал хэлье.

Юуны өмнө хуучирсан ч гэсэн өөрт байгаа зэвсэг, техникээ арван хуруу шигээ мэддэг, ашиглаж чаддаг болгоход одоо анги, салбарт ажиллаж байгаа боловсон хүчнийг буюу өнөө үед ярьдаг болсноор хэлбэл, “хүний нөөцийг” сайтар бэлтгэх хэрэгтэй юм. Анги салбарыг техникийн мэргэжлийн бие бүрэлдэхүүнээр бүрэн хангах, тэднийг бүхий л талаар, тухайлбал, цалин мөнгөөр дэмжиж цэргийн байгууллагад татаж ажиллуулах шаардлагатай байна.

Техник дээр биечлэн ажиллаж, гардаж юм хийж үзээгүй хүн, хэнбугай ч байсан ялгаагүй, тэр авахсан гээд байгаа шинэ зэвсэг, техникийг мэдэж, шууд ашиглаж чадна гэвэл мөн ч “холын зөгнөл” болно. Тэр тусмаа зэвсэг байлдааны техник үйлдвэрлэдэггүй, сэлбэг хэрэгслийг нь ч хийдэггүй манай орны нөхцөлд техникийн асуудлыг дагнаж хариуцсан, захирагчийн нэрийн өмнөөс үүрэг тушаал өгөх эрх бүхий хэн нэгэн албан тушаалтан анги, байгууллагад байх ёстой гэдэг бол “маргашгүй үнэн” юм.

Зэвсэгт хүчний хангалтанд, ойрын ирээдүйд худалдаад авч болзошгүй гэж үзэж байгаа тэр л шинэ хийц загварын, магадгүй гурав-тавдугаар үеийн зэвсэг, техникийг ашиглаж чадах, эв дүйгээ олсон бие бүрэлдэхүүнийг дотооддоо одооноос бэлтгэж байх асуудал тулгамдаж байгаа билээ. Өөрөөр хэлбэл, техникийн ашиглалтыг онолын, дадлагын өндөр төвшинд зохион байгуулж удирдаж чадахуйц тийм мэргэжилтэн нэн хэрэгтэй байна гэдэг нь сүүлийн 20-иод жилийн байдлаас тодорхой харагдах боллоо.

Юуны өмнө, техникийн ашиглалт гэдэг ерөнхий ойлголтын дотроос “хадгалалт” гэдэг хэсгийг онцгойлон авч үзээд энэ асуудалтай “тулж ажиллах” явдал монголын нөхцөлд маш чухал арга хэмжээ болоод байна.

Гагцхүү ямар нэгэн техникийг утга учиргүй “хав дарж” хадгалах биш, шалгаж, арчилж, бас судалж “хадгалдаг” арга зарчим хэрэгжих ёстой цаг үе нэгэнт иржээ. Тиймээс олон зориулалтын буюу үйлдвэрлэл, барилга байгуулалтын ажилд хэрэглэх боломжтой зарим техникийг өнөө үед эргэлтэнд оруулж “эдэлж, хэрэглэж” байх асуудал цаг үеэ олсон алхам болно.

Хадгалалтыг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулж хэрэгжүүлэх талаар манай эрдэмтэд, судлаачид чамлахааргүй бүтээл зохиол тууригсан байдаг. Тэгвэл өнөө үеийн залуу офицер, ахлагч нарыг хуучин зэвсэг техник дээр “шинээр дахиж сургах” асуудлыг, шинэ хийц загварын зэвсэг, байлдааны техникийг цөөн тоогоор авч суралцах, гаршуулах арга хэмжээтэй хослуулсан байдлаар зохион байгуулах явдал зүйн хэрэг болж, тэр ч байтугай он жилийг дамнасан зорилт, үйл хэрэг болохоор байна.

Цэргийн инженерийн зориулалтаар байлдааны ажиллагаанд ашиглаж болохуйц уул уурхай, зам барилгын төрөл маркийн, өндөр хүчин чадалтай орчин үеийн янз бүрийн техникийг зөвхөн анги салбарын нөхөн хангалтанд авч хадгалаад байх бус, судлаж мэдээд хэрэглэхдээ бодитой үр өгөөжтэй байх арга хэмжээнд буюу бүтээн байгуулалтын ажилд ашиглах шаардлага гарч ирж байна.

ЗОХИОГЧИД**А.Түвшинтөгс**

ССХ-ийн Нийгэм, төрийн судалгааны
секторын эрхлэгч

Н.Соёлгэрэл

ССХ-ийн Эрдэм шинжилгээний
ажилтан

Ч.Нарантуяа

ССХ-ийн Эрдэм шинжилгээний
ажилтан

Д.Уламбаяр

ХИС-ийн Олон улсын харилцаа, нийгэм
судлалын сургуулийн захирал

Л.Бямбаханд

ССХ-ийн Эрдэм шинжилгээний
ажилтан

М.Эрдэнэбаяр

ССХ-ийн Эрдэм шинжилгээний
ажилтан

Х.Номинболор

ССХ-ийн Эрдэм шинжилгээний
ажилтан

Э.Энхмаа

ССХ-ийн Эрдэм шинжилгээний
мэргэжилтэн

Ж.Батсуурь

ССХ-ийн Эрдэм шинжилгээний
мэргэжилтэн

С.Алтанчимэг

ССХ-ийн Эрдэм шинжилгээний
мэргэжилтэн

Б.Эрдэнэбат

ССХ-ийн зөвлөх

AUTHORS**A.Tuvshintugs (Ph.D)**

Head of Department of Social and State
studies

N.Soyolgerel (M.A)

Senior researcher of the Institute for Strategic
Studies

Ch.Narantuya (M.A)

Senior researcher of the Institute for Strategic
Studies

D.Ulambayar (Ph.D, Professor)

Director, School of International relations and
social studies, University of Humanities

L.Byambakhand (M.A)

Senior researcher of the Institute for Strategic
Studies

M.Erdenebayar (Ph.D)

Senior researcher of the Institute for Strategic
Studies

Kh.Nominbolor (M.E)

Senior researcher of the Institute for Strategic
Studies

E.Enkhmaa (Ph.D)

Researcher of the Institute for Strategic
Studies

J.Batsuuri (Sc.D)

Researcher of the Institute for Strategic
Studies

S.Altanchimeg (M.A)

Researcher of the Institute for Strategic
Studies

B.Erdenebat

Advisor, the Institute for Strategic Studies